МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.09.05 № ХЭГ/1628

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.МӨНХБАЯСГАЛАН ТАНАА

Асуултын хариу хүргүүлэх тухай

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг "Эрдэнэс Монгол" ХХК-аас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт 1л хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ

000245017063

118

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК

Эрдэнэс Монгол ХХК-ийн байр, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 7555 3399,
Цахим шуудан: info@erdenesmongol.mn,
Цахим хуудас: www.erdenesmongol.mn

2024.09.03 № 01/866

танай 2024.08.23-ны № хэг/1548 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалангийн асуултад "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн бэлтгэж ирүүлсэн мэдээллийг үндэслэн хариултын товч төслийг бэлтгэн Танд танилцуулж байна.

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК-аас асуултын дагуу бэлтгэн 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 01/576, 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 01/585 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав.

Хавсралт 325 хуудастай.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.НАРАНЦОГТ

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
S124913 НД2999

1424062155

119

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2024 оны 09 дүгээр сарын 03 - ны өдрийн 01/866 дугаар албан бичгийн хавсралт

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХӨРЭНГӨЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР УИХ-ЫН ГИШҮҮН Л.МӨНХБАЯГАЛАНГИЙН МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛТЫН ХАРИУ

1. **Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн ажлын гүйцэтгэлийн явцын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;**

Хүснэгт 1: Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явц

Багц ажил	Барилга байгууламж	Гүйцэтгэл	Ажлын явц
EPC 1	Технологийн бус барилга байгууламж: Угтах байр, эмнэлэг, хоолны газар, оффис сургалтын төв, агуулах, лаборатори, цэвэр усны систем, гал унтраах анги, засварын цех зэрэг	99%	Барилга байгууламжуудыг шат дараатайгаар Улсын комисст хүлээлгэн өгч байна.
EPC 2	Анхдагч процессын болон дагалдах байгууламжууд: Энгийн нэрлэгийн байгууламж, вакум нэрлэгийн байгууламж, хий ялгах байгууламж, завсрын болон бэлэн бүтээгдэхүүний сав, шингэрүүлсэн шатамхай хий хадгалах сав, бүтээгдэхүүний ачих буулгах байгууламж, шугам хоолойн тулгуурууд	17%	32 ширхэг түүхий эд, завсрын болон эцсийн бүтээгдэхүүн агуулах сав резервуар, хяналтын өрөө, дэд станцууд, шугам хоолойн эстакадын барилга угсралтын ажил хийгдэж байна.
EPC 3	Үйлдвэрийн цахилгаан станц	14%	Цахилгаан дэд станц, технологийн хяналтын барилгууд, шугам хоолойн эстакадыг байгуулах ажил хийгдэж байна.
EPC 4	Гүн боловсруулалтын лицензтэй технологийн байгууламжууд	8%	-

Эх сурвалж: МГТБҮ ХХК-ийн 2024.09.02-ны өдөр 01/576 албан бичиг, гүйцэтгэлийн мэдээлэл

Төслийн бүтээн байгуулалтын гүйцэтгэлээс харахад зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд баригдах үйлдвэрийн бүтээн байгуулалт удаашралтай явагдаж байна.

2. **Тус төслийн хүрээнд Улсын төсөвт болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжилт олгож эхэлсэн болон зогссон хугацаа, олгосон санхүүжилтийн нийт дүн, түүний зарцуулалтын талаарх мэдээлэл;**

Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 2 дугаар тогтоолоор "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн хэрэгжүүлж буй Газрын тос боловсруулах үйлдвэр төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр шийдвэрлэхээр болсон. Хөгжлийн банк 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 250 тэрбум хүртэлх зээлийн шугам нээн МГТБҮ ХХК-тай зээлийн гэрээ байгуулж анхны санхүүжилтийг 2018 оны 04 сарын 26-ны өдөр олгосон. Зээлийн санхүүжилт олгосноос хойш зээлийн хэмжээ барьцаа хөрөнгийн үнэлгээний хязгаарт тулсан шалтгаанаар Хөгжлийн банкнаас зээл олголтыг 2022 оны 11 сарын 29-ны өдөр зогсоосон. Харин 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн барьцаа хөрөнгийн үнэлгээний хэмжээг 5.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр дахин зээл олгож эхэлсэн. Засгийн газрын хариуцах үйлдвэрийн бус дэд

бүтэц, үйл ажиллагааны зардлуудыг Хөгжлийн банкны өндөр хүүтэй зээлийн санхүүжилтээр шийдвэрлэсэн нь төслийн хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлж байна.

Хүснэгт 2: Хөгжлийн банкнаас олгосон зээлийн хэмжээ

№	Дэд бүтэц	Гэрээний дүн /сая.төг/	Гүйцэтгэгч	Гүйцэтгэл	
				Дүн /сая.төг/	Хувь
1	Төмөр зам	67,125.0	УБТЗ ХНН	67,125.0	100%
2	Хүнд даацын автомашины зам	32,147.4	БХЯ	32,147.4	100%
3	ЦДАШ, дэд станц	5,377.5	ЦДҮС ТӨХК	5,377.5	100%
4	550 ажиллагсдын хотхоны бүтээн байгуулалт	69,141.1	БХЯ, Хангай бигэр ХХК, ТОБЭМ ХХК	42,221.2	61%
5	Үйлдвэрийн талбай бэлдэх	6,705.1	БХБЯ, Нутгийн зам групп ХХК	6,705.1	100%
6	Компанийн үйл ажиллагаа, зөвлөх үйлчилгээ			21,488.2	
Дүн					**175,064.4**
Нийт зээлийн хуримтлагдсан хүү					**98,487.8**

Эх сурвалж: МГТБҮ ХХК-ийн 2024.09.02-ны өдөр 01/576 албан бичиг

3. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас авсан зээл, үүнтэй холбоотойгоор байгуулсан гэрээнүүд, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтүүд болон зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээлэл;

БНЭУ-ын Экспорт-Импортын банк, МУЗГ хооронд 2016.04.28-ны өдөр 1.0 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийг байгуулсан. НТЭЗҮ-ээр төслийн төсөвт өртөг 1,236.0 сая ам.доллар болсон тул зээлийн хэмжээг нэмэгдүүлж 236.0 сая ам.долларын нэмэлт зээлийн хэлэлцээрийг 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан.

Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд нийт 992.2 сая ам.долларын гэрээг байгуулсан бөгөөд гэрээний санхүүжилт 256.9 сая ам.доллар байна.

Хүснэгт 3: *БНЭУ-ын ЗГ-аас авсан зээлийн хүрээнд байгуулсан гэрээ, нэмэлт, өөрчлөлт*

№	Гэрээний нэр	Гүйцэтгэгч	Гэрээний үнийн дүн (ам.доллар)	Санхүүжилт ийн дүн (ам.доллар)	Нэмэлт, өөрчлөлт
1	НТЭЗҮ боловсруулах ажлын гэрээ	Инженерс Индиа Лимитед	1,450,000	1,450,000	Байхгүй
2	Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ	Инженерс Индиа Лимитед	73,300,433	47,454,411	№1: 2019.09.26 №2: 2021.03.10 №3: 2023.04.12
3	EPC 01	JMC Projects India	97,800,000	92,591,947	№1: 2020.11.19 №2: 2023.04.03 №3: 2023.08.23 №4: 2023.11.28
4	EPC 02	Мега Инженеринг Энд Инфрастрактур лимитед компани	598,900,000	73,431,430	№1: 2023.01.25 №2: 2023.08.30 №3: 2023.09.28
5	EPC 03	Мега Инженеринг Энд Инфрастрактур лимитед компани	189,720,000	22,282,829	№1: 2023.01.25 №2: 2023.08.30 №3: 2023.09.28
6	Лиценз зээмшигчдийн төлбөр (нийт 7 гэрээ)		31,002,000	19,767,120	байхгүй
Дүн			**992,172,433**	**256,977,737**	

Эх сурвалж: МГТБҮ ХХК-ийн 2024.09.02-ны өдөр 01/576 албан бичиг

121

4. Газрын тос боловсруулах үйлдвэр төслийн хүрээнд хийгдэж буй дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар

❖ Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалт

Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангахад зориулагдсан 530 км урт дамжуулах хоолойг Засгийн газрын 2022 оны 94 дүгээр тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас нүүрс урьдчилан борлуулсан орлогын эх үүсвэрээр гүйцэтгэхээр шийдвэрлэн санхүүжүүлж байгаа бөгөөд төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Norinco International Cooperation" компани ажиллаж байна. Төсөл 65%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

❖ Үйлдвэрийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалт

Засгийн газрын 2018 оны 21 дүгээр тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт болох Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр чиглэлийн төмөр зам, хүнд даацын тусгай зориулалтын авто зам, цахилгаан дамжуулах сүлжээ зэргийг холбогдох төрийн өмчит компаниудаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг Хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгэсэн. Мөн үйлдвэрийн хашаа барих, талбайн тэгшилгээний ажлыг Хөгжлийн банкны санхүүжилтээр шийдвэрлэж хийж гүйцэтгэсэн.

5. Төслийн хүрээнд ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч гадаад болон дотоодын компаниуд тус бүрийн хариуцсан ажлын үнийн дүн, ажлын гүйцэтгэлийн явцын болон хийсэн ажлын тайлан, тэдгээрийн сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

❖ Төслийн менежментийн зөвлөх сонгон шалгаруулалтаар зөвхөн "Инженерс Индиа Лимитед" компани санал ирүүлсэн тул Энэтхэгийн ГХЯ энэхүү компанийг томилж, 2019 оны 5-р сард гэрээ байгуулсан.

❖ EPC 01 багц ажлын ерөнхий гүйцэтгэгчээр БНЭУ-ын "JMC Projects India" компани шалгарч 97.8 сая ам.долларын гэрээг байгуулсан.

❖ EPC 02 багц ажлын ерөнхий гүйцэтгэгчээр БНЭУ-ын "Megha Engineering & Infrastructure Limited" компани шалгарч 598.9 сая ам.долларын гэрээг байгуулсан.

❖ EPC 03 багц ажлын ерөнхий гүйцэтгэгчээр БНЭУ-ын "Megha Engineering & Infrastructure Limited" компани шалгарч 189.7 сая ам.долларын гэрээг байгуулсан.

❖ EPC 04 багц эхний хэсгийн гэрээг "Megha Engineering & Infrastructure Limited" компанитай 212 сая ам.долларын гэрээ 2023 оны 9-р сард байгуулсан. Үлдсэн хэсгийн гэрээг зээлийн нэмэлт эх үүсвэр шийдвэрлэгдсэний дараа байгуулахаар байна.

❖ Газрын тос дамжуулах хоолой төслийн ерөнхий гүйцэтгэгчээр "Norinco International Cooperation" компани шалгарч 397 сая ам.долларын гэрээг 2022 оны 4-р сард байгуулсан.

❖ Газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг Засгийн газрын 2018 оны 21 дүгээр тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдээс сонгон хэрэгжүүлэхийг холбогдох яамдын сайд нарт даалгасан байна.

Хүснэгт 4: Лиценз эзэмшигчтэй байгуулсан гэрээ, санхүүжилтийн хэмжээ

№	Лицензтэй байгууламжууд	Гүйцэтгэгч	Үнийн дүн (ам.доллар)	Ажлын явц
1	Устөрөгч үйлдвэрлэх байгууламж (HGU)	БНИУ-ын "Kinetics Technology"	3,815,562	Байгууламж тус бүрийн лиценз эзэмшигчид зураг төслөө (Basic design engineering package) боловсруулж, төсөл хэрэгжүүлэгчид хүлээлгэн өгсөн.
2	Хүхэр ялгах байгууламж (SRU)	БНФУ-ын "Axens"	1,998,000	
3	Висбрекинг байгууламж (VBU)	НХУ-ын "Shell"	4,775,000	
4	Шингэрүүлсэн шатдаг хийн цэвэрлэгээний байгууламж (LPGTU)	АНУ-ын "Honeywell UOP"	1,810,000	
5	Бензин боловсруулах байгууламж (MS Block)		3,796,897	
6	Гидрокрекинг гүн боловсруулалтын байгууламж (Full conversion HCU)		8,178,270	
7	Дизелийн гидро цэвэрлэгээний байгууламж (DHTU)		6,628,270	
Дүн			**31,002,000**	

Эх сурвалж: МГТБҮ ХХК-ийн 2024.09.02-ны өдөр 01/576 албан бичиг

Хүснэгт 5: Дотоодын компаниудын гүйцэтгэсэн ажил, санхүүжилтийн хэмжээ

№	Ажлын нэр	Гүйцэтгэгч	Үнийн дүн (сая төгрөг)	Ажлын явц
1	Салбар төмөр замын ТЭЗС, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээ	"Улаанбаатар төмөр зам" ХНН	70,582.0	100%
2	Авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээ	Батлан хамгаалах яам	29,405.6	100%
3	Авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын нэмэлт гэрээ	Батлан хамгаалах яам	4,488.5	100%
4	Үйлдвэрийн талбайн тэгшилгээ, үйлдвэрийн хашаа, целжилтөөс сэргийлэх ойн зурвас байгуулах ажлын зураг төсөл боловсруулах, барьж байгуулах ажлын гэрээ	Барилга хот байгуулалтын яам	5,842.5	100%
5	110 кВ-ын ЦДАШ, Сайншанд дэд станцын өргөтгөл, 110/10 кВ-ын дэд станцын зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээ	ЦДҮС ТӨХК	5,489.7	100%
6	Салбар төмөр ба авто замын техник эдийн засгийн судалгаа болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барьж байгуулах ажилд техник технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ, Ай Си Ти-Сайн консалтинг ХХК	3,399.8	100%
7	Цахилгаан дамжуулах сүлжээ байгуулах ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах болон барьж байгуулах ажилд техник технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ	Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ	141.1	100%
Дүн			**119,349.2**	

Эх сурвалж: МГТБҮ ХХК-ийн 2024.09.02-ны өдөр 01/576 албан бичиг

6. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй мэдээлэл

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн 2021-2023 онд үйл ажиллагаанд нийт 43.6 тэрбум төгрөгийн зардал гарсан байна. Энэхүү зардлын дийлэнх хэсгийг зээлийн хүүгийн зардал (13.9 тэрбум төгрөг), цалин хөлсний зардал (8.7 тэрбум),

элэгдлийн зардал (10.7 тэрбум төгрөг) тус тус бүрдүүлж байгаа ба бусад үйл ажиллагаанд 10.3 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт 6: "МГТБҮ" ТӨХХК-ийн үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй мэдээлэл

№	ҮЗҮҮЛЭЛТ	2021 (мян.төг)	2022 (мян.төг)	2023 (мян.төг)	Нийт (мян.төг)
	Нийт зардал	**27,381,385**	**7,660,926**	**8,560,527**	**43,602,838**
1	***Ерөнхий ба удирдлагын зардал***	***27,381,385***	***7,598,695***	***7,585,347***	***42,565,427***
1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,626,121	2,939,818	2,774,901	8,340,840
1.2	Бараа, үйлчилгээний зардал	24,755,264	4,658,877	4,810,446	34,224,587
2	***Борлуулсан бүтээгдэхүүний өртөг***	-	***62,231***	***975,181***	***1,037,412***
2.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-	371,466	371,466
2.2	Бараа үйлчилгээний зардал	-	62,231	603,715	665,946
	НИЙТ ЗАРДАЛ	**27,381,385**	**7,660,926**	**8,560,527**	**43,602,838**

Эх сурвалж: МГТБҮ ХХК-ийн 2024.09.02-ны өдөр 01/576 албан бичиг

2023 оны байдлаар "МГТБҮ" ТӨХХК нийт 391 тэрбум төгрөгийн дансны өглөгтэй байна. Үүний 388 тэрбум төгрөгийн өглөг нь Түүхий тос дамжуулах хоолойн төслийн санхүүжилттэй холбоотой үүссэн өглөг байна.

7. Монгол Улсын 2020-2024 онд шатахуун зарцуулж буй мөнгөн дүн болон газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол

а) Монгол Улсын 2020-2024 онд шатахуунд зарцуулсан мөнгөн дүнгийн талаар:

Монгол улс 2020 оноос 2024 оны 07 сарыг хүртэл хугацаанд нийт 8.7 сая тонн газрын тосны бүтээгдэхүүнийг 6.2 тэрбум ам.долларoор импортлон худалдаж авсан байна.

Хүснэгт 7: Монгол Улсын импортолсон газрын тосны бүтээгдэхүүн (мянган тонн)

№	Барааны нэр төрөл	2020	2021	2022	2023	2024 07 сар	Нийт
1	Автобензин	586	573	681	730	507	**3,077**
2	Дизель түлш	1,027	989	982	1,347	938	**5,283**
3	Онгоцны түлш	19	27	74	110	62	**292**
4	Түлшний мазут	3	2	2	4	3	**14**
5	**Нийт**	**1,635**	**1,591**	**1,739**	**2,191**	**1,510**	**8,666**
6	*Өсөлтийн % (Өмнөх онтой харьцуулсан)*	*-2%*	*-3%*	*9%*	*26%*	-	-

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 8: Монгол Улсын импортолсон газрын тосны бүтээгдэхүүний өртөг (сая. $)

№	Барааны нэр төрөл	2020	2021	2022	2023	2024 07 сар	Нийт
1	Автобензин	245	391	561	522	365	**2,084**
2	Дизель түлш	432	590	960	1,110	766	**3,858**
3	Онгоцны түлш	12	17	71	93	55	**249**
4	Түлшний мазут	1	1	1	1	1	**6**
5	**Нийт**	**690**	**999**	**1,593**	**1,728**	**1,187**	**6,197**
6	*Өсөлтийн % (Өмнөх онтой харьцуулсан)*	*-33%*	*45%*	*59%*	*8%*	-	-

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

b) Төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол:

Газрын тос боловсруулах үйлдвэр жилд 1.7 тэрбум литр бүтээгдэхүүнийг борлуулж, 4.1 их наяд төгрөгийн орлого олж, 2.8 их наяд төгрөгийн зардал гарган, 951 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар тооцсон байна. Төслийн өнөөгийн цэвэр үнэ цэн нь 3.2 их наяд төгрөг, дотоод өгөөжийн хувь нь 16.61 хувь байх төсөөлөлтэй байна.

Хүснэгт 9: "ГТБУ"-ийн мөнгөн урсгалын тооцоолол

№	Үзүүлэлт	Үйлдвэрлэлийн хэмжээ (литр)	Үнэ (төг.)	Дүн (сая.төг)
1	Дизель түлш	1,004,878,000	2,592	2,604,731
2	АИ-95	467,586,000	2,182	1,020,341
3	Онгоцны түлш	102,564,000	2,679	274,812
4	Зуухны түлш	46,078,000	1,661	76,555
5	ШШХ	82,692,000	1,691	139,793
6	**Борлуулалтын орлого (1+ … +5)**	**1,703,798,000**		**4,116,233**
7	Түүхий тос	1,792,000	1,379	2,471,464
8	Түүхий тос олборлосон үнээр			-
9	Нэмэлт түүхий эд			247,146
10	Үйл ажиллагааны зардал			95,151
11	Дамжуулах хоолойн у/а зардал			35,423
12	**Нийт үйлдвэрлэлийн зардал (7+ … +11)**			**2,849,185**
13	**Татварын өмнөх ашиг (13=6-12)**			1,267,048
14	ААНОАТ (13*25%)			315,862
15	**Цэвэр ашиг (15=13-14)**			**951,186**
16	Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт - ГТБУ, Эксим банк			400,655
17	Зээлийн эргэн төлөлт - Дамжуулах хоолой			130,919
18	Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт - Хөгжлийн банк			213,139
19	**Нийт зээл, зээлийн хүүгийн зардал (16+ … +18)**			**744,713**
20	**Мөнгөн урсгалын үлдэгдэл (20=15-19)**			**206,473**
21	**Нэгж бүтээгдэхүүний өртөг (төг)**			**2,109**
22	Өнөөгийн цэвэр үнэ цэнэ			3,244,627
23	Дотоод өгөөжийн хувь			16.61%
24	Зээл эргэн төлөгдөх боломжит хугацаа (жилээр)			7.5

Эх сурвалж: МГТБУ-ийн 2024.09.02-ны өдөр 01/576 албан бичиг

8. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн үйл ажиллагаа болон санхүүд хийсэн дотоодын болон олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагын тайлан, дүгнэлтүүд;

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК-аас 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 01/576 албан тоотоор ирүүлсэн Үндэсний аудитын газрын 2023 болон 2024 онуудад хийсэн санхүүгийн аудитын тайланг хавсаргав. Олон улсын аудитын байгууллагын тайлан, дүгнэлт байхгүй болно.

9. Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар;

Төслийн хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулагдаагүй болно.

10. Төслийн хүрээнд бий болох ажлын байрны тоо, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д одоо ажиллаж буй нийт ажилчдын тоо, үүнээс газрын тосны үйлдвэрийн хотхонд орон сууцанд хамрагдан амьдарч буй ажилтнуудын тоон мэдээлэл;

❖ Газрын тос боловсруулах үйлдвэрт болон түүхий тос дамжуулах хоолойн инженерийн байгууламж цогц төсөлд 1000 орчим инженер, техникийн ажлын байр бий болно.

125

❖ "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн одоогийн ажилчдын тоо: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 17 дугаар тогтоолд орон тооны дээд хязгаар 150+1 хүн буюу компанийн бүтцэд 6 газар, 5 алба байхаар баталсан. Өнөөдрийн байдлаар компанид 98 хүн ажиллаж байна.

❖ Газрын тосны үйлдвэрийн хотхоны ашиглалтад орсон 40 айлын 1 орон сууцыг юун түрүүнд Улаанбаатар хотоос ээлжээр ажиллаж буй МГТБҮ ХХК-ийн инженер, мэргэжилтнүүд ашиглаж, өмнө гардаг байсан томилолтын зардлыг эрс бууруулсан. МГТБҮ ХХК-ийн Улаанбаатар хотоос орон нутагт очиж ажиллаж буй инженер техникийн ажилтнууд гэр бүлийн хамт тус орон сууцанд (4 байранд) амьдарч байна. Түүнээс гадна ГТБҮ байгуулах төслийн Менежментийн зөвлөх "Engineers India Limited" (10 байр), EPC 02 ба 03 багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгч "Megha Engineering & Infrastructures Limited" (21 байр), EPC 01-ийн ерөнхий гүйцэтгэгч JMC компанийн инженер (2 байр), зөвлөхүүдийг тус орон сууцанд байраар хангасан байна.

❖ 2024 оны байдлаар тус орон сууцаас 469,0 сая төгрөгийн түрээсийн орлого олох төлөвтэй байна.

Хүснэгт 10: Орон сууцны түрээсийн орлогын тооцоолол /сая.төгрөгөөр/

№	Орлогын утга	2024	2025*	2026*
1	Орон сууц хөлсөлсний орлого (21 байр)	365.4	365.4	365.4
2	Орон сууц хөлсөлсний орлого (2 байр)	33.6	33.6	33.6
3	Орон сууц хөлсөлсний орлого (тохижилтгүй)	70.0	420.0	420.0
	Нийт дүн	**469.0**	**819.0**	**819.0**

*2025,2026 оны орон сууцыг түрээслэх гэрээ байгуулаагүй байгаа тул 2024 оны жишгээр төсөөлөв.

Эх сурвалж: МГТБҮ ХХК-ийн 2024.09.03-ны өдөр 01/585 албан бичиг

11. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нь газрын тос хайх болон ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшдэг эсэх талаар мэдээлэл

Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай" хуулийн хүрээнд газрын тосны хайгуулын Давст-XXXI талбайг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК-д олгосон. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь тус талбайд газрын тос боловсруулах үйлдвэрийн EPC 2, 3, 4 дүгээр багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгч "Megha Engineering and Infrastructures Limited" компанитай хамтран газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар холбогдох байгууллагуудаас санал авч ажиллаж байна.

126

МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХК
900, Бодь цамхаг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол улс
Утас: +976 70100389
И-мэйл: info@mongolrefinery.mn

2024.09.02 № 01/576
танай 26/VIII -ны № 09/848

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН
ТӨСЛИЙН СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ
ГАЗРЫН АХЛАХ МЕНЕЖЕР
Б.БАТМӨНХ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Монгол улсад "Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл"-ийн хэрэгжилттэй холбоотой асуулаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг бэлтгэн, хавсралтаар хүргүүлж байна.

Асуултын 7 дахь хэсгийн "Монгол улс 2020-2024 онд шатахуунд зарцуулж буй мөнгөн дүн", 9 дэх хэсэгт дурдсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний талаарх мэдээлэл манай компанид хамаарахгүй тул уг асуудлуудаар хариулт бэлтгээгүй болно.

Хавсралт 209 хуудастай.


Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЦЭНДСҮРЭНГИЙН ЦАНЦЭЦЭГ

127

МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК

БНЭУ-ЫН ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР (ГТБҮ) БАРИХ ТӨСЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦ



Улаанбаатар хот
2024.08.30

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР (ГТБҮ) БАРИХ ТӨСЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦ

"Монгол улсад Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл"-ийн бүтээн байгуулалтыг технологийн барилга байгууламжуудын дэс дараалал, байгууламж тус бүрийн төвөгшил болон инженерчлэлийн ажилд зарцуулагдах хугацааг тооцсоны үндсэн дээр дараах 4 хэсэгт хуваан гүйцэтгэж байна. Үүнд:


EPC 01: Технологийн бус барилга байгууламж
EPC 02: Атмосферийн болон Вакуум нэрлэг, Ханасан хий ялгах байгууламж, дагалдах, туслах байгууламжууд
EPC 03: Үйлдвэрийн Дулааны цахилгаан станц
EPC 04: Лицензтэй технологийн байгууламжууд

(EPC - Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралт)

Үйлдвэрийн бүтээн байгуулалтын EPC 01, 02, 03 багц ажлууд, Газрын тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажлууд хэвийн үргэлжилж байгаа бөгөөд ерөнхий гүйцэтгэгч БНЭУ болон БНХАУ-ын компаниуд, тэдний туслан гүйцэтгэгч монголын компаниудын нийт 1700 гаруй хүн үйлдвэрийн талбайд ажиллаж байна.

EPC 01 багц ажлын талаар


Үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламж (EPC 01)-ийн ерөнхий гүйцэтгэгчээр Энэтхэгийн Kalpataru Projects International Limited (KPIL) компани шалгарч 2021 оноос бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд барилга угсралтын ажлын явц 99%-ийн гүйцэтгэлтэй байна.





EPC 01 багц ажлын хүрээнд Ерөнхий гүйцэтгэгч нь дараах технологийн бус барилга байгууламжийг барьж дууссан ба барилга байгууламжуудыг шат дараатайгаар Улсын комисст хүлээлгэн өгч байна.


№	Барилга байгууламж	Ажлын гүйцэтгэл, %
1	Захиргааны барилга	99
2	Лабораторийн барилга	99
3	Засварын цех	99
4	Агуулахын барилга	99
5	Гал командын барилга	99
6	Ажилчдын хоолны газрын барилга	100
7	Эмнэлгийн барилга	100
8	Усны нөөцийн сав	100
9	Ус дамжуулах хоолой (87 км)	99
10	Үйдвэрийн доторх автозамын ажил (12.5 км)	100
11	Өргөх станц болон 11 худгийн барилга	100
12	Үерийн ус зайлуулах сувгийн ажил (33 км)	100
13	Зам талбайн ус хураах талбай	100
14	Автозамын доорх ус дамжуулах хоолойн ажил	100
15	35 кВ, 10кВ ЦДАШ (86,5 км)	100
16	Тос баригч байгууламж	100
17	Нэвтрэх хаалга -1	100
18	Нэвтрэх хаалга -2	99


EPC 01 багц ажлын бүтээн байгуулалтын зураг











МГТБҮ ТӨХХК нь Ерөнхий гүйцэтгэгч Kalpataru Projects International Limited компани, Төслийн Менежментийн Зөвлөх Инженерс Индиа Лимитед компанитай хамтран EPC-01 багц ажлын хүрээнд баригдсан технологийн бус барилга байгууламжийг нийт VI хэсэгт хуваан Улсын комисст хүлээлгэн өгч байна.

- Хэсэг-I: Үйлдвэрийн талбайн дэд станцыг Бор Хөөврийн говь дахь ус хангамжийн эх үүсвэртэй холбосон 89 км урт 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, барилга угсралтын үеийн дэд станц
- Хэсэг-II: Эмнэлгийн анхан тусламжийн байр, ажиллагсдын хоолны газар, үйлдвэрт нэвтрэх байр-1
- Хэсэг-III: Өргөх насос станцын барилга, 11 худгийн барилга, өргөх насосны систем, 85 км түүхий ус дамжуулах хоолой
- Хэсэг- IV: Үйлдвэрийн талбай дахь авто зам, замын дэд бүтцийн байгууламж, гадаргын ус зайлуулах систем, сувагчлал, тос баригч байгууламж, үйлдвэрийн талбайн цахилгаан байгууламжууд
- Хэсэг-V: Гал командын байр, агуулахын барилга, лабораторийн барилга, засварын цех, үйлдвэрт нэвтрэх байр-2
- Хэсэг-VI: Захиргааны барилга, гадна талбайн тохижилт

Дээрх иргэний барилгууд болон дэд бүтцийн байгууламжууд ашиглалтад орж эхэлж байгаатай холбоотойгоор эдгээр өмчүүдийн ашиглалт, арчлалт, хамгаалалтын ажлыг зохион байгуулах, мөн цахилгаан, дулаан, ус ашиглалтын гэх мэт ашиглалтын зардлын асуудлыг шийдвэрлэх шаардлага гарч, уг асуудлыг төр засгийн байгууллагуудад танилцуулж, шийдвэрлүүлж байна.

ТӨБЗГ-ын 2024.04.25-ны 205 дугаар тогтоолоор EPC 01 ажлын хүрээнд шинээр бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч компанид эзэмшүүлэх шийдвэр гарсан.

EPC 02 ба 03 багц ажлын талаар

Газрын тос боловсруулах үйлдвэрийн EPC 02 ба 03 багц ажлын хүрээнд үйлдвэрийн үндсэн технологийн байгууламжуудын бүтээн байгуулалтын ажил хийгдэх юм. Үүнд:

- Атмосферийн нэрлэгийн байгууламж
- Вакуум нэрлэгийн байгууламж
- Ханасан хий ялгах байгууламж
- Түүхий ус боловсруулах систем
- Хөргөлтийн усны систем

131

- Уур, тэжээлийн ус, халаалтын ус, эрчим хүчний систем
- Хаягдал ус цэвэршүүлэх байгууламж
- Түлшний систем
- Бамбарын систем
- Даралтат агаарын систем
- Азотын хийн хангамжийн систем
- Түүхий эд, завсрын болон эцсийн бүтээгдэхүүн хадгалах резервуар сав
- Ачих, буулгах байгууламж
- Галаас хамгаалах систем г.м

EPC 03 багц ажлын хүрээнд Ерөнхий гүйцэтгэгч нь 35 МВт хүчин чадалтай үйлдвэрийн дулааны цахилгаан станцыг барьж байгуулна.




Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн EPC 02 болон EPC 03-ын Ерөнхий гүйцэтгэгчээр БНЭУ-ын Megha Engineering and Infrastructure Limited (MEIL) компани шалгарч, 2022.10.28-нд гэрээ байгуулсан боловч урьдчилгаа санхүүжилтийг жил гаруй хугацааны дараа олгосон явдал нь бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөө ёсоор гүйцэтгэх боломжгүй болгосон. Гэхдээ MEIL компани нь өөрсдийн санхүүжилтээр инженер-геотехник, суурь судалгааны ажлаа дуусган, ажлын нарийвчилсан зургийн ажлыг эхлүүлж, 2023 оны 4-р сард барилга угсралтын ажлаа эхлүүлсэн. Өнөөдөр үйлдвэрийн талбайд ажил ид өрнөж, гадаадын 1300 инженер, техникийн ажиллагсад бүтээн байгуулалтад оролцож байна.

EPC 02 багцад багтсан байгууламжуудын ажлын нарийвчилсан инженерчлэлийн ажлыг Испанийн "Intecsa Industrial" S.A компани гүйцэтгэсэн бөгөөд одоогийн байдлаар үйлдвэрийн процесс технологи, шугам хоолой, барилга бүтээц, цахилгаан гэх мэт чиглэлүүдээр нийт 1994 ажлын нарийвчилсан зураг төслийг боловсруулсан ба үйлдвэрийн 3D моделийг дуусгах шатандаа явж байна. Дээрх зураг төслийг МГТБҮ ТӨХХК нь төслийн менежментийн зөвлөх компанитай хамтран хянаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг хийж явж байна. MEIL компани EPC-02 багц ажлын төвөгшил өндөртэй, удаан үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн захиалгыг хийсэн ба дараах инженерчлэлийн зураг төслийн ажлыг гүйцэтгэж үйлдвэрлэж эхэлж байна.

- Атмосферийн болон вакуум нэрлэгийн цамхаг: **KCP Limited (ЭНЭТХЭГ)**
- Атмосферийн болон Вакуум нэрлэгийн байгууламжийн технологийн зуух: **"Heurtey Petrochem Solution" (ФРАНЦ)**
- Давсгүйжүүлэх байгууламж: **"Forum US" (АНУ)**
- Давсгүйжүүлэгчийн тоноглол: **Forum Energy Technologies US Inc. (АНУ)**
- Хэвтээ даралтат сав: **Bharat Tanks and Vessels (ЭНЭТХЭГ)**
- Технологийн зуух: **Heurtey Petrochem Solutions (ФРАНЦ)**
- Хөргөлтийн цамхаг: **Mihir Industries (ЭНЭТХЭГ)**
- Агаарын хөргүүр: **Jord International (АВСТРАЛИ)**
- Ус цэвэршүүлэх комплекс: **Rochem Separation Systems (ЭНЭТХЭГ)**
- Дулаан солилцуурууд: **United Cooling Systems (ЭНЭТХЭГ)**
- Азотын байгууламж: **Linde India Limited (ЭНЭТХЭГ)**
- Даралтат сав: **MEIL Unit I Jeedimetla (ЭНЭТХЭГ)**
- Газар доорх шугам хоолой: **Ratnamani Metals & Tubes Ltd (ЭНЭТХЭГ)**
- Центрифугийн насос: **KEPL (ЭНЭТХЭГ)**
- Ачих байгууламж: **Ferro Tube & Forge Industries (ЭНЭТХЭГ)**
- Цамхагийн дотор тоног төхөөрөмж: **Munters India Humidity (ЭНЭТХЭГ)**
- Технологийн байгууламжийн зуухны агаарын халаагуур: **Kamal Encon Industries (ЭНЭТХЭГ)**
- Бамбарын систем: **AFG Combustion Pvt Ltd (ЭНЭТХЭГ)**



Өнөөгийн байдлаар EPC-02 багц ажлын хүрээнд үйлдвэрийн талбайд MEIL компани Төслийн менежментийн зөвлөх болон МГТБҮ ТӨХХК-ийн хяналтан дор 32 ширхэг түүхий эд, завсрын

болон эцсийн бүтээгдэхүүний агуулах сав резервуар, хяналтын өрөө, дэд станцууд, шугам хоолойн эстакадын суурийн барилга угсралтын ажил хийж байна.

<table>
<tr><td>Технологийн байгууламжийн шугам хоолойн эстакад
  </td><td>Дагалдах байгууламжийн шугам хоолойн эстакад
  </td></tr>
<tr><td>Агуулах сав, резервуарын парк
  </td><td>Бүтээгдэхүүний резервуар сав
  </td></tr>
</table>

EPC 03 буюу Үйлдвэрийн Дулааны цахилгаан станцын Ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын Megha Engineering and Infrastructure Limited (MEIL) компани өнгөрсөн хугацаанд процессын, шугам хоолойн, барилга бүтээцийн чиглэлээр 160 гаруй ажлын нарийвчилсан зургийг боловсруулж, МГТБҮ ТӨХХК болон Теслийн менежментийн зөвлөх компаниар хянуулж ажилласан. Мөн түүнчлэн үйлдвэрийн цахилгаан станцын төвөгшил өндөр, хамгийн удаан үйлдвэрлэгдэх тоног төхөөремж буюу цахилгаан станцын уурын зуухыг **Их Британийн "Foster Wheeler/Wood"**, турбин-генераторыг **ХБНГУ-ын "Siemens"** компаниудад захиалж, **"KCP Limited", "MEIL"** компаниуд үйлдвэрлэж байна. Одоогийн байдлаар үйлдвэрийн талбайд тус компани нь цахилгаан станцын дэд станц, технологийн хяналтын барилгууд, шугам хоолойн эстакадыг барьж байгуулж байна.

133

Дэд станц	Шугам хоолойн эстакад
	

ГТБҮ-ийн технологийн байгууламжууд (үйлдвэрийн Дулааны цахилгаан станц багтсан), дагалдах, туслах байгууламжуудын инженерчлэлийг хийх, үйлдвэрийн зураг төсөл, барилга угсралт, туршилт зэрэг бүтээн байгуулалтын бүхий л үе шатанд хяналт тавих, төслийн менежментийн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор 2019.05.13-ны өдөр Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээг БНЭУ-ын "Engineers India Limited" компанитай байгуулж, Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн шугам (LoC)-д оруулсан. Энэхүү гэрээт ажлын цар хүрээнд "Барилгын тухай хууль"-ийн 37.2, 42 зүйлд заасан захиалагчийн хяналтын чиг үүрэг хамаарч байгаа юм.

Гэсэн хэдий ч "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-иас үйлдвэрийн 35 МВт-ын дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажилд техникийн хяналт тавиулах шаардлага тавьж, Засгийн газрын 2024.05.22-ны өдрийн 219-р тогтоолоор үйлдвэрийн дулааны цахилгаан станцын угсралтын ажлын захиалагчийн техникийн хяналтын ажилд шаардлагатай санхүүжилтийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас шийдвэрлэхээр болсон.

EPC 04 Багц ажлын талаар

Газрын тос боловсруулах үйлдвэрийн гүн боловсруулалтын 7 лицензтэй технологийн байгууламж буюу гидрокрекинг, дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хийг ялгах, бензин үйлдвэрлэх, хүхэр үйлдвэрлэх, устөрөгч үйлдвэрлэх, висбрекингийн байгууламжуудын лиценз эзэмшигчдээр шалгарсан **АНУ-ын UOP Honeywell, Францын Axens, Италийн KT-Kintetics Technology, Голландын Shell** компаниуд өөр өөрсдийн байгууламжийн зураг төслөө боловсруулж, 2022 оны сүүлээр бүрэн хүлээлгэж өгсөн.

Уг багц ажлын ерөнхий гүйцэтгэгчээр EPC 02, 03 багц ажлыг гүйцэтгэж байгаа Megha Engineering and Infrastructure Limited (MEIL) компани шалгарч, ЗГ-ын 2023.09.13-ны өдрийн 336-р тогтоолын дагуу 2023.09.29-нд EPC 04 багц ажлын I хэсгийн гэрээг батлагдсан Зээлийн дүнд (1.236.0 сая ам. доллар) багтаан байгуулсан боловч Энэтхэгийн Эксим банк тус гэрээг өнөөг хүртэл зээлийн шугамд оруулаагүйгээс бусад ажилтай зэрэг явагдах ёстой EPC 04 багц ажил эхэлж чадаагүй байна.

EPC 04 багц ажлын гэрээг тендерт ирүүлсэн хамгийн бага үнийн дүнгээр байгуулахад төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал 1,656,8 сая ам.доллар болох буюу 2018 онд боловсруулсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардал, хөнгөлөлттэй зээлийн дүнгээс 30 орчим хувиар өсөх болсон.

Үүнд дэлхийн зах зээл дээр сүүлийн жилүүдэд үүссэн эдийн засгийн хямрал, бүх төрлийн бараа материал, техник, тоног төхөөрөмжийн үнийн өсөлт болон инженерчлэл, зураг төслийн үе шатанд үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, үйл ажиллагааны тевөгшил болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түгээх, тээвэрлэлттэй холбоотой дэд бүтцийг өөрийн орны нөхцөлд тохируулах зэрэгтэй холбоотой техникийн зарим нэмэлт, өөрчлөлт оруулах болсон зэрэг нөлөөлсөн болно.

ЗГ-ын 2023.09.13-ны өдрийн 336-р тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн EPC-04 багц ажлын санхүүжилтийн талаар авах арга хэмжээний тухай" хэлэлцээд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банкнаас зээлийн нэмэлт эх үүсвэрийг шийдвэрлэсний дараа EPC-04 багц ажлын үлдэгдэл ажлыг гүйцэтгэх гэрээг Бүгд Найрамдах Энэтхэг Улсын "Мега Инженеринг Энд Инфрастрактурс Лимитэд" компанитай байгуулахыг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн удирдлагад даалгасан.

Энэтхэгийн ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийг нэмэгдүүлэх замаар нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр манай ЗГ-ын зүгээс Энэтхэгийн талд удаа дараа хандаад байна.

4. ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР

• ГАЗРЫН ТОС ДАМЖУУЛАХ ХООЛОЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Дорноговь аймагт баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэр (ГТБҮ)-ийн түүхий эдийг тээвэрлэх 530 км урт, 3 аймгийн (Дорноговь, Сүхбаатар, Дорнод), 8 сумдын (Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн, Баяндэлгэр, Халзан, Асгат, Сүхбаатар, Матад) нутаг дэвсгэрээр дамнан баригдаж буй, манай улсын хувьд нүүрсустөрөгч алсын замд тээвэрлэх анхны магистраль шугам хоолойн байгуулалтын ажил эрчимтэй явагдаж байна. Хоолойн "Толгой станц" болон "Халаах, өргөх станц-1" нь Дорнод аймгийн Матад сум, "Халаах өргөх, станц-2" Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, "Халаах, өргөх станц-3" Сүхбаатар аймгийн Халзан сум, "Халаах, өргөх станц-4" нь Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, "Хүлээн авах станц" Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт тус тус байрлана.


Газрын тос дамжуулах хоолой барих ажлын ерөнхий гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит "Norinco International Cooperation" компани 2022 оны сүүлээс төслийн ажлыг эхлүүлж, техникийн зураг төсөл, ажлын нарийвчилсан зураг, түүхий тосны шинжилгээ, инженерийн суурь судалгаа, 6 байршилд кемпийн барилга угсралт, технологийн зам зэрэг дэд бүтцийн ажлаа дуусгаснаар дамжуулах хоолойн барилга угсралтын ажлыг 2023 оны 6-р сард эхлүүлсэн.

Хоолойн ажлын нарийвчилсан зураг төсөл, инженерчлэлийн ажлыг **Канад улсын "Worley Parsons"** компани гүйцэтгэж, **Италийн Prometheus** компани хяналт тавьсан. Өдөр тутмын хяналтыг төсөл хэрэгжүүлэгч **"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр"** компани, Зохиогчийн хяналтын ажлыг **Хятадын Sinopec** компани гүйцэтгэж байна.

"Norinco International Cooperation" компани нь ажлаа эрчимтэй явуулж, өнөөдрийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Хоолой цувих ажил - **423 км**
- Хоолой гагнуурын ажил - **417 км**
- Үл эвдэх радиографийн сорил – **410 км**
- Зэврэлтээс хамгаалах будаг – **328 км**
- Дулаалга хөөс – **225 км**
- Хоолой буулгах, булах ажил – **148 км**
- ЦДАШ, дэд станц- **48.63%**
- Үндсэн түр кемпийн барилга угсралтын ажил - **100%**
- 5 халаах, өргөх станцын ажил – **25.51%**
- Толгой станцын түр кемпийн барилга угсралтын ажил - **77%,**
- Халаах, өргөх станц-1 түр кемпийн барилга угсралтын ажил - **79%,**
- Халаах, өргөх станц-2 түр кемпийн барилга угсралтын ажил - **100%**
- Халаах, өргөх станц 3 түр кемпийн барилга угсралтын ажил - **75%,**
- Халаах, өргөх станц 4 түр кемпийн барилга угсралтын ажил - **90%,**

Дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын зураг



- **ҮЙЛДВЭРИЙН ГАДНАХ ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**


Засгийн газрын 2018.01.24-ний өдрийн 21-р тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалт болох Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр чиглэлийн төмөр зам, хүнд даацын тусгай зориулалтын авто зам, цахилгаан дамжуулах сүлжээ барих ажлыг туршлага болон техник тоног төхөөрөмжийн чадавхитай төрийн өмчит этгээдүүдээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.

Үйлдвэрийн гаднах дэд бүтэц (17,5 км тусгай зориулалтын хүнд даацын авто зам, 27,7 км салаа төмөр зам, дэд өртөөний барилга байгууламж, 18,2 км 110 кВ-ын цахилгаан


137

дамжуулах агаарын шугам, 110/10кВ-ын дэд станц)-ийн барилга байгууламжийг Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр маш богино хугацаанд барьж байгуулан, 2019 оны 11 дүгээр сард ашиглалтанд хүлээн авсан.

Авто зам: 17,5 км хүнд даацын тусгай зориулалтын авто замын Ерөнхий гүйцэтгэгчээр Батлан хамгаалах яам ажилласан. ЗТХөгжлийн сайдын 2021 оны А/147-р тушаалаар "Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох 17.5 км авто зам"-ыг тусгай зориулалтын авто замд хамруулсан тул уг авто замын арчлалт, хамгаалалтыг 2022 оноос ЗТХЯ-ны харьяа "Дорноговь АЗЗА" ТӨХК хариуцахаар болсон бөгөөд манай компанийн зүгээс үйл ажиллагаанд хяналт тавьж шаардлагатай засвар, үйлчилгээг цаг хугацанд нь хийлгэж байна.



Төмөр зам: Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбосон 27 км төмөр зам болон 3,7 км холбоос зам, төмөр бетон гүүр, туннель барих Ерөнхий гүйцэтгэгчээр "Улаанбаатар төмөр зам" ХНН ажилласан.




Төмөр замын "тээвэрлэлт, арчлалт, хамгаалалтын гэрээт ажлын гүйцэтгэгч"-ээр "МТЛ" ХХК ажиллаж байгаа бөгөөд тус компани нь галт тэрэгний хөдөлгөөний байнгын бэлэн байдлыг хангаж, шаардлагатай засвар үйлчилгээний ажлуудыг хийлгэж байна.

Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц:

ГТБҮ-ийг Сайншанд сумтай холбосон 18.2 км 110кВ-ын ЦДАШ, 110/10кВ-6300кВа дэд станцын барилга байгууламжийг барьж, байгуулах Ерөнхий гүйцэтгэгчээр "ЦДҮС" ТӨХК ажилласан.


ТӨБЗГ-ын 2021.10.19-ний өдрийн 439-р "үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолоор "МГТБҮ" ТӨХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 18.2 км цахилгаан



дамжуулах агаарын шугам, 110/35/10кв дэд станцыг "ЦДҮС" ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн.

Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас гаргасан техникийн нөхцөлийн дагуу ГТБҮ-ийн "Ширээт" дэд станцын 110/10кВ-ын 6.3МВА хүчин чадал бүхий трансформаторыг 110/35/10кВ-ын 31.5МВА хүчин чадал бүхий трансформатораар өргөтгөх зайлшгүй шаардлага бий болсон. Монгол Улсын Шадар сайдаас Эрчим хүчний яам болон бусад холбогдох төрийн байгууллагуудад өгсөн чиглэлийн дагуу Эрчим хүчний яамнаас өргөтгөлийн зураг төслийг боловсруулж дууссан боловч санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байна. "Ширээт" дэд станцын өргөтгөлийг зардлыг 2024 оны улсын төсөвт суулгаж, үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Үйлдвэрийн хашаа барих, талбайн тэгшилгээний ажил: Үйлдвэрийн хашаа барих, талбайн тэгшилгээний ажлуудыг Барилга, хот байгуулалтын яамнаас сонгон шалгаруулсан "Нутгийн зам" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын захиалагчийн хяналтыг "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ гүйцэтгэж, 2022 онд Улсын комисс хүлээн авсан.



Эдгээр дэд бүтцүүд нь төслийн талбайд ГТБҮ-ийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх суурь нь болсон бөгөөд цаашид тус бүс нутагт төлөвлөсөн Аж үйлдвэрийн парк байгуулах хөтөлбөрийн эхлэл болсон.

10. Төслийн хүрээнд бий болох ажлын байрны тоо, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д ажиллаж буй нийт ажилтнуудын тоо, үүнээс Газрын тосны үйлдвэрийн хотхонд амьдарч буй ажилтнуудын тоо

- Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолойн үйл ажиллагааг явуулахад 1000 орчим инженер, техникийн ажилласад шаардлагатай.

Үйлдвэрт ажиллах нарийн мэргэжлийн инженерийг ойрын хугацаанд бага зардлаар бэлтгэх зорилгоор ШУТИС-тай хамтран тусгайлсан сургалтын хөтөлбөр боловсруулан БСШУЯ-аар батлуулж, тус их сургуулийн Геологи, уул уурхайн сургуульд "Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл"-ийн анги шинээр нээж, тэтгэлэгтэй хөтөлбөр хэрэгжүүлж, 2022-2023 оны оны хичээлийн жилээс элсэлт авч эхлээд байна. Манай улсын ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн байгалийн шинжлэх ухааны мэдлэгийн түвшин хангалттай бус байгаагаас залуу үе инженерийн ангийг, тэр дундаа газрын тосны инженерийн мэргэжлийг тэр болгон сонгохгүй байна.

- "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн (МГТБҮ) 2023 оны зохион байгуулалтын бүтэц (6 газар, 5 алба), орон тооны дээд хязгаар (150+1 хүн)-ыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлсан бөгөөд өнөөдрийн байдлаар 98 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах цаг ойртож байгаа өнөө үед үйлдвэрт ажиллах нарийн мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдыг бэлтгэхийн тулд төрөл бүрийн инженерийн мэргэжилтэй залуучуудыг ажилд авч, компани дээр аль болох урт хугацаанд инженрийн зураг төсөл, барилга угсралт, үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшүүлж, дадлагажуулсан байх шаардлагатай хэдий ч шаардлага хангасан инженерүүдийг олоход хүндрэлтэй байна.

- Газрын тос боловсруулах үйлдвэрийн ирээдүйн ажиллагсдын нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх, бүтээн байгуулалтын үе шатанд хөдөө, орон нутагт ажиллах гадаад, дотоодын инженер, техникийн ажиллагсдыг хямд орон байраар хангаж төслийн зардлыг хэмнэх зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд хотод "Газрын тосны үйлдвэрийн хотхон"-ы бүтээн байгуулалтыг хийхээр болсон. Өнөөдрийн байдлаар төсөл хэрэгжүүлэгч компанийн гэрээ байгуулсан I ээлжийн барилгуудын ажил хэвийн үргэлжилж, эхний 40 айлын 1 орон сууцны барилгыг 2022 онд ашиглалтад оруулсан.

- Ашиглалтад орсон 40 айлын 1 орон сууцыг юун түрүүнд Улаанбаатар хотоос ээлжээр ажиллаж буй МГТБҮ-ийн инженер, мэргэжилтнүүд ашиглаж, өмнө гардаг байсан томилолтын зардлыг эрс бууруулсан. МГТБҮ-ийн Улаанбаатар хотоос орон нутагт очиж ажиллаж буй инженер техникийн ажилтнууд гэр бүлийн хамт тус орон сууцанд (4 байранд) амьдарч байна.

Түүнээс гадна ГТБҮ байгуулах төслийн Менежментийн зөвлөх "Engineers India Limited (EIL), EPC 02 ба 03 багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгч "Megha Engineering & Infrastructures Limited", EPC 01-ийн ерөнхий гүйцэтгэгч JMC компани компанийн инженер, зөвлөхүүдийг тус орон сууцанд байраар хангасан болно.

141

11. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нь газрын тос хайх болон ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшдэг эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл

"*Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль*"-ийн хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой, найдвартай хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08-р сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст XXXI талбайг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК (МГТБҮ)-д олгосон.

Монгол орны зүүн хэсэгт газрын тос олборлож байгаа БНХАУ-ын "ПетроЧайна Дачин Тамсаг" ХХК-ийн Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудын хайгуулын хугацаа 2011, 2012 онд дуусгавар болсон учир тус компани Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Монгол Улсын Газрын тосны тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу дээрх 2 талбайд ашиглалтын талбайг ялгаж үлдсэн талбайг Монгол Улсын Засгийн газарт буцаажээ. Ашигт малтмал, газрын тосны газраас 2017 онд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн буцаагдсан хэсгийг нийлүүлээд хайгуулын Давст XXXI талбайг ялгасан юм. Давст XXXI талбай нь Монгол орны зүүн хэсэгт Дорнод аймгийн Матад, Халхгол сумдын нутгийг дамнан орших бөгөөд Тамсагийн сав газрын 15,575 км^2 талбайг хамарна.

"*Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль*"-ийн 5.5-д Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 5.2-т заасныг үндэслэн Газрын тос боловсруулах үйлдвэрт газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохоор тусгасан бөгөөд МГТБҮ нь Давст XXXI талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулсны дараа төрийн захиргааны төв байгууллагаас авах болно. Гэрээ байгуулах эрхийг Засгийн газраас олгох юм.

Манай компани уг талбайд өмнө хийгдсэн хайгуул, судалгааны ажлын анхдагч мэдээлэл, тайлан материалыг "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуул"-ийн 5.4 дэх заалтыг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанаас хуулбарлан авч, геологи, геофизикийн өгөгдөлд тайлал хийж, газрын тосны хэтийн төлөвт урьдчилсан байдлаар үнэлгээ хийж хэд хэдэн проспектуудыг тодорхойлоод байна.

МГТБҮ нь өнгөрсөн хугацаанд Давст XXXI талбайд хөрөнгө оруулалтыг татах талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж, гадаад, дотоодын олон аж ахуйн нэгжүүдийг хамтын ажиллагаанд урьж, олон удаагийн уулзалт, ярилцлага, хэлэлцээг хийсэн.

Хамтран ажиллах компанийг сонгох зорилгоор 19 орны 56 компанид, мөн Монгол улсад суугаа 13 Элчин сайдын яамдаар дамжуулан тухайн улсад газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, мэргэжлийн болон санхүүгийн чадавхтай компаниудтай хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн боловч бодитой хамтран ажиллах санал ирүүлээгүй. Их хэмжээний хөрөнгө санхүүжилт шаардлагатай, эрсдэл өндөртэй энэ салбарт манай орны хувьд газрын тосны суурь судалгаа муу, техник технологи, дэд бүтэц, эрх зүйн орчин хангалтгүй зэрэг шалтгаанаар хөрөнгө оруулагчид хамтран ажиллах сонирхол багатай байна.


Харин ГТБҮ-ийн бүтээн байгуулалтын EPC 02, 03, 04 дүгээр багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын "Megha Engineering and Infrastructures Limited" (MEIL) компаниас Давст XXXI талбайд хөрөнгө оруулалт хийн, газрын тосны хайгуулыг эрчимтэй явуулж, богино хугацаанд олборлолт эхлүүлэх, цаашилбал удахгүй ашиглалтад орох газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдийн хараат байдлаас гаргахад дэмжлэг үзүүлж, урт хугацаанд хамтран ажиллах сонирхолтой байгаагаа албан ёсоор илэрхийлсэн.

Манай компани MEIL компанитай байгуулах "Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа хамтран явуулах гэрээ"-ний төслийг боловсруулж, "Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ын 5.2-т заасны дагуу гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамдаас санал авч байна.

МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭР ТӨХХК

3. БНЭУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРААС АВСАН ЗӨЭЛ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙГООР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНҮҮД, ТЭДГЭЭРИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД БОЛОН ЗӨЭЛИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5. ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛСАН ЕРӨНХИЙ, ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ БОЛОН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ГАДААД, ДОТООДЫН КОМПАНИУДТАЙ ХИЙСЭН ГЭРЭЭ, ТҮҮНИЙ ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН СОНГӨН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ



143

3. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас авсан зээл, үүнтэй холбоотойгоор байгуулсан гэрээнүүд, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтүүд болон зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

3.1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас авсан зээл

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас манай улсад 1,0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болж, тус улсын Экспорт-Импортын банк, Монгол Улсын Засгийн газар хооронд 2016 оны 04 сарын 28-ны өдөр Зээлийн ерөнхий хэлэлцээрийг байгуулсан.

Засгийн газрын 2017 оны 2 сарын 17-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор тус 1,0 тэрбум ам.долларын зээлийн хөрөнгөөр Газрын тос боловсруулах үйлдвэр (ГТБҮ) байгуулах төслийг хэрэгжүүлэхээр тогтож, хэлэлцээрийг Улсын Их Хурлаас 2017 оны 5 сарын 31-ний өдөр соёрхон батлалсан.

ГТБҮ-ийн нарийвчилсан Техник эдийн засгийн үндэслэл (НТЭЗҮ)-ийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны захиалгаар БНЭУ-ын төрийн өмчит Инженерс Индиа Лимитед компани боловсруулж, тус яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл 2018 оны 11 дүгээр сард хүлээн авсан. НТЭЗҮ-ээр төслийн хөрөнгө оруулалтын нийт зардлыг 1,236 тэрбум ам.доллар байхаар тооцсон тул нэмэлтээр шаардлагатай 236,0 сая ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг 2019 оны 10 сарын 09-ний өдөр Монгол Улсын Засгийн газар, Энэтхэгийн Экспорт-Импорт банк хооронд байгуулсан болно.

Зээлийн эргэн төлөлтөөс чөлөөлөгдөх хугацааг сунгах зорилгоор 2016 онд байгуулсан 1,0 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийг 3 хэсэгт хуваан 2023 оны 08 сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан.

ГТБҮ байгуулах төсөлтэй холбоотой Монгол Улсын Засгийн газар, Энэтхэгийн Экспорт-Импорт банк хооронд дараах 4 Зээлийн ерөнхий хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

1. 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан 236,0 сая ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээр
2. ГТБҮ-ийн НТЭЗҮ, Төслийн менежментийн зөвлөх, EPC 01 багц ажлын гэрээ, Лиценз эзэмшигчидтэй байгуулсан гэрээнүүдэд зориулсан нийт 203,2 сая ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээр
3. ГТБҮ-ийн EPC 02 багц ажлын гэрээнд зориулсан 599,0 сая ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээр
4. ГТБҮ-ийн EPC 03 багц ажлын гэрээнд зориулсан 190,0 сая ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээр

3.2. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас авсан зээлийн хүрээнд байгуулсан гэрээнүүд, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтүүдийн

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан дээрх 4 Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд үйлдвэрийн барилга, угсралттай холбоотой ажил болон зөвлөх үйлчилгээний дараах гэрээнүүдийг санхүүжүүлсэн болон санхүүжүүлж байна. Үүнд:

№	Гэрээний нэр		Гүйцэтгэгч	Огноо	Үнийн дүн (ам.доллар)	Хэрэгжилт	Нэмэлт, өөрчлөлт
1.	"Газрын тос боловсруулах үйлдвэр болон дамжуулах хоолой барих" төслийн Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын гэрээ		Энэтхэгийн Инженерс Индиа Лимитед компани	2017.08.09	1,450,000	Хэрэгжиж дууссан	Байхгүй
2.	Монгол Улсад Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн "Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ		Энэтхэгийн Инженерс Индиа Лимитед компани	2019.05.13	73,300,433	Хэрэгжиж байгаа	1. Нэмэлт, өөрчлөлт №1: 2019.09.26 2. Нэмэлт, өөрчлөлт №2: 2021.03.10 3. Нэмэлт, өөрчлөлт №2: 2023.04.12
3.	Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн Технологийн бус барилга байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын гэрээ (EPC 01)		Энэтхэгийн Калпатару Прожектс Интернэйшнл Лимитед компанийн (JMC Projects India)	2020.10.13	97,800,000	Хэрэгжиж байгаа	1. Нэмэлт, өөрчлөлт №1: 2020.11.19 2. Нэмэлт, өөрчлөлт №2: 2023.04.03 3.Нэмэлт, өөрчлөлт №3: 2023.08.23 4. Нэмэлт, өөрчлөлт №4: 2023.11.28
4.	Анхдагч технологийн болон дагалдах байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын гэрээ (EPC 02)		Энэтхэгийн Мега Инженеринг Энд Инфрастрактур лимитед компани	2022.10.28	598,900,000	Хэрэгжиж байгаа	1. Нэмэлт, өөрчлөлт №1: 2023.01.25 2. Нэмэлт, өөрчлөлт №2: 2023.08.30 3. Нэмэлт, өөрчлөлт №3: 2023.09.28
5.	Үйлдвэрийн цахилгаан станцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын гэрээ (EPC 03)		Энэтхэгийн Мега Инженеринг Энд Инфрастрактур лимитед компани	2022.10.28	189,720,000	Хэрэгжиж байгаа	1. Нэмэлт, өөрчлөлт №1: 2023.01.25 2. Нэмэлт, өөрчлөлт №2: 2023.08.30 3. Нэмэлт, өөрчлөлт №3: 2023.09.28
6.	Лицензтэй технологийн байгууламжуудын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын гэрээ (EPC 04)		Энэтхэгийн Мега Инженеринг Энд Инфрастрактур лимитед компани	2023.09.29	212,000,000	Хэрэгжиж байгаа	Санхүүжилт эхлээгүй байгаа
7.	Үйлдвэрийн технологийн байгууламжуудын Лиценз эзэмшигчидтэй байгуулсан гэрээ (Лиценз, зураг төсөл, катализатор, химийн бодис, зарим тусгай тоноглол нийлүүлэх болон сургалтын гэрээ)	Устерегч үйлдвэрлэх байгууламж (HGU)	Италийн Kinetics Technology	2022.02.23	3,815,562	Хэрэгжиж байгаа	Байхгүй
		Хүхэр ялгах байгууламж (SRU)	Францын Axens	2022.04.01	1,998,000	Хэрэгжиж байгаа	
		Висбрекинг байгууламж (VBU)	Голландын Shell	2022.06.10	4,775,000	Хэрэгжиж байгаа	
		Шингэрүүлсэн шатдаг хийн цэвэрлэгээний байгууламж (LPGTU)	АНУ-ын Honeywell UOP	2022.04.20	1,810,000	Хэрэгжиж байгаа	
		Бензин үйлдвэрлэх байгууламж (MS Block)	АНУ-ын Honeywell UOP	2022.05.10	3,796,897	Хэрэгжиж байгаа	
		Гидрокрекинг гүн боловсруулалтын байгууламж (Full conversion HCU)	АНУ-ын Honeywell UOP	2022.05.02	8,178,270	Хэрэгжиж байгаа	

145

		Дизелийн гидро-цэвэрлэгээний байгууламж (DHTU)	АНУ-ын Honeywell UOP	2022.04.21	6,628,270	Хэрэгжиж байгаа	

5. Төслийн хүрээнд ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч гадаад болон дотоодын компаниуд тус бүрийн хариуцсан ажлын үнийн дүн, ажлын гүйцэтгэлийн явцын болон хийсэн ажлын тайлан, тэдгээрийн сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

5.1. Төслийн хүрээнд ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч ГАДААД компаниуд тус бүрийн хариуцсан ажлын үнийн дүн, ажлын гүйцэтгэлийн явцын болон хийсэн ажлын тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

№	Төрөл		Гүйцэтгэгч	Үнийн дүн (ам.доллар)	Ажлын явц *2024 оны 07 дугаар сарын байдлаар*	Ажлын тайлан
1.	Монгол улсад Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн "Төслийн менежментийн зөвлөх" үйлчилгээний гэрээ		Энэтхэгийн Инженерс Индиа Лимитед компани	73,300,433	-	Сар бүрийн тайланг ирүүлж байна.
2.	Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын гэрээ (EPC 01)		Энэтхэгийн Калпатару Прожектс Интернэйшнл Лимитед компанийн (JMC Projects India)	97,800,000	99%	Долоо хоног, сар бүрийн тайланг ирүүлж байна.
3.	Анхдагч технологийн болон дагалдах байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын гэрээ (EPC 02)		Энэтхэгийн Мега Инженеринг Энд Инфрастрактур лимитед компани	598,900,000	14.8% (тоног төхөөрөмжийн захиалгын явц ороогүй болно.)	Долоо хоног, сар бүрийн тайланг ирүүлж байна.
4.	Үйлдвэрийн цахилгаан станцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын гэрээ (EPC 03)		Энэтхэгийн Мега Инженеринг Энд Инфрастрактур лимитед компани	189,720,000	13% (тоног төхөөрөмжийн захиалгын явц ороогүй болно.)	Долоо хоног, сар бүрийн тайланг ирүүлж байна.
5.	Лицензтэй технологийн байгууламжуудын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын гэрээ (EPC 04)		Энэтхэгийн Мега Инженеринг Энд Инфрастрактур лимитед компани	212,000,000	8%	Долоо хоног, сар бүрийн тайланг ирүүлж байна.
6.	Үйлдвэрийн технологийн байгууламжуудын Лиценз эзэмшигчидтэй байгуулсан гэрээ (Лиценз, зураг төсөл, катализатор, химийн бодис, зарим тусгай тоноглол нийлүүлэх болон сургалтын гэрээ)	Устөрөгч үйлдвэрлэх байгууламж (HGU)	Италийн Kinetics Technology	3,815,562	1. Лицензийн гэрээ: 100% 2. Зураг төсөл боловсруулах гэрээ: 100% 3. Катализатор, химийн бодис, зарим тусгай тоноглол нийлүүлэх гэрээ: - 4. Сургалтын гэрээ: -	Байгууламж тус бүрийн Лиценз эзэмшигчид зураг төслөө (Basic Design Engineering Package) боловсруулж, төсөл хэрэгжүүлэгчид хүлээлгэн өгсөн болно.
		Хүхэр ялгах байгууламж (SRU)	Францын Axens	1,998,000	1. Лицензийн гэрээ: 100% 2. Зураг төсөл боловсруулах гэрээ: 100% 3. Катализатор, химийн бодис, зарим тусгай тоноглол нийлүүлэх гэрээ: -	

					4. Сургалтын гэрээ: -	
		Висбрекинг байгууламж (VBU)	Голландын Shell	4,775,000	1. Лицензийн гэрээ: 100% 2. Зураг төсөл боловсруулах гэрээ: 100% 3. Сургалтын гэрээ: -	
		Шингэрүүлсэн шатдаг хийн цэвэрлэгээний байгууламж (LPGTU)	АНУ-ын Honeywell UOP	1,810,000	1. Лицензийн гэрээ: 100% 2. Зураг төсөл боловсруулах гэрээ: 100% 3. Катализатор, химийн бодис нийлүүлэх гэрээ: - 4. Сургалтын гэрээ: -	
		Бензин боловсруулах байгууламж (MS Block)	АНУ-ын Honeywell UOP	3,796,897	1. Лицензийн гэрээ: 100% 2. Зураг төсөл боловсруулах гэрээ: 100% 3. Катализатор, химийн бодис, зарим тусгай тоноглол нийлүүлэх гэрээ: - 4. Сургалтын гэрээ: -	
		Гидрокрекинг гүн боловсруулалтын байгууламж (Full conversion HCU)	АНУ-ын Honeywell UOP	8,178,270	1. Лицензийн гэрээ: 100% 2. Зураг төсөл боловсруулах гэрээ: 100% 3. Катализатор, химийн бодис, зарим тусгай тоноглол нийлүүлэх гэрээ: - 4. Сургалтын гэрээ: -	
		Дизелийн гидро-цэвэрлэгээний байгууламж (DHTU)	АНУ-ын Honeywell UOP	6,628,270	1. Лицензийн гэрээ: 100% 2. Зураг төсөл боловсруулах гэрээ: 100% 3. Катализатор, химийн бодис, зарим тусгай тоноглол нийлүүлэх гэрээ: - 4. Сургалтын гэрээ: -	
7.	Газрын тос дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил		Хятадын Норинко Интернэйшнл Кооперэйшн	388,064,000	59%	Долоо хоног, сар бүрийн тайланг ирүүлж байна.

5.2. Төслийн хүрээнд ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч гадаад компаниуд тус бүрийн сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр гадаад улс орнуудад хэрэгжүүлж буй бүхий л төсөл хөтөлбөрүүдийн хувьд тус улсын Засгийн газраас гаргасан Зээлийн шугамын журмыг дагаж мөрддөг бөгөөд тус журамд, ерөнхий гүйцэтгэгчдийг зөвхөн

147

Энэтхэг компаниуд дундаас сонгох, мөн төсөлд шаардлагатай бараа материал, техник тоног төхөөрөмжийн Энэтхэг улсаас нийлүүлэх хувь хэмжээ гэх зэрэг нөхцөлийг зааж өгсөн байдаг. Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн Ерөнхий гүйцэтгэгч, зөвлөх компанийг сонгохдоо БНЭУ-ын Засгийн газрын Зээлийн шугамын журам болон Зээлийн ерөнхий хэлэлцээрт заасны дагуу эхлээд БНЭУ-ын Экспорт-Импортын банкнаас зөвхөн Энэтхэгт бүртгэлтэй компаниад дунд урьдчилан сонгон шалгаруулалт явуулж, хураангуй жагсаалт гарган Монголын талд хүргүүлж, улмаар тус хураангуй жагсаалтад орсон компаниуд дунд Монголын тал тендерийн хуулийн заршмын дагуу сонгон шалгаруулалт явуулж, гүйцэтгэгч компаниудыг шалгаруулсан болно.

1. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн Технологийн бүс барилга байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын EPC 01 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын талаар

БНЭУ-ын Экспорт-Импортын банкнаас 2019 оны 7 дугаар сард үйлдвэрийн Технологийн бүс барилга байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын (EPC 01) Ерөнхий гүйцэтгэгчийг урьдчилан сонгон шалгаруулах ажиллагаа явуулж, AFCONS Infrastructure Limited, JMC Projects India, KEC International, Mega Engineering and Infrastructure Лимитэд, Ashoka Buildcon зэрэг 5 компанийг хураангуй жагсаалтад оруулан 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлсэн.

Хураангуй жагсаалтад орсон компаниудын дунд монголын тал сонгон шалгаруулалт явуулахдаа, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 196 дугаар тогтоол, Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн 2019 оны Н-05/05 дугаар зөвлөмжийг үндэслэн Тагнуулын ерөнхий газраас чиглэл авсны үндсэн дээр "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 3.4 дүгээр заалтын дагуу компанийн дотоод худалдан авах ажиллагааны журмыг мөрдөн тендерийн зарчмаар сонгон шалгаруулалт явуулсан.

Сонгон шалгаруулалтыг нэг үе шаттай хоёр дугтуйтай саналын системээр явуулж, оролцогч компаниудаас ирүүлсэн техникийн саналыг Төслийн менежментийн зөвлөх компанитай хамтран үнэлж, техникийн шаардлага хангасан компаниудын үнийн саналыг нээж, хамгийн бага үнийн санал өгсөн компанийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон.

Нарийвчилбал, техникийн саналын шаардлага хангасан хоёр компанийн үнийн саналыг нээхэд JMC Projects India компани 113,7 сая ам.доллар, Afcons Infrastructure Limited компани 125,3 сая ам.долларын санал ирүүлсэн. Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн "JMC Projects India" (KPIL) компанитай үнэ бууруулах хэлэлцээг хийж, үнийн саналыг 16,0 сая ам.доллараар бууруулан 97,8 сая ам.долларт хүргэж чадсан.

Засгийн газрын 2020 оны 08 сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 09 сарын 15-ны № 33 тоот тогтоолыг үндэслэн "JMC Projects India" (KPIL) компанитай 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралт (EPC)-ын гэрээг дээрх үнийн дүнгээр байгуулсан.

EPC багцуудын Ерөнхий гүйцэтгэгч нартай ФИДИК-ийн Мөнгөн ном буюу нийт үнэд суурилсан, түлхүүр гардуулах нөхцөлтэй Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралт ажлын (Engineering, Procurement, and Construction – EPC) гэрээг байгуулсан бөгөөд гэрээний дагуу хийх бараа, ажил, үйлчилгээний бүх худалдан авалт, ажлын туслан гүйцэтгэгч нарыг Ерөнхий гүйцэтгэгч нар өөрсдөө сонгож, хариуцдаг болно.

2. Анхдагч технологийн болон дагалдах байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын EPC 02 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын талаар

БНЭУ-ын Экспорт-Импортын банкнаас 2020 оны 11 сард үйлдвэрийн Анхдагч технологийн болон дагалдах байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын EPC 02 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийг урьдчилан сонгон шалгаруулах ажиллагааг явуулж, Tata Projects Limited, Afcons Infrastructure Limited, L&T Hydrocarbon Engineering Limited, Tecnimont Private Limited зэрэг 4 компанийг хураангуй жагсаалтад оруулан монголын талд 2021 оны 3 сард ирүүлсэн.

2021 оны 4 сард монголын тал хураангуй жагсаалтад орсон компаниудын дунд сонгон шалгаруулалтыг зарлахад Afcons Infrastructure Limited, L&T Hydrocarbon Engineering Limited гэсэн 2 компани тендер ирүүлсэн. Тус хоёр компанийн техникийн саналыг үнэлж, техникийн шаардлага хангасан компаниудын үнийн саналыг нээхэд, Afcons Infrastructure Limited компани 736,0 сая ам.доллар, L&T Hydrocarbon Engineering Limited компани 1.264,0 сая ам.доллар буюу 1 багц ажлын хувьд үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардалтай тэнцэхүйц өндөр үнийн санал ирүүлсэн байсан.

Хэт өндөр үнийн санал ирүүлсэнтэй холбоотойгоор үүссэн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд монгол, энэтхэгийн төр засгийн байгууллагууд хамтран шуурхай арга хэмжээнүүдийг авч ажилласан.

Тухайлбал, 2022 оны 4-р сард Энэтхэгийн Экспорт-Импортын банк, Төслийн менежментийн зөвлөх компаниудын удирдлага Монголд яриа хэлэлцээ хийсний үр дүнд ирүүлсэн тендерүүдээс татгалзаж, илүү өрсөлдөөн бий болгох зорилгоор Энэтхэгт бүртгэлтэй гадаадын корпорициудын оролцоог хангах тусгайлсан өөрчлөлтийг Зээлийн ерөнхий хэлэлцээртээ оруулж, "Түргэвчилсэн тендер" буюу Энэтхэгийн Экспорт-Импортын банкнаас урьдчилсан сонгон шалгаруулалт явуулахгүйгээр монголын тал 2 уе шаттай нээлттэй тендерийг Энэтхэг улсад дахин зарлахаар болсон. Улмаар Энэтхэгийн талаас өгсөн зөвшөөрлийн дагуу EPC 02 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022 оны 06 сард Энэтхэгт бүртгэлтэй компаниуд дунд нээлттэй зарлаж, 09 сарын 26-нд дараах үнийн саналтай тендерүүдийг хүлээн авсан. Үүнд:

-Afcons Infrastructure Limited: 895,0 сая ам.доллар
-Tecnimont Private Limited and Kalpataru Power Transmission Limited: 749,5 сая ам.доллар
-Megha Engineering & Infrastructures Limited: 675,0 сая ам.доллар

Төсөл хэрэгжүүлэгч компани техникийн шаардлага хангаж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн Megha Engineering and Infrastructures Limited компанитай үнэ бууруулах хүндрэлтэй хэлэлцээг хийж, үнийн саналыг 675,0 сая ам.долларааc 598,9 сая

ам.доллар хүртэл бууруулж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10-р сарын 26-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 сарын 27-ны өдрийн 12 тоот тогтоолыг тус тус үндэслэн 2022 оны 10-р сарын 28-ний өдөр Megha Engineering & Infrastructures Limited компанитай гэрээ байгуулсан.

3. Үйлдвэрийн цахилгаан станцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын EPC 03 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын талаар

БНЭУ-ын Экспорт-Импортын банкнаас 2020 оны 12 сард үйлдвэрийн цахилгаан станцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын EPC 03 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийг урьдчилан сонгон шалгаруулах ажиллагааг явуулж, ISGEC Heavy Engineering Limited, Bharat Heavy Electricals Ltd компанийг хураангуй жагсаалтад оруулан 2021 оны 03 сарын 08-ны өдөр монголын талд хүргүүлсэн.

Хураангуй жагсаалтад орсон компаниуд дундаас Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021 оны 5 дугаар сард зарлахад, Bharat Heavy Electricals Ltd компани дангаараа тендер ирүүлсэн. Тус компанийн техникийн саналын үнэлгээг хийж, санхүүгийн саналыг нээхэд 380,0 сая ам.долларын, буюу мөн л маш өндөр үнийн санал ирүүлсэн байсан.

Тендерт ганц компани хэт өндөр үнийн санал ирүүлсэнтэй холбоотойгоор үүссэн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд монгол, энэтхэгийн төр засгийн байгууллагууд хамтран шуурхай арга хэмжээнүүдийг авч, EPC 02 багц ажлын сонгон шалгаруулалтын жишгээр "Түргэвчилсэн тендер" буюу Эксим банкнаас урьдчилсан сонгон шалгаруулалт явуулахгүйгээр монголын тал 2 үе шаттай нээлттэй тендерийг Энэтхэг улсад явуулахаар тохиролцсон. Улмаар Энэтхэгийн талаас өгсөн зөвшөөрлийн дагуу EPC 03 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022 оны 05 сард Энэтхэгт бүртгэлтэй компаниуд дунд нээлттэй зарлахад 07 сарын 04-нд дараах үнийн саналтай тендерүүдийг хүлээн авсан. Үүнд:

- JMC-EDAC Consortium: 249,6 сая ам.доллар
- Megha Engineering and Infrastructures Limited: 225,0 сая ам.доллар

Хамгийн бага үнийн санал ирүүлсэн Megha Engineering and Infrastructures Limited компанитай үнэ бууруулах хэлэлцээг хийж, үнийг 225,0 сая ам.доллараас 189,7 сая ам.доллар хүртэл бууруулж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10-р сарын 26-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 сарын 27-ны өдрийн 12 тоот тогтоолыг тус тус үндэслэн 2022 оны 10-р сарын 28-ны өдөр Megha Engineering & Infrastructures Limited компанитай гэрээ байгуулсан.

Төсөл хэрэгжүүлэгч компани EPC 02 ба 03 багц ажлын сонгон шалгаруулалтад тендер ирүүлсэн Megha Engineering and Infrastructures Limited компанитай хэлэлцээ хийсний үр дүнд нийт 110 сая ам.долларыг бууруулж чадсан юм.

4. Лицензтэй технологийн байгууламжуудын Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын EPC 04 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын талаар

EPC 04 багц ажлыг хугацаа алдалгүй эхлүүлэх талаар энэтхэг, монголын талууд зөвшилцсөний үндсэн дээр Энэтхэгийн талаас өгсөн зөвшөөрлийн дагуу Ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг EPC 02, 03 багц ажлын тендерийн жишгээр

түргэвчилсэн, нээлттэй тендерийг Энэтхэг улсад явуулсан. Уг тендерийг 2022 оны 10 сарын 28-ны өдөр Энэтхэгт бүртгэлтэй компаниуд дунд зарлахад, Megha Engineering and Infrastructures Limited, Fortune -Dinesh Chandra JV, Tecnimont - KPIL JV компаниудаас тендер ирүүлсэн.

Тендер ирүүлсэн компаниудаас Fortune -Dinesh Chandra JV ерөнхий нөхцөлийн шаардлагыг хангаагүй бөгөөд ерөнхий нөхцөлийн шаардлагыг хангасан Megha Engineering and Infrastructures Limited болон Tecnimont - KPIL JV компаниудын техникийн саналыг үнэлж, үнийн саналыг нээхэд Megha Engineering and Infrastructures Limited компани 648,0 сая ам.доллар, Tecnimont - KPIL JV 794,5 сая ам.долларын үнийн санал тус тус ирүүлсэн байсан.

Засгийн газрын 2023 оны 09 сарын 13-ны өдрийн 336 дугаар тогтоол, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09 сарын 28-ны № 23/07 тоот тогтоолыг үндэслэн үйлдвэрийн Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын EPC 04 багц ажлын эхний хэсгийн гэрээг батлагдсан зээлийн эх үүсвэрт багтаан 212.0 сая ам.доллар үнийн дүнгээр Megha Engineering and Infrastructures Limited компанитай 2023 оны 09 сарын 29-ны өдөр байгуулсан. Засгийн газрын 2023 оны 09 сарын 13-ны өдрийн 336 дугаар тогтоолын дагуу EPC 04 багц ажлын үлдсэн 2 дахь хэсгийн гэрээг Энэтхэгийн Экспорт-Импортын банкнаас зээлийн нэмэлт эх үүсвэр шийдвэрлэгдсэний дараа байгуулахаар төлөвлөж байна.

5. Газрын тос дамжуулах хоолойн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын (EPC) Ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын талаар

Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.01.25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжиж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолой барих төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах (EPC+F) Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулагдсан.

Мэргэжил, санхүүгийн чадавхтай гадаадын компаниудыг тендерт оролцуулах зорилгоор сонгон шалгаруулалтыг урьдчилсан сонголт болон нэг үе шаттай 2 дугтуйт хэлбэрээр олон улсад нээлттэй зарлаж, урилгыг АНУ-ын "Pipeline and Gas Journal" сэтгүүл болон компанийн вебсайтад нийтлүүлсэн.

Уг урилгын дагуу 9 улсын 24 компани оролцох хүсэлтээ ирүүлж, ерөнхий нөхцөлийн шаардлагыг хангасан дараах 15 компанийн хураангуй жагсаалтыг гаргасан. Үүнд:

- Sumitomo Corporation
- Kalpataru Power Transmission Limited
- L&T Hydrocarbon Engineering Limited
- PAO TMK
- ЗНГС Прометей
- E-Invest, a.s.& Bueno Engenharia e Construcao LTDA
- DIAG Industries Gmbh&Евроxан ХХК
- Project Materials GmbH
- Bonatti S.P.A
- Sicilsado S.p.A
- Sicim S.p.A

151

- China Petroleum Pipeline Engineering Comonay limited & China Petroleum Technology and Development Corporation
- Sinopec International Petroleum Service Corporation-Shnegli
- SINOPEC Engineering (Group) Co., Ltd
- Norinco International Cooperation Ltd

Урьдчилсан сонголтоор шаардлага хангасан Хятад-4, Герман-2, ОХУ-2, Итали-3, Энэтхэг-2, Япон-1, Чех Бразил-1, нийт 15 компанид дээрх үндсэн тендерийн баримт бичгийг 2021 оны 04 сарын 23-нд хүргүүлсэн. Оролцогсдоос тендерийг 2021 оны 10 сарын 20-ны өдөр хүлээн авсан бөгөөд дараах 4 компани тендер ирүүлсэн. Үүнд:

- China Petroleum Pipeline Engineering Limited (БНХАУ)
- NORINCO International Cooperation (БНХАУ)
- Kalpataru Power Transmission Limited (БНЭУ)
- Sumitomo корпораци (Япон)

Дээрх 4 компаниас 3 компани техникийн үнэлгээгээр шалгарсан бөгөөд тэдгээрийн санхүүгийн саналыг нээхэд China Petroleum Pipeline Engineering Limited компани 628.4 сая ам.доллар, NORINCO International Cooperation компани 397.0 сая ам.доллар, Kalpataru Power Transmission Limited компани 607.8 сая ам.долларын саналыг тус тус ирүүлсэн.

NORINCO International Cooperation компани нь дамжуулах хоолойн хөрөнгө оруулалтын 90 хувьтай тэнцэх зардлын эргэн төлөлтийг зээлийн хүү, шимтгэлгүй, Засгийн газрын баталгаа шаардахгүйгээр барилга угсралтын 3 жилийн хугацаанд Монголоос худалдан авах нүүрсний борлуулалтын орлогоор төлөх санал ирүүлсэн. Санхүүжилтийн 10 хувьтай тэнцэх 38,0 орчим сая ам. долларыг Монголын Засгийн газраас гаргах нөхцөл тавьсныг төсөл хэрэгжүүлэгч компани хэлэлцээрийн явцад хөнгөвчилж 100 хувийн санхүүжилтийг гүйцэтгэгчээс гаргуулах тохиролцоог хийж чадсан.

Захиалагч болон МГТБҮ-ээс хөрөнгө оруулалт, техник технологи, барилга угсралтын талаар нарийвчилсан шийдлүүдийг тохиролцохоор шалгарсан компанитай гэрээний хэлэлцээрийг эхлүүлсэн.

Үнэлгээний хорооны шийдвэрээр техник технологийн хувьд хэрэгжих боломжтой, хамгийн бага үнийн санал ирүүлсэн NORINCO International Cooperation компанийг сонгон шалгаруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас тус компанид гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2021 оны 12 дугаар сарын 3-ны өдөр хүргүүлж, EPC гэрээг 2022 оны 04 сарын 21-ний өдөр байгуулсан.

6. <u>Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн "Төслийн менежментийн" зөвлөхийн сонгон шалгаруулалтын талаар</u>

БНЭУ-ын Экспорт-Импортын банкнаас 2018 оны сүүлээр Төслийн менежментийн зөвлөх (ТМЗ) компанийн урьдчилсан сонгон шалгаруулалтыг явуулж, дангаараа саналаа ирүүлсэн Энэтхэгийн Инженерс Индиа Лимитэд компанийн тендерт үнэлгээ хийн, хураангуй жагсаалтад оруулан 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "GOILOC-258/18-19/2107" тоот албан бичгээр монголын талд мэдэгдсэн.

Гэвч ганц компанийн хураангуй жагсаалтаар монголын тал тендер хуулийн сонгон шалгаруулалт явуулах боломжгүй болсон тул ТМЗ компанийг хуулийн дагуу сонгох

асуудлыг яаралтай шийдвэрлэхээр Энэтхэгийн Гадаад хэргийн яам, Экспорт-Импортын банк, Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яамны холбогдох хүмүүс удаа дараа уулзаж, улмаар асуудлыг БНЭУ-ын Зөөлийн шугамын журмын дагуу шийдвэрлэхээр болсон. Тус Зөөлийн шугамын журмын Хоёрдугаар хавсралтын (f) хэсгийн II-т "Зөөлдэгч тал Төслийн менежментийн зөвлөх компанийг БНЭУ-ын Гадаад хэргийн яам, эсвэл Эксим банкнаас сонгож өгөх хүсэлтийг гаргасан тохиолдолд Энэтхэгийн Гадаад хэргийн яамнаас Төслийн менежментийн зөвлөх компанийг холбогдох дүрэм, журмын дагуу Зөөлдэгчийн өмнөөс сонгож өгөх боломжтой" гэж заасны дагуу Энэтхэгийн тал 2019 оны 01 сарын 21-ны өдөр Төслийн менежментийн зөвлөх компаниар Инженерс Индиа Лимитэд компанийг томилсон тухайгаа мэдэгдсэн болно. Улмаар тус компанитай 4 сарын хугацаанд хэлэлцээ хийсний дүнд 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж, төслийн үндсэн үйл ажиллагааг амжилттай эхлүүлсэн болно.
Дулхийн улс орнуудад хэрэгжиж буй ийм төрлийн төслүүдийн хувьд ТМЗ-ийн зардлыг нийт хөрөнгө оруулалтын зардлын 10 хувиар тооцдог жишгийн дагуу Инженерс Индиа Лимитэд компаниас гаргасан үнийн саналыг хэлэлцээ хийсний үр дүнд 5,8 хувьд хүргэж чадсан.

7. Лиценз эзэмшигчдийн сонгон шалгаруулалт

Үйлдвэрийн патенттай дараах 7 технологийн байгууламжуудын лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах ажиллагааг Энэтхэгийн Экспорт-Импортын банк, ТМЗ компанитай хамтран явуулсан:

- Бензин боловсруулах байгууламж (MS Block)
- Гидрокрекинг гүн боловсруулалтын байгууламж (HCU)
- Дизелийн гидроцэвэрлэгээний байгууламж (DHDT)
- Висбрекинг байгууламж (VBU)
- Шингэрүүлсэн шатдаг хийн цэвэрлэгээний байгууламж (LPGTU)
- Хүхэр ялгах байгууламж (SRU)
- Устөрөгч үйлдвэрлэх байгууламж (HGU)

Зөөлийн ерөнхий хэлэлцээрээс санхүүжих гэрээг сонгон шалгаруулахдаа зөвхөн Энэтхэгийн компаниуд зохион байгуулах (зөвхөн монголын төслийн хувьд Энэтхэгт бүртгэлтэй компаниуд гэж оруулсан), санхүүжилтийг зөвхөн Энэтхэг компанид олгох хязгаарлалттай байдаг бөгөөд олон улсад бүртгэлтэй лиценз эзэмшигчдийг хэрхэн сонгон шалгаруулж, зөөлийн шугамаас санхүүжүүлэх асуудлыг Энэтхэгийн ГХЯ, Экспорт-Импортын банк, ТМЗ компанитай удаан хугацаанд хэлэлцсэний эцэст монголын тал ТМЗ компанитай хамтран олон улсад нээлттэй сонгон шалгаруулалтыг явуулж, шалгарсан компаниудтай 3 талт гэрээ байгуулан төлбөрийг ТМЗ компаниар дамжуулан хийх замаар лиценз эзэмшигчдийг зөөлийн шугамаас санхүүжүүлэхээр тохиролцсон.

Лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2019 оны 11 сард олон улсад зарласан. Тендерт оролцсон АНУ-ын "UOP", "Merichem" болон "Chevron Lummus Global", Францын "Technip" болон "Axens", Данийн "Haldor Topsoe", Голландын "Shell", Италийн "Kinetics Technology" зэрэг компаниудтай техник технологи, санхүү, гэрээ эрх зүйтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхээр маш олон хэлэлцээг удаан хугацаанд хийсэн.

153

Улмаар хамтарсан ажлын хэсэг оролцогчдоос ирүүлсэн тендерийн техникийн хэсгийг хянаж, үнэлгээ хийж, техникийн шаардлага хангасан компаниудын үнийн саналыг нээж, хамгийн өндөр оноо авсан компаниудтай гэрээний хэлэлцээнд орж, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 сарын 27-ны өдрийн 25-28 дугаартай тогтоолуудыг үндэслэн дараах компаниудтай гэрээ байгуулсан.

- Хүхэр ялгах байгууламжийн (SRU) тендерт Францын "Axens" компани шалгарч, Лиценз олгох, зураг төсөл боловсруулах, тусгай тоног төхөөрөмж нийлүүлэх болон сургалтын гэрээ байгуулсан.

- Устөрөгч үйлдвэрлэх байгууламжийн (HGU) тендерт Италийн "Kinetics Technology" компани шалгарч, Лиценз олгох, зураг төсөл боловсруулах, тусгай тоног төхөөрөмж нийлүүлэх болон сургалтын гэрээ байгуулсан.

- Висбрекинг байгууламжийн (VBU) тендерт Голландын "Shell" компани шалгарч, Лиценз олгох, зураг төсөл боловсруулах, тусгай тоног төхөөрөмж нийлүүлэх болон сургалтын гэрээ байгуулсан.

- Гидрокрекинг гүн боловсруулалтын байгууламж (HCU), Бензин боловсруулах байгууламж (MS Block), Шингэрүүлсэн шатдаг хийн цэвэрлэгээний байгууламж (LPGTU), Дизелийн гидроцэвэрлэгээний байгууламжийн (DHDT) тендерт АНУ-ын "UOP" компани шалгарч, Лиценз олгох, зураг төсөл боловсруулах, тусгай тоног төхөөрөмж нийлүүлэх болон сургалтын гэрээ байгуулсан.

5.3. Төслийн хүрээнд ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч дотоод компаниуд тус бүрийн хариуцсан ажлын үнийн дүн, ажлын гүйцэтгэлийн явцын болон хийсэн ажлын тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

№	Төрөл	Байгууллага	Үнийн дүн (төгрөг)	Ажлын явц *2024 оны 07 дугаар сарын байдлаар*
	ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮТЦИЙН ХҮРЭЭНД			
1.	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн салбар төмөр замын - ТЭЗС, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээ	"Улаанбаатар төмөр зам" ХНН	70,582,000,000	100%
2.	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээ	БХЯ	29,405,625,497	100%
3.	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын нэмэлт гэрээ	БХЯ	4,488,543,287	100%
4.	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн талбайн тэгшилгээ, үйлдвэрийн хашаа, цэлжилтөөс сэргийлэх ойн зурвас байгуулах ажлын зураг төсөл боловсруулах, барьж байгуулах ажлын гэрээ	БХБЯ	5,842,500,000	100%
5.	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн 110кВ-ын ЦДАШ, Сайншанд дэд станцын өргөтгөл,	ЦДҮС ТӨХК	5,489,663,748	100%

	110/10 кВ-ын дэд станцын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээ			
6.	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн салбар төмөр ба авто замын техник эдийн засгийн судалгаа болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барьж байгуулах ажилд техник технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ, Ай Си Ти-Сайн Консалтинг ХХК	3,399,790,313	100%
7.	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан дамжуулах сүлжээ байгуулах ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах болох барьж байгуулах ажилд техник, технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ	Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ	141,117,045	100%

5.4. Төслийн хүрээнд ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч ДОТООД компаниуд тус бүрийн сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

5.4.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалт

Газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн өмчит хуулийн этгээдүүд хариуцан хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Үйлдвэрийн салбар төмөр замын ТЭЗС, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээг "Улаанбаатар төмөр зам" ХНН хариуцан хэрэгжүүлсэн.
- Үйлдвэрийн авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээг Батлан хамгаалах яам хариуцан хэрэгжүүлсэн.
- Үйлдвэрийн талбайн тэгшилгээ, үйлдвэрийн хашаа, цөлжилтөөс сэргийлэх ойн зурвас байгуулах ажлын зураг төсөл боловсруулах, барьж байгуулах ажлыг Барилга, хот байгуулалтын яам хариуцан хэрэгжүүлсэн.
- Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн 110кВ-ын ЦДАШ, Сайншанд дэд станцын өргөтгөл, 110/10 кВ-ын дэд станцын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах ажлын гэрээг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК хариуцан хэрэгжүүлсэн.
- Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн салбар төмөр ба авто замын техник эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах, тэдгээрийг барьж байгуулах ажилд технологийн хяналт тавих ажлыг Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ хариуцан хэрэгжүүлсэн.
- Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан дамжуулах сүлжээ байгуулах ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах болох барьж байгуулах ажилд техник, технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ хариуцан хэрэгжүүлсэн.

155

МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК
900, Бодь цамхаг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол улс
Утас: +976 70100389
И-мэйл: info@mongolrefinery.mn

2024.09.03 № 01/585

танай 2024.09.02 оны № 09/860

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН
ТӨСЛИЙН СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ
ГАЗРЫН АХЛАХ МЕНЕЖЕР
Б.БАТМӨНХ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2024 оны 09 дүгээр сарын 3-ны өдрийн 09/860 тоот албан бичигт дараах тайлбарыг хүргүүлж байна.

- **Таны 1 дүгээр асуултын тухайд:**

Лиценз эзэмшигчдийн төлбөрийн санхүүжилттэй холбоотой мэдээллийг УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалангийн асуултад бэлтгэж хүргүүлсэн хариултын 5.2-ийн 7 дахь хэсэг буюу "Лиценз эзэмшигчдийн сонгон шалгаруулалт"-ын талаарх мэдээлэлд оруулсан байгаа болно. Мөн Лиценз эзэмшигчидтай байгуулсан гэрээг БНЭУ-ын Экспорт-Импортын банкнаас санхүүжүүлж байгаа гэрээний жагсаалтад оруулсан байгааг асуултын 3.2 дахь хэсгээс харна уу.

БНЭУ-аас авсан зээлийн санхүүжилтийн дүнгийн нийлбэрийг тооцож үзэхэд зөрүү байхгүй байгааг доорх хүснэгтээр харуулав.

№	Зардлын зүйл	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг Гэрээний дүн	Санхүүжилтийн дүн
1	ГТБҮ-ийн НТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ	"Инженерс Индиа Лимитед"	2017.05.01	2019.12.31	$ 1,450,000	$ 1,450,000
2	Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ	"Инженерс Индиа Лимитед"	2019.05.13	2024.05.13	$ 73,300,433	$ 47,454,411
3	EPC-1 Технологийн бус барилга байгууламжийн ажил	Жэй Эм Си Прожектс Индиа	2019.10.13	2023.04.23	$ 97,800,000	$ 92,591,947
4	EPC-2 Анхдагч процессийн болон Дагалдах байгууламжуудын Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын ажил	Мега Инженеринг энд Инфрастракчерс	2022.10.28	2025.12.28	$ 598,900,000	$ 73,431,430
5	EPC-3 Үйлдвэрийн цахилгаан станцын Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын ажил	Мега Инженеринг энд Инфрастракчерс	2022.10.28	2025.06.28	$ 189,720,000	$ 22,282,829
6	Лиценз эзэмшигчдийн төлбөр				$ 31,002,000	$ 19,767,120
	Дүн				$ 992,172,433	$ 256,977,737

- **Таны 2 дугаар асуултын тухайд:**

УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан зөвхөн Газрын тос боловсруулах үйлдвэр (ГТБҮ)-ийн төслийн ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой мэдээллийг шаардсаны дагуу хариултыг бэлтгэж

хүргүүлсэн ба Сайншанд хотод баригдаж буй 550 айлын орон сууцны хотхон нь Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөлтэй шууд холбоогүй учир тавьсан асуултад хамаарахгүй гэж үзсэн болно. Харин дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой мэдээллийн хувьд, хүнд даацын авто, төмөр зам, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, үйлдвэрийн хашаа, талбайн тэгшилгээ зэрэг нь үйлдвэрийн бүтээн байгуулалтын нэг хэсэг тул үүнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлсэн.

- **Таны 3 дугаар асуултын тухайд:**

3.а. ГТБҮ-ийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн 17км ЦДАШ, дэд станцын барилга байгууламжийг мэргэжлийн байгууллага болох "Цахиалгаан дамжуулах үндэсний сүлжээ" ХК-д ТӨБЗГ-ын 2021.10.19-ны өдрийн 439-р тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн болно. (ТӨБЗГ-ын тогтоолыг хавсаргав.)

3.б 2023 оны байдлаар хуримтлагдаад байгаа 391 тэрбум төгрөгийн дансны өглөгийг дараах хүснэгтээр харуулав.

№	Дансны нэр	Дасны нэр	Харилцагч	Тайлбар
1	Байгууллагад өгөх өглөг	145,069,075.00	Промитиус компани	2024 онд төлсөн
2	Ажилчдад өгөх өглөг	8,749.55	Ажилтан	2024 онд төлсөн
3	Цалингийн өглөг	121,172.56	Ажилтан	2024 онд төлсөн
4	Гэрээт ажлын өглөг	45,943,441,767.51	Норинко компани	Дамжуулах хоолойн барилгын ажлын өглөг
5	Гэрээт ажлын өглөг	11,472,120.00	Криетив Монголиа ХХК	Гэрээг дүгнэж дууссанаар олгоно.
6	Бусад урт хугацаат өглөг	342,704,670,635.10	Эрдэнэс таван толгой ХК	Санхүүжилтийн эргэн төлөлтийн хуваарийг хавсаргав.
7	Бусад урт хугацаат өглөг	1,853,558,528.00	Хохтоны барилгын ажлын гүйцэтгэгчид	Барилгын ажлын барьцаа хөрөнгийн өглөг
Дүн		390,658,342,047.72		

Урт хугацаат өглөгийн санхүүжилт, эргэн төлөлтийн хуваарийг хавсаргав.

- **Таны 4 дүгээр асуултын тухайд:**

а. ГТБҮ-ийн эдийн засаг өөрийн онцлогтой бөгөөд үйлдвэрлэлийн нийт зардлын 85-90 хувийг түүхий эдийнг зардал эзэлдэг. Үйлдвэрийн үндсэн түүхий эд болох түүхий тосны дэлхийн зах зээлийн үнэ төрөл бүрийн шалтгаанаар тогтмол өөрчлөгдөж байдаг тул хэдэн жилийн дараах тосны үнэ ханшийг өнөөдөр таамаглах боломжгүй юм. Зарим онуудад жилийн дотор 2-3 дахин өөрчлөгдөж байсан жишээ бий. Уг шалтгаанаар үйлдвэрийн эдийн засгийн үр ашгийн нарийн тооцоог хийх боломж бага тул тухайн аж үйлдвэрийн салбарт түгээмэл ашиглагддаг олон улсын аргачлаллаар тооцож гаргасан.

б. Төслийн үр ашгийн тоон мэдээллүүд 2023 оны 9-р сард батлагдсан ТЭЗҮ-д туссан дүнгүүдээс ялгаатай байгаа учир нь тус тооцоог Төслийн менежментийн зөвлөх Инженерс Индиа Лимитед компани боловсруулсан ба ингэхдээ манай компанийн бусад зээлийн, тухайлбал, түүхий тос дамжуулах хоолой, Хөгжлийн

157

банкны зээлийн эргэн төлөлтийг авч үзээгүй, цэвэр үйлдвэрийн эдийн засгийн тооцоог авч үзсэн болно.

- **Таны 5 дугаар асуултын тухайд:**

Гишүүнээс ирүүлсэн албан бичигт хэдээс хэдэн оны тайлан мэдээг ирүүлэх талаар тодорхой дурдаагүй байх тул сүүлийн 2 жилийн аудитын дүгнэлтийг хүргүүлсэн. Олон улсын аудитын тайлан, дүгнэлт байхгүй болно.

- **Таны 6 дугаар асуултын тухайд:**

Сайншандад баригдаж буй хотхоны ашиглалтад орсон 40 айлын 1 орон сууцыг дараах байдлаар ашиглаж байна. Үүнд:

- Улаанбаатар хотоос ээлжээр ажиллаж буй МГТБҮ-ийн инженер, мэргэжилтнүүд – тус бүр 4 ор бүхий 3 байр,
- Улаанбаатар хотоос гэр бүлийн хамт орон нутагт ажиллаж, амьдарч буй МГТБҮ-ийн инженер техникийн ажилтнууд - 4 байр,
- Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн Менежментийн зөвлөх "Engineers India Limited" компани - 10 байр,
- EPC 01 багц ажлын ерөнхий гүйцэтгэгч "JMC" компани – 2 байр,
- EPC 02, 03 ба 04 багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгч "Megha Engineering & Infrastructures Limited" компани - 21 байр тус тус ашиглаж байна.

№	Орлогын утга	2024	2025	2026
1	Орон сууц хөлслөсний орлого (21 байр)	365,400,000	365,400,000	365,400,000
2	Орон сууц хөлслөсний орлого (2 байр)	33,600,000	33,600,000	33,600,000
3	Орон сууц хөлслөсний орлого (тохижилтгүй)	70,000,000	420,000,000	420,000,000
Нийт дүн		**469,000,000**	**819,000,000**	**819,000,000**

2025-26 онд орон сууцыг түрээслэх гэрээг байгуулаагүй байгаа тул 2024 оны жишгээр тооцөлөв.

Хавсралт 4... хуудастай.

Хүндэтгэсэн,

MONGOL REFINERY LLC
МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ
МОНГОЛ УЛС
УЛААНБААТАР ХОТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.АЛТАНЦЭЦЭГ

158

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр Дугаар 439 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэрийн 6,399,599,406.00 (зургаан тэрбум гурван зуун ерэн есөн сая таван зуун ерэн есөн мянга дөрвөн зуун зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

13901450

\Huraldaanii material\2021 on\2021.10.19 18-r huraldaan.docx

159

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2021.10.22 № А-5/6716

танай _____-ны №_____-т

"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 439 дугаар тогтоолыг хүргүүлж байна.

Тогтоолын хэрэгжилтийг ханган, биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ ЗАШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

13300609?
А-5/2021

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
А/[illegible] дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Гэрээний үйлчэтгэлийн дүн	Зээлийн хүүгийн зардал	Нийт балансын үнэ
		(төгрөг)		
1	18,2 км цахилгаан дамжуулах агаарын шугам	5,377,525,212.00	1,022,074,194.00	6,128,281,722.00
2	Дэд станц (110/35/10кв)			271,317,684.00
НИЙТ ДҮН				**6,399,599,406.00**
				(зургаан тэрбум гурван зуун ерэн есөн сая таван зуун ерэн есөн мянга дөрвөн зуун зургаан)

161

ЭТТ-2022/252 тоот гэрээний Хавсралт №3

САНХҮҮЖИЛТИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

№	Огноо	Дүн	Үлдэгдэл
0		-	$ 388,064,000
1	7/1/2027	$ 3,233,867	$ 384,830,133
2	8/1/2027	$ 3,233,867	$ 381,596,267
3	9/1/2027	$ 3,233,867	$ 378,362,400
4	10/1/2027	$ 3,233,867	$ 375,128,533
5	11/1/2027	$ 3,233,867	$ 371,894,667
6	12/1/2027	$ 3,233,867	$ 368,660,800
7	1/1/2028	$ 3,233,867	$ 365,426,933
8	2/1/2028	$ 3,233,867	$ 362,193,067
9	3/1/2028	$ 3,233,867	$ 358,959,200
10	4/1/2028	$ 3,233,867	$ 355,725,333
11	5/1/2028	$ 3,233,867	$ 352,491,467
12	6/1/2028	$ 3,233,867	$ 349,257,600
13	7/1/2028	$ 3,233,867	$ 346,023,733
14	8/1/2028	$ 3,233,867	$ 342,789,867
15	9/1/2028	$ 3,233,867	$ 339,556,000
16	10/1/2028	$ 3,233,867	$ 336,322,133
17	11/1/2028	$ 3,233,867	$ 333,088,267
18	12/1/2028	$ 3,233,867	$ 329,854,400
19	1/1/2029	$ 3,233,867	$ 326,620,533
20	2/1/2029	$ 3,233,867	$ 323,386,667
21	3/1/2029	$ 3,233,867	$ 320,152,800
22	4/1/2029	$ 3,233,867	$ 316,918,933
23	5/1/2029	$ 3,233,867	$ 313,685,067
24	6/1/2029	$ 3,233,867	$ 310,451,200
25	7/1/2029	$ 3,233,867	$ 307,217,333
26	8/1/2029	$ 3,233,867	$ 303,983,467
27	9/1/2029	$ 3,233,867	$ 300,749,600
28	10/1/2029	$ 3,233,867	$ 297,515,733
29	11/1/2029	$ 3,233,867	$ 294,281,867
30	12/1/2029	$ 3,233,867	$ 291,048,000
31	1/1/2030	$ 3,233,867	$ 287,814,133
32	2/1/2030	$ 3,233,867	$ 284,580,267
33	3/1/2030	$ 3,233,867	$ 281,346,400
34	4/1/2030	$ 3,233,867	$ 278,112,533
35	5/1/2030	$ 3,233,867	$ 274,878,667
36	6/1/2030	$ 3,233,867	$ 271,644,800
37	7/1/2030	$ 3,233,867	$ 268,410,933
38	8/1/2030	$ 3,233,867	$ 265,177,067

№201
Гарын үсэг

39	9/1/2030	$	3,233,867	$	261,943,200
40	10/1/2030	$	3,233,867	$	258,709,333
41	11/1/2030	$	3,233,867	$	255,475,467
42	12/1/2030	$	3,233,867	$	252,241,600
43	1/1/2031	$	3,233,867	$	249,007,733
44	2/1/2031	$	3,233,867	$	245,773,867
45	3/1/2031	$	3,233,867	$	242,540,000
46	4/1/2031	$	3,233,867	$	239,306,133
47	5/1/2031	$	3,233,867	$	236,072,267
48	6/1/2031	$	3,233,867	$	232,838,400
49	7/1/2031	$	3,233,867	$	229,604,533
50	8/1/2031	$	3,233,867	$	226,370,667
51	9/1/2031	$	3,233,867	$	223,136,800
52	10/1/2031	$	3,233,867	$	219,902,933
53	11/1/2031	$	3,233,867	$	216,669,066
54	12/1/2031	$	3,233,867	$	213,435,200
55	1/1/2032	$	3,233,867	$	210,201,333
56	2/1/2032	$	3,233,867	$	206,967,466
57	3/1/2032	$	3,233,867	$	203,733,600
58	4/1/2032	$	3,233,867	$	200,499,733
59	5/1/2032	$	3,233,867	$	197,265,866
60	6/1/2032	$	3,233,867	$	194,032,000
61	7/1/2032	$	3,233,867	$	190,798,133
62	8/1/2032	$	3,233,867	$	187,564,266
63	9/1/2032	$	3,233,867	$	184,330,400
64	10/1/2032	$	3,233,867	$	181,096,533
65	11/1/2032	$	3,233,867	$	177,862,666
66	12/1/2032	$	3,233,867	$	174,628,800
67	1/1/2033	$	3,233,867	$	171,394,933
68	2/1/2033	$	3,233,867	$	168,161,066
69	3/1/2033	$	3,233,867	$	164,927,200
70	4/1/2033	$	3,233,867	$	161,693,333
71	5/1/2033	$	3,233,867	$	158,459,466
72	6/1/2033	$	3,233,867	$	155,225,600
73	7/1/2033	$	3,233,867	$	151,991,733
74	8/1/2033	$	3,233,867	$	148,757,866
75	9/1/2033	$	3,233,867	$	145,524,000
76	10/1/2033	$	3,233,867	$	142,290,133
77	11/1/2033	$	3,233,867	$	139,056,266
78	12/1/2033	$	3,233,867	$	135,822,400
79	1/1/2034	$	3,233,867	$	132,588,533
80	2/1/2034	$	3,233,867	$	129,354,666
81	3/1/2034	$	3,233,867	$	126,120,800
82	4/1/2034	$	3,233,867	$	122,886,933

163

83	5/1/2034	$	3,233,867	$	119,653,066
84	6/1/2034	$	3,233,867	$	116,419,200
85	7/1/2034	$	3,233,867	$	113,185,333
86	8/1/2034	$	3,233,867	$	109,951,466
87	9/1/2034	$	3,233,867	$	106,717,600
88	10/1/2034	$	3,233,867	$	103,483,733
89	11/1/2034	$	3,233,867	$	100,249,866
90	12/1/2034	$	3,233,867	$	97,016,000
91	1/1/2035	$	3,233,867	$	93,782,133
92	2/1/2035	$	3,233,867	$	90,548,266
93	3/1/2035	$	3,233,867	$	87,314,400
94	4/1/2035	$	3,233,867	$	84,080,533
95	5/1/2035	$	3,233,867	$	80,846,666
96	6/1/2035	$	3,233,867	$	77,612,800
97	7/1/2035	$	3,233,867	$	74,378,933
98	8/1/2035	$	3,233,867	$	71,145,066
99	9/1/2035	$	3,233,867	$	67,911,200
100	10/1/2035	$	3,233,867	$	64,677,333
101	11/1/2035	$	3,233,867	$	61,443,466
102	12/1/2035	$	3,233,867	$	58,209,600
103	1/1/2036	$	3,233,867	$	54,975,733
104	2/1/2036	$	3,233,867	$	51,741,866
105	3/1/2036	$	3,233,867	$	48,508,000
106	4/1/2036	$	3,233,867	$	45,274,133
107	5/1/2036	$	3,233,867	$	42,040,266
108	6/1/2036	$	3,233,867	$	38,806,400
109	7/1/2036	$	3,233,867	$	35,572,533
110	8/1/2036	$	3,233,867	$	32,338,666
111	9/1/2036	$	3,233,867	$	29,104,800
112	10/1/2036	$	3,233,867	$	25,870,933
113	11/1/2036	$	3,233,867	$	22,637,066
114	12/1/2036	$	3,233,867	$	19,403,200
115	1/1/2037	$	3,233,867	$	16,169,333
116	2/1/2037	$	3,233,867	$	12,935,466
117	3/1/2037	$	3,233,867	$	9,701,600
118	4/1/2037	$	3,233,867	$	6,467,733
119	5/1/2037	$	3,233,867	$	3,233,866
120	6/1/2037	$	3,233,867	(0)	
		$	**388,064,000**	(0)	

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр | Дугаар 2 | Улаанбаатар хот

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх талаар холбогдох ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Хөгжлийн банкнаас "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгох зээл, зээлийн хүүг газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн үеэс төлөх талаар Монгол Улсын Хөгжлийн банктай хэлэлцээр хийж, гэрээ байгуулахыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.

3. Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай)-ын ажлыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч, явц, үр дүнгийн талаар Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд Ч.ХҮРЭЛБААТАР

165

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 09 өдөр Дугаар 09 Улаанбаатар хот

Зээлийн гэрээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.11, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар тогтоол, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 9.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын хүрээнд үйлдвэрийн гаднах дэд бүтэц болох хүнд даацын автозам, төмөр замын салаа, үйлдвэрлэлийг цахилгаанаар хангах цахилгаан дамжуулах агаарын шугам, үйлдвэрийн талбай бэлтгэх, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зориулж хавсралтад заасны дагуу нийт 250,000,000,000.00 (хоёр зуун тавин тэрбум) хүртэлх төгрөгийн зээлийн гэрээг Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн үеэс тооцож зээл, зээлийн хүүг төлөх нөхцөлтэйгээр Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулахыг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Цэрэннороот зөвшөөрсүгэй.

2.Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн барьцаанд Бүгд Найрамдах Энэтхэг улсын Инженерс Индия Лимитед компанийн боловсруулж буй нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэл, төслийн үр дүнд ирээдүйд бий болох хөрөнгийг тус тус барьцаалах талаар тус банктай хэлэлцээ хийхийг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Цэрэннороор нарт даалгасугай.

3."Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас тухай бүр авч үр ашигтай зарцуулах, гүйцэтгэсэн ажлын тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамаар хянуулан улирал бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг гүйцэтгэх захирал Д.Цэрэннороот үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХҮҮЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭХИШИГ

0001[illegible]

D:\Huraldaanii material\2016 on\2018.01.09\togtool\01docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн
09 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЗАРДАЛ

Д/д	Зардлын төрөл	Нийт зардал (тэрбум төгрөг)
1	Үйл ажиллагааны зардал	13.80
2	Дэд бүтэц барих зардал	210.40
3	Зөвлөх үйлчилгээний зардал	10.80
4	Үйлдвэрийн талбай бэлтгэх зардал	7.80
5	Магадлашгүй ажлын зардал	7.20
	Нийт дүн	250.00

167

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг
1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-19
Утас: +(976) 70130513
Факс: +(976) 70130502

2018.08.21 № 6/2655

танай _____-ны № _____-т

"МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨХХК-Д

Шийдвэр хүргүүлэх тухай

Танай компанийн 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03/18 дугаартай албан бичгээр БНЭУ-ын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжих *"Газрын тос боловсруулах үйлдвэр барих"* төслийн бэлтгэл ажил болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах 246.42 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг Монгол Улсын Хөгжлийн банкинд ирүүлснийг судалж үзээд Хавсралтад тусгасан нөхцөлөөр зээл олгохоор шийдвэрлэснийг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралт: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд.

ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ,
ЗЭЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Ч.МӨНХБАЯР

615

Монгол Улсын Хөгжлийн банкны
2018 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
61855 дугаар албан бичгийн Хавсралт

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

-	Зээлдэгч:	"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК
-	Зээлийн хэмжээ:	- Техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ, бусад шаардлагатай баримт бичиг болон барьцаа хөрөнгийн үнэлгээтэй уялдуулан 250,000,000,000 (хоёр зуун тавин тэрбум) хүртэл төгрөг. - Зээлдэгч төсөл хэрэгжүүлэх газрын гэрчилгээг банканд ирүүлэх, Эрдэлийн үнэлгээ, удирдлагын газраас ажлын шугамаар түүний үнэлгээг хийх. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас батлагдсан төсвийн хүрээнд барьцаа хөрөнгийн үнэлгээнд үндэслэн компанийн үйл ажиллагааны 2018 оны урсгал зардал болох 1,149,867,000 (нэг тэрбум нэг зуун дөчин есөн сая найман зуун жаран долоон мянган) хүртэл төгрөгийн санхүүжилтийг улирлаар хэсэгчлэн олгох. - Барьцаа хөрөнгийн үнэлгээтэй уялдуулан үндэслэл зээлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлэх.
-	Үндсэн хүү:	Жилийн 11.89% (төгрөгийн)
-	Нэмэгдүүлсэн хүү:	Үндсэн хүүний 20.0%
-	Зээлийн зориулалт	"Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төсөлд, нарийвчилбал төслийн хүрээнд хийгдэх авто зам, төмөр зам, цахилгаан, дулааны хангамж, үйлдвэрийн талбай бэлтгэх зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой ажлын зардал, төслийн зөвлөх үйлчилгээний болон компанийн үйл ажиллагааны зардал
-	Зээлийн хугацаа:	Зээлийн эхний олголтоос хойш 10 жил
-	Зээлийн судалгааны хураамж:	100,000 төгрөгийг нэг удаа
-	Зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэр:	Төслийн орлого
-	Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа:	Зээлийн эхний олголтоос хойш 2022 оныг дуустал
-	Үндсэн зээлийн эргэн төлөлтийн хуваарь:	2023 оноос зээлийн хугацаа дуусах хүртэл хугацаанд тэнцүү дүнгээр хагас жил тутам
-	Үндсэн хүүгийн эргэн төлөлтийн хуваарь:	2023 оноос зээлийн хугацаа дуусах хүртэл хугацаанд хагас жил тутам
-	Барьцаа хөрөнгө:	Төсөл хэрэгжих газар, төслийн хүрээнд иреэдүйд бий болох бүх хөрөнгө
-	Гэрээ байгуулахаас өмнөх нөхцөл:	- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас батлагдсан компанийн 2018 оны зорилтот түвшинг ирүүлэх. - Төсөл хэрэгжих газрын гэрчилгээг авч банканд ирүүлэх.
-	Бусад нөхцөл:	- Төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг ирүүлэх; - Үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг улирлаар

санхүүжүүлэх бөгөөд гүйцэтгэлд үндэслэнэ. Гүйцэтгэлтэй холбоотой банкнаас шаардсан материалыг ирүүлэх (дансны хуулга, түрээсийн гэрээ гэх мэт);

- Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг ирүүлэх, ерөнхий үнэлгээгээр нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд түүнийг мөн боловсруулж, батлуулан банканд ирүүлэх;
- Үндсэн зээл болон хүүгийн эргэн төлөлтөд эрсдэл учирсан тохиолдолд эргэн төлөлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар харуулан төлөх;
- Авто зам, төмөр зам, цахилгаан, дулаан хангамжийн дэд бүтцийн барилга байгууламжийн магадлалаар хянагдаж баталгаажсан ажлын зураг төсөл, төсөв, ажлын даалгавар, холбогдох техникийн нөхцөлүүд, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, газрын гэрчилгээ зэргийг тухай бүр банканд ирүүлэх;
- Аж ахуйн үйл ажиллагааны тустай зөвшөөрлийн хуульд заасны дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авч, банканд ирүүлэх;
- Үйлдвэрлэл эхлэхээс өмнө түүхий эд материалын татан авалт болон борлуулалтыг холбогдох гэрээ, хэлцлээр баталгаажуулж, банканд ирүүлэх;
- Зээлийг төслийн хэрэгжилтийн үе шат, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх болон бэлтгэн нийлүүлэлтийн гэрээ хэлцэл, төлбөрийн нэхэмжлэх болон ажлын гүйцэтгэлийн тайлан, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичиг зэрэгт үндэслэн хэсэгчлэн олгох;
- Төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээ тайлан, төслийн хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тайлан, төслийн шинэчлэгдсэн төлөвлөгөө зэргийг тухай бүр банканд ирүүлж байх;
- "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төсөл (*төсөл гэдэгт боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой, авто зам, төмөр зам, цахилгаан, дулааны хангамж, үйлдвэрийн тавбай бэлтгэх хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээний болон компанийн үйл ажиллагаатай холбоотой зардал хамаарна*)-ийн нийт төсвийг баталгаажуулж банканд ирүүлэх;
- Бодитоор бий болсон хөрөнгийг тухай бүр гэрчилгээжүүлж, Монгол Улсын Хөгжлийн банкны барьцаанд барихуулах;
- Зээл олгох шийдвэр гарсан тохиолдолд холбогдох яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар зэргийг гэрээний талуудаар оролцуулах;
- Монгол Улсын Хөгжлийн банк дахь харилцах дансаар зээл, хүүгийн төлбөрийг төлөх хэмжээний орлогыг зээл төлөгдөх өдрөөс өмнө төлөрүүлэх.

170

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар: ЗГ-МГТ-З 2018-43

Улаанбаатар х

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Зээлийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 4 453 дугаар зүйл, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 2 дугаар бүлэг, бу холбогдох заалт, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооц зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр бүлэг, Монгол Улсын Засгийн газрын 2(оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалт газрын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Хөгжли банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 06 дуга тогтоол, Зээлийн удирдлагын хорооны 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хурл 2018/01 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хор Энхтайваны өргөн чөлөө-19, 11, 12 дугаар давхарт байрлах, улсын бүртгэлийн 901600101 регистрийн 5461626 дугаартай **Монгол Улсын Хөгжлийн банк** (цаашид "Банк" гэх),

Нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэсни гудамж-5/2, Засгийн газрын II байр хаягт орших **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам** (цааши "Захиалагч" гэх),

Монгол Улс, Улаанбаатар хот-210349, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 1(Засгийн газрын IX байр хаягт орших регистрийн 6098169 дугаартай **Төрийн өмчийн бодлог зохицуулалтын газар** (цаашид "Хувьцаа эзэмшигч" гэх),

Монгол Улс, 13312 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу Сүхбаатарын талбай гудамж 8/1 байр, 1601 тоот хаягт орших улсын бүртгэлийн 9011671052 регистрийн 6177492 дугаартай **"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК** (цааши "Зээлдэгч" эсхүл "Төсөл хэрэгжүүлэгч" гэх), (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар харилцан тохиролцож байгуулсан болно.

1.2. Гэрээний зорилго нь *"Газрын тос боловсруулах үйлдвэр барих"* төслийг хэрэгжүүлэх зорилгоор Банкнаас Зээлдэгчид Гэрээнд заасан нөхцөл, зориулалтаар зээл олгох, зарцуулалтад хяналт тавих, Зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, түүний хүүг бүгдээ төлөх болон уг зээлтэй холбогдсон бусад харилцаа, Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон зохицуулахад оршино.

Хоёр.Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Гэрээнд дурдагдсан дараах нэр томьёог доор дурдсан агуулгаар ойлгоно:

2.1.1."зээл" гэж Банкнаас гэрээнд заасан зориулалтаар төсөл хэрэгжүүлэгчид олгож, Гэрээнд заасан нөхцөлийн дагуу хүүгийн төлбөрийн хамт бүгдээр төлөгдөх мөнгөн хөрөнгийг;

Банк:

Худсыг батлагаажуулан гарын үсэг зурсан

төлөөлөх:

1

171

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

2.1.2.**"Зээлдэгч"** гэж Энэхүү гэрээнд заасны дагуу зээл авсан төсөл хэрэгжүүлэгчийг;
2.1.3.**"төсөл"** гэж Гэрээний 1.2-т заасан төслийг;
2.1.4.**"Захиалагч"** гэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
2.1.5. **"барьцааны зүйл"** гэж Талуудын хооронд байгуулсан Барьцааны гэрэ
тусгагдсан, зээлийн мөнгөн хөрөнгийг бүцааж төлөх баталгаа болгож Банкинд барьцаалж
зүйлийг;
2.1.6.**"Гүйцэтгэгч"** гэж Төслийн ажлыг хийж гүйцэтгэхээр Зээлдэгч буюу Төс
хэрэгжүүлэгч нартай ажил гүйцэтгэх болон түүнтэй ижил зорилго бүхий гэрээ байгуулсан аж
гүйцэтгэгч этгээдийг;
2.1.7.**"зээл олголтыг зогсоох"** гэж зээл олгохыг бүрмөсөн зогсоож Банк нэг тал
санаачилгаар зээлийн гэрээг цуцлан зээлийн үндсэн төлбөр болон үндсэн хүү, нэмэгдүүлс
хүүг хугацаанаас нь өмнө шаардах эрх үүсэх, Банкинд учирсан хохирлыг Зээлдэгч
нэхэмжлэх үр дагавар бүхий үйлдэл, эс үйлдлийг;
2.1.8.**"зээл олголтыг түр зогсоох"** гэж Гэрээний 6 дугаар зүйлд заасан нөхцөл байд
бий болсон тохиолдолд зээлийн Гэрээг цуцлалгүйгээр Банкны тавьсан шаардлага биелэх хүрт
хугацаанд зээл олголт болон Банкин дахь харилцах болон зээлийн дансанд буй зээлийн мөнг
хөрөнгөөс зарлага гаргахгүйгээр түр зогсоохыг;
2.1.9. **"Зээлдэгчийн эрх зүйн байдлын талаар ноцтой сөрөг үр дагавар бүхи**
мэдээлэл" гэж төслийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий тусга
зөвшөөрөл нь хүчингүй болсон эсхүл татан буугдах, дампуурах хүсэлтээ холбогдох этгээдэ
гаргасан зэрэг болон тэдгээртэй төстэй үр дагавар бүхий нөхцөл байдлыг;
2.1.10. **"барьцаа хөрөнгийн чанар, үнэлгээ ноцтой буурсан"** гэж дараах үйлдэл,
үйлдлийг ойлгоно.Үүнд:
2.1.10.а. Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан Барьцаан
гэрээнд заасан барьцаа хөрөнгийн чанар, зах зээлийн үнэлгээ ердийн элэгдэл хорогдлоос гадуу
илт муудаж, Банкнаас олгосон зээл, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүний төлбөрийн нийлбэр н
барьцаа хөрөнгийн үнэлгээний 90-ээс дээш хувиар буурсан;
2.1.10.б. барьцааны зүйл гуравдагч этгээдэд давхар барьцаалагдсан;
2.1.10.в. барьцааны зүйлтэй холбоотойгоор шаардсан баримт бичгийг Банкин
ирүүлээгүй;
2.1.10.г. Шүүх, Арбитр, Прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуул, Цагдаа
Улсын бүртгэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Татварын байгууллагаас барьцааны зүйлийн
захиран зарцуулах эрхэд хязгаарлалт хийсэн.
2.1.11. **"Зээлдэгч их хэмжээний эд хөрөнгийн хариуцлага хүлээх болсон"** гэж Зээлдэгч
Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцлийн үнийн дүнтэй адил
хэмжээний эд хөрөнгийн хариуцлага хүлээх болсныг;
2.1.12. **"зээлийн төлбөр"** гэж зээлийн үндсэн төлбөр, үндсэн хүү болон нэмэгдүүлсэн
хүүг.

Гурав.Зээлийн нөхцөл

3.1. Банк нь Зээлдэгчид дараах нөхцөлөөр зээл олгоно:
3.1.1.**Зээлийн хэмжээ:** Техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ, бусад
шаардлагатай бичиг баримт болон барьцаа хөрөнгийн үнэлгээтэй уялдуулан 250,000,000,000.00
(хоёр зуун тавин тэрбум) хүртэл төгрөг байна.
3.1.2.**зээлийн хүү:** Жилийн 11.89% (арван нэг зууны наян есөн) хувь;
3.1.3.**зээлийн хугацаа:** Зээлийн эхний олголтоос хойш 10 жил;

Банк:

Худалдаж баталгаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

3.1.4.**зээлийн зориулалт:** "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төс
нарийвчилбал төслийн хүрээнд хийгдэх авто зам, төмөр зам, цахилгаан, дулааны ханга
үйлдвэрийн талбай бэлтгэх зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой ажлын зар
төслийн зөвлөх үйлчилгээний болон компанийн үйл ажиллагааны зардалд зориулагдана. Үүн
өөр зориулалтаар ашиглахыг хориглоно;

3.1.5.**үндсэн зээлийн эргэн төлөлт:** 2023 оноос зээлийн хугацаа дуусах хүр
хугацаанд тэнцүү дүнгээр хагас жил тутам;

3.1.6.**зээлийн хүүгийн эргэн төлөлт:** 2023 оноос зээлийн хугацаа дуусах хүр
хугацаанд хагас жил тутам;

3.1.7.**зээлийн эргэн төлөлтийн хуваарь:** Хавсралт 1 (Зээлийн эргэн төлөлт
хуваарь)-д тодорхойлсон хуваарийн дагуу төлнө;

3.1.8. **зээл олгох хэлбэр:** бэлэн бус, төгрөгөөр;

3.1.9. **Зээлдэгчийн зээлийн дансны дугаар:** ....., валют-төгрөг;

3.1.10. **Зээлдэгчийн харилцах дансны дугаар:** ....., валют-төгрөг;

3.1.11. **зээл судалсны шимтгэл:** 100,000.00 төгрөг нэг удаа;

3.1.12. **нэмэгдүүлсэн хүү:** Гэрээний 3.1.2-т заасан хүүгийн 20 (хорин) хувьтай тэнц
байна;

3.1.13. **барьцаа хөрөнгө:** Зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан 20
оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаартай Барьцааны гэрээ (төслий
хүрээнд ирээдүйд бий болох эд хөрөнгийн эрх)-нд дурдсан барьцааны зүйл болон ирээдүй
холбогдох талуудын хооронд байгуулагдах бүх төрлийн барьцаа, баталгаа, батлан даалты
гэрээнд дурдсан барьцааны зүйлүүд;

3.1.14. **Зээлийг хэсэгчлэн олгох:**

3.1.14.а. Зээлийг төслийн хэрэгжилтийн үе шат, ажил гүйцэтгэх, үйлчилгэ
үзүүлэх болон бэлтгэн нийлүүлэлтийн гэрээ хэлцэл, төлбөрийн нэхэмжлэх болон ажлы
гүйцэтгэлийн тайлан, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичиг зэрэг
үндэслэн хэсэгчлэн олгоно;

3.1.14.б. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зээлийн эргэн төлөлтий
баталгаа гаргаж өгсөн тохиолдолд уг байгууллагаас баталсан төсвийн хүрээнд барьца
хөрөнгийн үнэлгээнд үндэслэн компанийн үйл ажиллагааны 2018 оны урсгал зардал боло
1,149,867,000 (нэг тэрбум нэг зуун дөчин есөн сая найман зуун жаран долоон мянган) хүртэл
төгрөгийн санхүүжилтийг улирлаар хэсэгчлэн олгож болно;

3.1.14.в. Барьцаа хөрөнгийн үнэлгээтэй уялдуулан үлдэгдэл зээлийг Банкны
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлнэ.

3.1.15. **Зээлийн эх үүсвэр:** Актив пассив, хөрөнгийн удирдлагын газрын дүгнэлтээр
тодорхойлогдоно.

Дөрөв.Зээлийн хугацаа тоолох болон зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү тооцох

4.1. Зээлийн эхний олголтыг Гэрээний 3.1.9–д заасан дансанд шилжүүлсэн өдрөөс эхлэн
зээлийн хугацааг тоолох бөгөөд энэ өдрөөс эхлэн үндсэн хүү тооцно.

4.2. Зээлийн хүүг сар тутам харгалзах бодит хоногоор, жилийн 365 хоног байхаар,
нэмэгдүүлсэн хүүг хугацаа хэтрүүлсэн хоног тутам харгалзах бодит хоногоор тооцно.

4.3. Зээлдэгч зээлийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд зээлийн үндсэн
төлбөрийг төлөөгүй бол зээл төлөгдөх хуваарьт өдрийн дараагийн өдрөөс эхлэн төлөөгүй
үндсэн төлбөрийн дүнгээс Гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд Гэрээний

173

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

3.1.12-т заасан хувиар нэмэгдүүлсэн хүүг тооцож, Гэрээнд заасан зээлийн хүү дээр н
Банкинд төлнө.

4.4. Зээл, зээлийн хүүгийн төлбөрийг Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт хугацаанаас е
төлсөн тохиолдолд зээлийн хүүг ашигласан бодит хоногоор тооцно.

Тав.Зээлийн олголт хийх

5.1 Зээлдэгч Гэрээний дагуу зээлийг хүлээн авах эрх дараах тохиолдолд үүсэхийг тал
харилцан тохиролцов:

5.1.1.зээлийн болон харилцах дансыг Банкинд нээсэн байх;

5.1.2.Зээлдэгчийн компанийн дүрэм буюу үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг,
бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлүүд нь хууль тогтоомжид заасан шаардлагыг ханга
хүчин төгөлдөр байх;

5.1.3.Банкны бодлого, журмын дагуу шаардагдах бүх баримт бичгийг үнэн зөв, бүр
бүрдүүлж өгсөн байх;

5.1.4.Барьцааны гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж, эрх бүхий байгууллаг
бүртгүүлсэн байх;

5.1.5.барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, лавлагаа ав
үйлчилгээний хураамж болон зээл авахтай холбоотойгоор гарах нотариатын болон буса
холбогдох төлбөр, хураамж, шимтгэлийг төлсөн байх;

5.1.6.Зээлдэгч төсөл хэрэгжих газрын гэрчилгээг авч Банкинд ирүүлэх ба Банкн
Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын газраас үнэлгээг хийнэ. Энэхүү үнэлгээнд үндэслэн төслий
батлагдсан төсвийн хүрээнд компанийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг гүйцэтгэл
үндэслэн улирлаар, хэсэгчлэн олгоно. Гүйцэтгэлтэй холбоотой Банкнаас шаардсан материаль
ирүүлэх (дансны хуулга, түрээсийн гэрээ гэх мэт);

5.1.7.төсөл хэрэгжих хугацаанд төслийн санхүүжилтийн хуваарьтай нийцүүлэн тухай
жилд санхүүжүүлэх дүнг Зээлийн удирдлагын хороо болон Төлөөлөн удирдах зөвлөлд дахи
танилцуулж, зөвшөөрөл авах.

5.2. Зээлдэгч нь Гэрээний 5.1-д заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангаснаар зээлий
хүлээн авах эрх үүсэх бөгөөд зээлийг хэсэгчлэн олгохдоо дараагийн олголтуудыг төслий
төлөвлөгөөний гүйцэтгэлд үндэслэн хүлээн авах эрх нээгдэх ба ингэхдээ 3.1.14.в-д заасан
шийдвэр гарсан байна.

5.3. Зээлийг барьцаанд бариулах бодит барьцаа хөрөнгийн үнэлгээтэй уялдуулан
хэсэгчлэн олгоно.

5.4. Бараа худалдан авах гэрээ, ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ, гүйцэтгэлийн тайлан,
нэхэмжлэх зэрэг баримт бичигт үндэслэн зээлийг хэсэгчлэн олгох зөвшөөрлийг Банкнаас тухай
бүр олгоно.

5.5. Банкны эрх бүхий этгээдээс тухайн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх талаар гаргасан
шийдвэрийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон, эсхүл Зээлдэгч зээлийн гэрээ
байгуулагдсанаас хойш 3 сарын дотор зээлийг хүлээн авааагүй буюу Зээлдэгчээс шалтгаалан
Банк зээлийг Зээлдэгчийн дансанд шилжүүлэх нөхцөл бүрдээгүй тохиолдолд Банк энэхүү
Зээлийн гэрээг дангаар цуцалж, зээлийг олгохоос татгалзах эрхтэй.

5.6. Зээлийн мөнгөн хөрөнгийг хэсэгчлэн олгохтой холбоотойгоор Зээлдэгч нь дор
дурдсан баримт бичгийг бүрдүүлсний үндсэн дээр зээлийн дараагийн олголтыг хүлээн авах
тухай хүсэлтээ Банкинд ирүүлэх ба Банк эдгээр баримт бичиг, холбогдох бусад нөхцөл

Банк:

Л.

Худсыг баталгаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

МОНГОЛ УЛСЫН
ХЭГЖЛИЙН БАНК

шаардлага бүрэн хангагдсан эсэхийг хянан шалгасны үндсэн дээр дараагийн олголтыг х
буюу харилцах данснаас гүйлгээ хийх зөвшөөрөл олгоно:

5.6.1. Төсөл хэрэгжүүлэгчийн албан хүсэлт;
5.6.2. Төсөл хэрэгжүүлэгчийн баталгаажуулсан гүйцэтгэлийн тайлан;
5.6.3. Төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ;
5.6.4. Гүйцэтгэгчийн төлбөрийн нэхэмжлэх;
5.6.5. Банк шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.

Зургаа.Зээл олголтыг түр зогсоох

6.1. Банк дараах тохиолдолд Зээлдэгчид мэдэгдэл хүргүүлснийүндсэн дээр зээл олго
хийхийг бүрэн болон хэсэгчлэн түр зогсоож болно:

6.1.1.Гэрээний 5.2 дахь хэсэгт заасны дагуу зээлийн эхний олголтыг хийгээгүй б
эхний олголтыг хийгээгүй нөхцөл байдал арилах хүртэл хугацаанд дараагийн олголтыг;

6.1.2.зээлийн мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар өөр зүйлд зарцуулах гэж буй
Банкны газар дээрх болон зайны шалгалтаар тогтоогдсон бол уг зөрчлийг арилгасан тухайг
Банкинд бүрэн нотлох хүртэл хугацаанд;

6.1.3.Гэрээний 5.4 дэх хэсэгт заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй эсхүл, бүр
бус, өөр хоорондоо зөрчилтэй, дутуу, хоёрдмол утга бүхий тодорхой бус агуулгатай барим
бичиг бүрдүүлсэн бөгөөд эдгээр нь зээлийг бүр зогсоох үндэслэл болохгүй гэж Банк үзсэн бо
эдгээр зөрчил, доголдлыг арилгах хүртэл хугацаанд.

6.1.4.Зээлдэгч Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол биелүүлэх хүртэл хугацаан
зогсооно.

Долоо.Зээлийн эргэн төлөлт

7.1. Зээлийн төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд зээлийн төлбөрий
нэмэгдүүлсэн хүү, зээлийн хүү, зээлийн үндсэн төлбөр гэсэн дарааллаар төлнө.

7.2. Зээлдэгч нь Гэрээний Хавсралт 1-д заасан хугацаанаас өмнө зээл, зээлийн хүү
эргүүлэн төлж болно.

7.3. Зээлдэгч зээл, зээлийн хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй аливаа шалтгаан
(үүнд байгалийн гамшиг, байлдааны ажиллагаа, хорио цээрийн дэглэм, гэнэтийн буюу
давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал зэрэг) нь Зээлдэгч Гэрээгээр хүлээсэн
үүргээ гүйцэтгэхгүй байх үндэслэл болохгүй.

7.4. Зээлийн гэрээний хугацаа дууссан нь гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй
Зээлдэгчийг зээлийн төлбөрийг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

7.5. Төслийн ажил аливаа шалтгаанаар хойшилсон нь Зээлдэгч Гэрээний дагуу үндсэн
төлбөр, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.

7.6. Зээлдэгч нь зээлийн эргэн төлөлтийг зээл авсан валютаар эргэн төлөх бөгөөд өөр
валютаар төлөх тохиолдолд Банкны зөвшөөрлийг авах ба зээл олгох, төлөх, зээлийн төлбөрийг
суутгах аливаа валютын ханшийг зээлийн эх үүсвэртэй уялдуулан Банк дангаар тогтооно.

7.7. Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөр хийх өдөр бөлмогц зээлийн үндсэн
төлбөр, түүний үндсэн болон нэмэгдүүлсэн хүүг Банкин дахь зээлдэгчийн данснаас,
зээлдэгчийн данс дахь мөнгөн хөрөнгө нь хуваарьт төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй, бол
Зээлдэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн бусад банкин дахь данснаас үл маргах
журмаар төлүүлэх бөгөөд энэхүү үйлдлийг Банкны тухай хуулийн 11.2-д заасан *(үл маргах*

Банк:

Худалдаж баталгаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийн төлөөлөл:

175

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

журмаар төлөх тухай харилцагчийн гарын үсэг бүхий гэрээ) харилцагчийн даалгавраар гүйл
хийгдсэнд тооцно. Энэ тохиолдолд Зээлдэгчид урьдчилан мэдэгдсэн байх.

7.8. Банк Гэрээний 8.3.1 дэх хэсэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөө
олгосны дагуу Зээлдэгч бусад банк, санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ
эргэн төлөлтийн хуваарь Гэрээний эргэн төлөлтийн хуваарьтай давхацсан бол энэ зээл
гэрээний дагуу хийх зээлийн болон хүүгийн төлбөрийн үүргийг тэргүүн ээлжид биелүүлнэ.

7.9. Банк нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр Зээлдэгч
зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ (зээлийг худалдаж) шилжүүлж болох бөгөөд ийнх
шилжүүлсэн тохиолдолд барьцааны эрхийг хамт шилжүүлж болно.

Найм.Зээлдэгчийн эрх, үүрэг

8.1. Зээлдэгч зээлийн үүргийг зохих ёсоор гүйцэтгэх талаар дараах үүрэг хүлээнэ:

8.1.1.зээлийг Гэрээний 3.1.4-т заасан зориулалтын дагуу ашиглах;

8.1.2.зээлийн төлбөрийг Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь бүр
төлөх;

8.1.3.хугацаа дууссан техникийн нөхцөлүүдийн хугацааг сунгаж, холбогдох барим
бичгийг ирүүлсэн байх;

8.1.4.төслийн хүрээнд бий болох барилга, байгууламжийн санхүүжилтийг олгохдо
Барилгын тухай хуулийн 25.2-т заасны дагуу барилгын зураг төсөл, төсөвт эрх бүхи
байгууллагаар магадлал хийлгүүлж Банкинд ирүүлэх;

8.1.5.зээлийг төлүүлэх тухай мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд зээлийн төлбөрийг у
мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэх;

8.1.6.Зээлдэгчийн хүсэлтээр Зээлийн гэрээ, түүний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаа
байгуулсан аливаа гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд Банкны эрх бүхий этгээдий
шийдвэрийн дагуу Банкнаас тогтоосон дүнгээр шимтгэл төлөх;

8.1.7.зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд уг эргэн төлөлтий
хуваарийг баталгаажуулан Банкинд ирүүлэх үүрэгтэй бөгөөд ийнхүү ирүүлээгүй нь Банкнаа
шинэчлэн хүргүүлсэн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлбөр төлөх үүргээ
чөлөөлөгдөхгүй;

8.1.8.байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг ирүүлэх, ерөнхий үнэлгээгээр
нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд түүнийг мөн боловсруулж, батлуулан
Банкинд ирүүлэх;

8.1.9.авто зам, төмөр зам, цахилгаан, дулаан хангамжийн дэд бүтцийн барилга
байгууламжийн магадлалаар хянагдаж баталгаажсан ажлын зураг төсөл, төсөв, ажлын
даалгавар, холбогдох техникийн нөхцөлүүд, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх,
зөвшөөрөл, газрын гэрчилгээ зэргийг тухай бүр Банкинд ирүүлэх;

8.1.10.аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуульд заасны дагуу
үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай
зөвшөөрөл болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авч, Банкинд ирүүлэх;

8.1.11.үйлдвэрлэл эхлэхээс өмнө түүхий эд материалын татан авалт болон
борлуулалтыг холбогдох гэрээ, хэлцлээр баталгаажуулж, Банкинд ирүүлэх;

8.1.12.Банкин дахь харилцах дансаар зээл, хүүгийн төлбөрийг төлөх хэмжээний
орлогыг зээл төлөгдөх өдрөөс өмнө төвлөрүүлэх;

8.1.13.Төслийн хүрээнд баригдах боловсруулах үйлдвэр, бусад барилга байгууламжууд
баригдаж дууссаны дараа барьцааны зүйл болох газар ашиглах эрхийн гэрчилгээг газар

Банк:

Худалдаж баталгаажуулан гарын үсэг зурсан:

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

эзэмших эрхийн гэрчилгээ болгон өөрчилж Банкинд барьцаалуулж, холбогдох бүртгэл байгууллагад бүртгүүлэх.

8.2. Зээлдэгч нь зээлийн зарцуулалтыг тайлагнах талаар дараах үүрэг хүлээнэ:

8.2.1. Зээлдэгч нь санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын ажлыг Нягт бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тогтмол бүртгэх;

8.2.2. зээлийн зарцуулалт, төслийн хэрэгжилтийн талаарх баримт бичиг болон Банкн шаардсан холбогдох бусад материалыг бүрэн, үнэн зөвөөр Банкинд улирал тутам гарг тайлагнах;

8.2.3. зээлийн гэрээний хугацаанд Зээлдэгчийн жилийн борлуулалтын төлөвлөг зээлийн зарцуулалтыг дэлгэрэнгүй тусгасан сар бүрийн борлуулалтын болон гүйцэтгэли тайлан, санхүүгийн тайлан, Зээлдэгчийн аудитлагдсан санхүүгийн тайлан, мөн түүнчлэн зээлт холбоотой аливаа мэдээллийг Банкнаас шаардсан тухай бүрд шуурхай гаргаж өгөх;

8.2.4. Банкны төлөөлөгчдийг зээлийн ашиглалттай холбоотой баримт бичгүүдэд бол газар дээрх хяналт, шалгалт хийх буюу хяналт тавих бололцоогоор хангаж, өөрийн эд хөрөнг санхүүгийн бүртгэл, тайлантай чөлөөтэй танилцуулах;

8.2.5. төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээ тайлан, төслийн хүрээнд хийгдсэн ажлы гүйцэтгэлийн тайлан, төслийн шинэчлэгдсэн төлөвлөгөө зэргийг тухай бүр Банкинд ирүүл байх;

8.2.6. Төслийн нийт төсвийг боловсруулан, баталгаажуулж Банкинд ирүүлэх.

8.3. Зээлдэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх санхүү, төлбөрийн чадвартай бай талаар дараах үүрэг хүлээнэ:

8.3.1. шүүх, арбитр болон төрийн зохих байгууллагад Зээлдэгчийн эсрэг их хэмжээни үнийн дүн бүхий гомдол, нэхэмжлэл гарсан болон эдгээр төрлийн нэхэмжлэл, гомдлыг эр бүхий байгууллагаас ханган шийдвэрлэсэн эсхүл ийм үнийн дүн бүхий эвлэрлийн гэрэ байгуулсан тохиолдолд энэ тухай Банкинд нэн даруй мэдэгдэх;

8.3.2. зээлийн эрсдэлийг удирдах, хянах, эрсдэлээс сэргийлэх шаардлагатай бүхий арга хэмжээг авах;

8.3.3. Зээлдэгч өөрийн компани, байгууллагыг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах өөрчлөх замаар өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орох, татан буугдах, эрх зүйн байдлаа өөрчлөх, нэрээ солих, оршин байгаа газраа өөрчлөх эсхүл эдгээр нөхцөл байдал бий болж болзошгүй тохиолдол бүрд Банкинд 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх;

8.3.4. Зээлдэгчийн санхүүгийн тайлан, балансад аудит хийлгэсэн зардлыг хариуцах.

8.4. Зээлдэгч нь барьцааны хөрөнгийн чадавхийг ханган ажиллах талаар дараах үүрэг хүлээнэ:

8.4.1. Зээлдэгч нь зээл барьцааны хэмжээ хангагдах хэмжээнд барьцаа хөрөнгийг нэмэгдүүлэх;

8.4.2. Зээлдэгч нь зээлийг төлж дуусах хүртэлх хугацаанд Банкинд урьдчилан бичгээр мэдэгдэлгүйгээр барьцааны зүйлийг гуравдагч этгээдэд ашиглуулах, түрээслүүлэх, аливаа этгээдийн барьцааны эрх давхар үүсгэхгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй байх үүрэгтэй бөгөөд Банк нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс өмнө тэргүүн ээлжид барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөлийг хангаж ажиллах;

Банк:

Хуудсыг баталгаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

177

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

8.4.3. зээлийн хугацаанд зээлийн барьцаа хөрөнгийг дахин үнэлэх болон барьца
зүйлийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын талаар газар дээрх явцын хяналтыг хийхэд Банк
хүндрэл учруулахгүй байх, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

8.4.4. барьцааны зүйлийн бүрэн бүтэн, хүчин төгөлдөр байдлыг хангах, чанар байд
муутгахгүй байх, Банкны шаардлагаар зохих шаардлага хангах эд хөрөнгөөр солих;

8.4.5. барьцааны зүйл нь зээлийн болон бусад төлбөрийг бүрэн барагдуула
хүрэлцэхгүй тохиолдолд бусад эд хөрөнгөөр төлөх;

8.4.6. бодитоор бий болсон хөрөнгийг тухай бүр гэрчилгээжүүлж, Банкны барьца
бариулах;

8.4.7. барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, бүртгэлд өөрчле
оруулах, бүртгэлийн хугацааг сунгах болон лавлагаа авах үйлчилгээний хураамжийг төлөх.

8.5. Зээлдэгч дараах эрхтэй:

8.5.1. Зээлийн гэрээ, Барьцааны гэрээ хүчин төгөлдөр болсон бөгөөд Гэрээний 5 дуга
зүйлд заасан нөхцөл, шаардлагыг бүрэн хангаснаар зээлийн мөнгөн хөрөнгийг гэрээнд заас
хугацаанд зориулалтын дагуу ашиглах;

8.5.2. зээл, зээлийн хүүгийн төлбөрийг хугацаанаас нь өмнө төлөх;

8.5.3. зээлийн дансны гүйлгээний хуулга, баримтыг тухай бүр авах;

8.5.4. зээлийн эргэн төлөлттэй уялдуулан барьцаа хөрөнгөөс чөлөөлүүлэх болон зээли
нөхцөлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах;

8.5.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах.

Ес.Банкны эрх, үүрэг

9.1. Банк дараах үүрэгтэй:

9.1.1. Зээлийн гэрээ болон Барьцааны гэрээ хүчин төгөлдөр болж, Гэрээний 5 дугаа
зүйлд заасан зээл олгох нөхцөл хангагдмагц Зээлдэгчид гэрээнд заасан зориулалтаар зээл олгох

9.1.2. Банк зээл олгосон даруй зээл олгосон өдөр, зээлийн хэмжээ, түүнд бодогдо
хүүгийн хувь хэмжээ, зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлтийг харуулса
бүртгэлийг хөтлөх, Зээлдэгчийн хүсэлтээр уг бүртгэлийн талаарх мэдээллийг гаргаж өгөх;

9.1.3. Банк нь Гэрээний 9.1.2 дахь хэсэгт заасан бүртгэлийг зохих ёсоор хийгээгүй буюу
алдаатай хөтөлсөн нь Зээлдэгчийн зээлээ төлөх үүрэг хариуцлагад нөлөөлөхгүй бөгөөд
Зээлдэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй;

9.1.4. Зээлдэгчид өөрийн дотоод дүрэм, журмын дагуу түргэн шуурхай, чирэгдэлгүй
үйлчлэх;

9.1.5. Гэрээний дагуу Банкны төлөөлөгчийн гүйцэтгэх хяналт, шалгалтын үйл
ажиллагаа нь Зээлдэгчийн бизнесийн болон үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд
сөргөөр нөлөөлөхгүй байх;

9.1.6. Гэрээ, холбогдох журмаар хүлээсэн бусад үүргээ биелүүлэх.

9.2. Банк дараах эрхтэй:

9.2.1. Зээлдэгчийн зээл, зээлийн хүүгийн төлбөрийг Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн
дагуу төлүүлэх, хугацаа хэтэрсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийн хамт
Зээлдэгчийн Банкин дахь харилцах данснаас үл маргах журмаар суутган авах, тухайн данснад
зээл төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний мөнгө байхгүй буюу уг данснаас зээлийн үндсэн төлбөр,

8

Банк:

Хуудсыг баталгаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

хүү, бусад төлбөрийг төлүүлэх боломжгүй тохиолдолд арилжааны банкууд дахь Зээлдэг
бусад данснаас үл маргах журмаар төлүүлэх;

9.2.2.зээлийн ашиглалт буюу зарцуулалт, зээлээр санхүүжигдэж буй Төс
хэрэгжилтийн явц, Зээлдэгчийн хөрөнгө санхүүгийн байдал болон барьцаа хөрөнгөд хя
тавих, газар дээр нь шалгалт хийх, Зээлдэгчийн үйл ажиллагаа явуулж буй газарт нэг
орох;

9.2.3.Зээлдэгчээс хэрэгжүүлж буй Төслийн үр дүнгийн талаарх мэдээлэл, төлөвл
санхүүгийн тайлан, зээл зарцуулалтын болон борлуулалтын тайлан, холбогдох матери
авах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

9.2.4.барьцаа хөрөнгөнд даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын н
төлбөрөөр төргүүн зэлжид зээлийн төлбөрийг барагдуулахыг шаардах;

9.2.5.Зээлдэгч Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт хугацаанд зээл, зээлийн хүүг төлө
тохиолдолд уг төлбөрийг барьцаа хөрөнгөөр барагдуулахаар хугацаатай анхаарал, мэдэ
хүргүүлж, Зээлдэгч уг хугацаанд гэрээний зөрчлөө арилгаагүй бол барьцааны зүйлээр ху
заасны дагуу зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах;

9.2.6.Банк шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Зээлдэгчийн санхүүгийн тай
балансад аудит хийлгэх, баримт бичиг гаргуулан авах эрхтэй ба аудит хийлгэх байгууллa
Банк дангаар сонгох;

9.2.7.Зээлдэгчийн санхүүгийн чадвар, бусад банкнаас зээлтэй эсэх талаарх мэдээлл
холбогдох байгууллагаас авах;

9.2.8.Банк нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр Зээлдэгч
зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ (зээлийг барьцааны эрхийн хамт худалдаж) шилжүүлэх;

9.2.9.Банкны эрх бүхий этгээдээс тухайн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх тал
гаргасан шийдвэрийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон, эсхүл Зээлдэгч зээлийн гэ
байгуулагдсанаас хойш 3 сарын дотор зээлийг хүлээн аваагүй буюу Зээлдэгчээс шалтгаа
Банк зээлийг Зээлдэгчийн дансанд шилжүүлэх нөхцөл бүрдээгүй тохиолдолд зээл
хүсэлтийг дахин хэлэлцэх, зээлийн гэрээг нэг талын санаачилгаар цуцлах;

9.2.10. Банк нь зээл төлөгдөж дуусах хүртэл хугацаанд барьцаа, баталгааны гэрэ
тусгагдсан барьцааны зүйлийн талаарх лавлагаа, мэдээллийг эрх бүхий байгууллагаас авах;

9.2.11. Банк нь зээлийн эх үүсвэр, олголт, эргэн төлөлт зэрэг зайлшгүй шалтгаан
Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт Зээлдэгчтэй зөвшилцсөний дагуу өөрчлөлт оруулах;

9.2.12. Банк тус төсөлд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг татан төвлөрүүл
тохиолдолд эх үүсвэрийн өртгөөс хамаарч олгосон зээлийн жилийн хүүд Банк нэг тал
санаачилгаар тохируулга хийх;

9.2.13. төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулагдса
дараагаар төслийн санхүүжилттэй холбоотой судалгааг нарийвчлан хийж Зээлийн удирдлаг
хороо болон Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, өгсөн чиглэлийн дагуу холбогдох ар
хэмжээг авах;

9.2.14. Банкны Актив, пассив хөрөнгийн удирдлагын газраас тогтоосон Гэрээнд заас
зээлийн эх үүсвэр өөрчлөгдөх тохиолдолд зээлийн зарим нөхцөлд *(зээлийн хэмжээ, хү
хугацаа, эргэн төлөлтийн хуваарь)* өөрчлөлт оруулах асуудлыг Банк дангаар гаргаж, өөрчл
эрхтэй байх;

9.2.15. төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл эцэсл
боловсруулагдсанаар Банкны Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын газраас төслийн үр дүн
ирээдүйд бий болох хөрөнгийг үнэлж, барьцаалах, үнэлгээг бэлтгэн гийлүүлэлтийн гэрэ

Банк:

Зээлдэгчийг төлөөлж:

179

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАНАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

АСУУЛТ

2024 10 01 № 10

Шинэ хичээлийн боомт хэзх талаар

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өргадтай хийсэн уулзалт дээр Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Цагаан дэл уулаар шинэ боомт хэзх үйл ажиллагаат түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан байдаг Гэтэл боомтын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа одоог хүртэл явагдсаар байна Үүний улмаас нутгийн иргэд болон үйл ажиллагаа явуулахаар ирж буй компанийн хүмүүсийн хооронд үл ойлголцол гарч, таагүй нөхцөл байдал үүсэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хэлэлцэх шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Боомт хэзх үйл ажиллагаат түдгэлзүүлэх тухай Ерөнхий сайдын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар Засгийн Газраас ямар арга хэмжээ авсан талаар мэдээлэл;

2. Боомт хэзх үйл ажиллагаат түдгэлзүүлэх тухай Ерөнхий сайдын шийдвэр гарснаас хойш энэ хэсгээр удаа дараа түр хил нээн, барилгын материал оруулж ирсэн, бетон сууртай маш их хэмжээний төмөр хашаа барьж хятад хэнээр пайзжүүлэн, Монгол, Хятад нийлсэн олон хүн хил дээр ажиллаж, Монгол Улсын хилийн дархан байдал алдагдаж байна. Ерөнхий сайдын түдгэлзүүлсэн шийдвэр цуцлагдаагүй байхад ямар байгууллагын, ямар албан тушаалтны зөвшөөрлөөр ямар компани энэ боомтын үйл ажиллагаат явуулж буй талаар тодорхой мэдээлэл;

3. Боомттой холбоотой 270 км концессын гэрээтэй авто замын ажлын явц ямар шатанд яваа, цаашид үргэлжлэх, эсэх талаар болон концесс задарсан тул дахин концессын гэрээ байгуулах албан бус мэдээлэл байгаа тул үүний талаар тодруулга, мэдээлэл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хэлэлцэх шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Г.ГАНБААТАР

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

зураг төсөл, төсөв, бодитоор бий болсон байдал зэрэгт үндэслэн Банкны Эрсдэлийн үнэлг удирдлагын газраас тухай бүр шинэчлэн тогтоох;

9.2.16. хууль тогтоомж болон Гэрээнд заасан бусад эрхээ хэрэгжүүлэх.

Арав.Захиалагчийн эрх, үүрэг

10.1. Захиалагч дараах үүрэгтэй:

10.1.1. Зээлийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах, зээлдэгчийн үйл ажиллагаанд байнгы хяналт тавьж ажиллах;

10.1.2. Төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд Банкны оролцоог хангаж, шаардлагатай бүх л мэдээллээр хангах;

10.1.3. Төслийн гүйцэтгэл төлөвлөсөн хугацаанаасаа хоцрох, зогсох тохиолдо төслийг үргэлжлүүлэх талаар шаардлагатай бүх талын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэ

10.1.4. Зээлийн нийт төлбөр гэрээний 7.1-д заасны дагуу төлөгдөгдөхгүй бай тохиолдолд Банкинд эргэн төлөх, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулах шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах.

10.1.5. Үйлдвэрийн нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэл болон инженерий зураг төслийн хүрээнд үйлдвэр байгуулахад шаардагдах гаднах дэд бүтцийн бүтэ байгуулалтын ажил хэрхэн уялдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

10.2. Захиалагч дараах эрхтэй:

10.2.1. Зээлдэгчийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих.

10.2.2. Хууль тогтоомж болон Гэрээнд заасан бусад эрхээ хэрэгжүүлэх.

Арван нэг. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг

11.1. Хувьцаа эзэмшигч нь дараах үүрэгтэй:

11.1.1. Зээлийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах, зээлдэгчийн үйл ажиллагаанд байнгы хяналт тавьж ажиллах;

11.1.2. Төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд Банкны оролцоог хангаж, шаардлагатай бүхи л мэдээллээр хангах;

11.1.3. Төслийн гүйцэтгэл төлөвлөсөн хугацаанаасаа хоцрох, зогсох тохиолдол, төслийг үргэлжлүүлэх талаар шаардлагатай бүх талын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх.

11.1.4. Зээлийн нийт төлбөр гэрээний 7.1-д заасны дагуу төлөгдөхгүй байх тохиолдолд Банкинд эргэн төлөх, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах;

11.1.5. Үндсэн зээл болон хүүгийн эргэн төлөлтөд эрсдэл учирсан тохиолдолд эргэн төлөлтийг хариуцан төлж, барагдуулах.

11.2. Хувьцаа эзэмшигч нь дараах эрхтэй:

11.2.1. Зээлдэгчийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих;

11.2.2. Хууль тогтоомж болон Гэрээнд заасан бусад эрхээ хэрэгжүүлэх.

Арван хоёр.Үүргийн зөрчил, хүлээх хариуцлага

12.1. Банк нь Зээлдэгч Гэрээний 8.1, 8.3, 8.4 дэх хэсэгт заасан үүргээ зөрчсөн тохиолдолд, эсхүл дор дурдсан зөрчил гаргасан тохиолдолд тухайн үүргийн зөрчлийн шинж байдлаас шалтгаалан зөрчил арилгах талаар нэмэлт хугацаа тогтоох буюу тогтоохгүйгээр өөрийн санаачлагаар зээлийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцлан, зээл болон гэрээнд заасан бусад

Банк:

Худалдаа батлагаажсуулан гарын үсэг зурсан.

Зээлдэгчийг төлөөлж:

181

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

төлбөрийг хугацаанаас өмнө эргүүлэн төлөхийг шаардаж, Банкинд учирсан хохирлыг Г
холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ:

12.1.1.Зээлдэгч тухайн төслийг хэрэгжүүлэх эрхгүй болсон эсхүл төсөл б
шалтгаанаар хэрэгжих боломжгүй болсон нь Банк болон бусад эрх бүхий этгээдээс тогтоогд
12.1.2. зээлийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан, ашиглуулах нөхцөл бүрдүүл
зориулалт бусаар ашиглах гэж буй нь Банк болон бусад эрх бүхий этгээдээс тогтоогд
зээлийн зориулалтын талаарх мэдээ, мэдээллийг Банкнаас шаардсан хугацаанд гаргаж өгөө
худал, буруу, алдаатай мэдээлэл ирүүлсэн;

12.1.3. зээлийн төлбөрийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь бү
төлөөгүй;

12.1.4. зээл авах болон ашиглахтай холбоотой чухал ач холбогдол бүхий бар
бичгийг Банкнаас шаардсан хугацаанд Банкинд ирүүлээгүй буюу хуурамч материал бүрдүүл
болох нь Банк болон бусад эрх бүхий этгээдээс тогтоогдсон;

12.1.5. Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон
Банкны болон бусад эрх бүхий этгээдийн шалгалтаар тогтоогдсон, эсхүл дампуурах хүсэлт
холбогдох этгээдэд гаргасан;

12.1.6. Зээлдэгч төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх бүхий этгээдийн зөвшөөре
тусгай зөвшөөрлийг авааагүй, эсхүл тэдгээрийг түдгэлзүүлсэн, цуцалсан, хүчингүй болгосон;

12.1.7. Зээлдэгч нь Банкнаас санхүүжилт олгохыг хориглосон үйл ажиллагааг явуулса
нь Банк болон бусад эрх бүхий этгээдээс тогтоогдсон;

12.1.8. Зээлдэгчийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтад орсон өөрчлөлт н
Зээлдэгчийг зээлээ эргүүлэн төлж чадахгүйд хүргэх нь Банк болон бусад эрх бүхий этгээдэ
тогтоогдсон;

12.1.9. барьцаа хөрөнгийн чанар, үнэлгээ буурсан нөхцөлд Зээлдэгч барьцаа хөрөнгий
солих, эсхүл нэмж хөрөнгө барьцаалуулахаас татгалзсан;

12.1.10. Зээлдэгчийн орлогын мөнгөн урсгал багасаж, зээл төлөх чадвараас илт доогуу
болсон нь Банкны хяналт, шалгалтаар тогтоогдсон;

12.1.11. Зээлдэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн;

12.1.12. Зээлдэгч нь дээр дурдсанаас бусад зөрчил гаргасан нь төлбөрийн үүрэг
сөргөөр нөлөөлсөн бөгөөд Банкнаас шаардсан хугацаанд уг зөрчлийг арилгаагүй бол.

12.2.Гэрээний 12.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн бол Банк Зээлдэгчид алба
бичгээр мэдэгдэж, Зээлдэгчид тодорхой үндэслэл бүхий тайлбар өгөх боломжоор хангана. Банк
нэн даруй цуцлах шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд Зээлдэгчид гэрээний зөрчлийг
арилгах 30 хоногоос доошгүй хугацаатай мэдэгдэл өгнө.

12.3. Банк Гэрээний 12.2 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээ авсан нь үр дүнгүй болсон
бол Монгол Улсын Иргэний хууль, Барьцааны гэрээнд заасан журмын дагуу зээлийн гэрээний
үүргийн гүйцэтгэлийг хангуулах, худалдан борлуулах замаар зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн
хүүгийн төлбөр болон зээл төлүүлэхтэй холбогдон гарсан зардлыг төлүүлэхээр барьцааны эрхээ
хэрэгжүүлнэ.

12.4. Гэрээний 12.3 дахь хэсэгт заасны дагуу Барьцааны гэрээнд заасан хөрөнгөөр үүргийн
гүйцэтгэлийг хангуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Зээлдэгч нь гэрээний
үүргийг бусад эд хөрөнгөөр хариуцан төлнө.

12.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд гэрээний үүргийг
хангахтай холбогдон гарсан шүүхийн болон бусад зардлыг, түүнчлэн энэ хуйлд заасан журмын
дагуу гэрээ цуцалснаас учирсан хохирлыг Зээлдэгч хариуцна.

Банк:

Худалдыг баталгаажуулан гарын үсэг зурсан:

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

12.6. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал (байгал гамшиг, байлдааны ажиллагаа, хорио цээрийн дэглэм зэрэг Банкны хүсэл зоригоос үл хамаа нөхцөл байдал)-ын улмаас Банк зээл олгож чадаагүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

12.7. Зээлдэгч үүргээ биелүүлээгүй нь захиргааны зөрчил, эрүүтийн гэмт хэрэг шинжтэй бол Банкнаас төрийн эрх бүхий байгууллагад энэ талаарх мэдээлэл, материал хүргүүлж хуулийн дагуу хохирлоо нөхөмжилнө.

Арван гурав.Баталгаа, зөвшөөрөл

13.1. **Баталгаа:**

13.1.1.Зээлдэгч нь үйл ажиллагаагаа явуулах, төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах б зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу авсан байх ба хуульд заасан хугацаа сунгуулах, гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуустал хүчин төгөлдөр хэвээр байлгах үүр амлалтыг авч, баталгаа гаргаж байна.

13.1.2. Гэрээ байгуулах өдөр буюу түүнээс өмнөх хугацаанд хамрагдах Банки мэдэгдээгүй ямар нэгэн өр төлбөр, түүнтэй холбоотой маргаан, үүрэг, хариуцлага байхг бөгөөд Гэрээгээр авч буй зээлийг цаашид Зээлдэгчийн аливаа үйлдэл, эс үйлдлээс үүсэж бол аливаа өр төлбөр, зардал, хохирол, анз зэргээс ангид байлгахыг Зээлдэгч үүгээр баталж байна.

13.1.3. Зээлдэгч нь барьцааны зүйлтэй холбогдуулж аливаа гуравдагч этгээд, бус үүрэг гүйцэтгүүлэгчдийн өмнө үүрэг хүлээгээгүй болно.

13.2. **Бүрэн эрх** - Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар Зээлдэгч нь Гэрэ байгуулах болон Гэрээний нөхцөлүүдийг биелүүлэхдээ өөрийн эрх бүхий байгууллага шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан болно.

13.3. **Үнэн зөв мэдэгдэл** - Гэрээний дагуу Зээлдэгчээс, Банкинд гарган өгсөн бүх барим бичиг болон мэдээлэл, баталгаа нь бүгд үнэн зөв бөгөөд ямар нэгэн чухал хэргийн талаар худа мэдэгдээгүй, Гэрээ үнэн зөв болоход зайлшгүй шаардлагатай аливаа чухал хэргий орхигдуулаагүй болно. Хэрэв Зээлдэгчийн гаргаж өгсөн мэдээлэл буруу, алдаатай, худал байва үүнээс үүсэх үр дагавар, хохирол, хариуцлагыг Зээлдэгч хүлээнэ.

13.4. **Зөрчилдөөн байхгүй тухай** - Зээлдэгч Гэрээнд заасан хэлцлийн аливаа нөхцөлий урьдчилан гүйцэд уншиж танилцсан, Талууд Гэрээний бүх нөхцөлийн талаар харилцан саналаа илэрхийлж тохиролцсон бөгөөд Зээлдэгч нь Гэрээгээр тохирсон нөхцөлүүдийг биелүүлэх нь Зээлдэгчийн дүрэм, журам болон ижил төрлийн бусад баримт бичгийн нөхцөл болзолтой зөрчилдөхгүй бөгөөд эдгээр нөхцөл, болзлын дагуу аливаа хувь хүн буюу бусад байгууллага хуулийн этгээдээс зөвшөөрөл авах шаардлагагүй. Одоо байгаа болон ирээдүйд гарч болох шүүх, захиргаа, арбитрын шийдвэрийг биелүүлж байгаа Зээлдэгчийн үүрэг нь Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхэд ямар ч хэлбэрээр саад болохгүй. Зээлдэгч нь Гэрээ байгуулсан өдрөөс хойш Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ ямар нэгэн хэлбэрээр Гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

13.5. **Нууц хадгалах** - Талууд Гэрээ байгуулснаар мэдэх болсон нөгөө талынхаа болон түүний харилцагчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар нөгөө талдаа сергөөр нөлөөлөхүйц байдлаар ашиглахгүй, хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй.

13.6. **Мэдээлэл өгөх зөвшөөрөл:** Зээлдэгч нь Банкинд дараах мэдээллийг гуравдагч этгээдэд гаргаж өгөх, бүртгүүлэхийг үүгээр зөвшөөрч байна:

13.6.1. Гэрээний үндсэн үүрэг, гол нөхцөлийн талаарх мэдээлэл;

13.6.2.төрийн эрх бүхий байгууллагаас шаардсан зээлийн болон төсөл, төслийн ажлын мэдээлэл;

Банк:

Худалдаа баталгаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

183

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

13.6.3.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.1 болон 6 дугаар зүйлд дурдсан зээлі мэдээллийг Зээлийн мэдээллийн сан буюу зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд өгөхийг;

13.6.4.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан дагуу барьцаа хөрөнгийн болон холбогдох бусад мэдээллийг "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан"-д бүртгүүлж байхыг.

13.7. Эрх олгох тухай: Зээлдэгч нь дараах бүрэн эрхийг Банкинд үүгээр олгож байна:

13.7.1. Зээлдэгчийн өмнөөс зээл, баталгаа болон барьцааны гэрээг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх тухай хүсэлт, мэдүүлэг гаргах, мэдүүлэгт өөрчлөлт оруулах, гарын үсэг зурах, холбогдох гэрээ бүртгэгдэж гарахад гэрчилгээний хамт гардаж авах болон барьцааны зүйлийн лавлагаа, мэдээллийг эрх бүхий байгууллагаас авах зэрэг, бүртгүүлэхтэй холбоотой болон бүртгүүлсний дараах бүхий л үйлдэл хийх бүрэн эрх;

13.7.2.Зээлдэгч Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг зөрчиж эхэлсэн өдрөөс хойш улсын бүртгэл, хил, гааль, татвар, тээвэр цагдаагийн болон бусад асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад Зээлдэгчийн төлөөлөн лавлагаа, мэдээлэл авах, тэдгээр байгууллагад хандах бүрэн эрх.

Арван дөрөв.Бусад зүйл

14.1.Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр болж, гэрээний үүрэг бүрэн биелэгдсэнээс дуусгавар болно.

14.2.Гэрээ, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээнүүд нь Талууд, тэдгээрийн эрх залгамжлагч, үүрэг хүлээсэн авагч болон холбогдох эрх бүхий албан тушаалтны хувьд заавал биелэгдэх хүчинтэй байна.

14.3. Гэрээг 6 эх хувь үйлдсэн бөгөөд хувиуд хуулийн адил хүчинтэй байна.

14.4. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэх бөгөөд эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр гэж тооцогдоно.

14.5. Гэрээний хавсралт, нэмэлт, өөрчлөлтийн болон Барьцааны гэрээнүүд нь Гэрээний салшгүй хэсэг байна.

14.6.Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцаа, аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

14.7.Гэрээний үүргийн биелэлтийн явцад гарах маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.Зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

14.8.Гэрээтэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, албан бичгийг Талууд Гэрээнд заасан хаягаар хүргүүлнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд түүнийг нөгөө талдаа мэдээллээгүйгээс мэдэгдэл, албан бичиг хүрээгүйн хариуцлагыг тэдгээрийг хүргүүлсэн тал хариуцахгүй болно.

Банк:

Худалдаж баталгаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Хувьцаа эзэмшигчийг төлөөлж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга

Банкийг төлөөлж:

Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал

Б.БАТБАЯР

Зээлдэгчийг төлөөлж:

Монгол газрын т
боловсруулах
үйлдвэр ТӨХХК

захирал

Ж.ЭРДЭНЭОРОВ

Дэд захирал бөгөөд Төслийн санхүүжилт, зээлийн газрын захирал

Ч.МӨНХБАЯР

Төслийн зээл, санхүүжилтийн хэлтсийн захирал

Т.МӨНХТУЛГА

300

300,000

Банк:

Худалдаа баталгаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

Хянав. 12018.04.13/
Б.Нуруубурэн

185

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр байгуул
ЗГ-МГТ-З 2018-43 дугаартай Зээлийн гэрээний Хавс

ЗЭЭЛИЙН ОЛГОЛТ, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

№	Огноо	Зээл олголтын төлөвлөгөө	Үндсэн зээлийн эргэн төлөлт	Үндсэн хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үндсэн зэ үлдэгд
1	5/1/2018	287,466,750.00	-	-	-	287,466,750
2	6/25/2018	1,106,377,704.64	-	-	-	1,393,844,45
3	9/24/2018	54,862,748,089.41	-	-	-	56,256,592,5
4	12/24/2018	54,862,748,089.41	-	-	-	111,119,340,
5	3/25/2019	34,312,203,650.34	-	-	-	145,431,544,
6	6/25/2019	34,312,203,650.34	-	-	-	179,743,747,
7	3/25/2020	6,549,925,688.62	-	-	-	186,293,673,(
8	3/25/2021	6,549,925,688.62	-	-	-	192,843,599,3
9	3/25/2022	28,578,200,344.31	-	-	-	221,421,799,6
10	6/27/2022	28,578,200,344.31	-	-	-	250,000,000,0
11	8/1/2023		22,727,272,727.27	109,844,739,929.69	132,572,012,656.96	227,272,727,2
12	2/1/2024		22,727,272,727.27	13,622,415,940.22	36,349,688,667.50	204,545,454,5
13	8/1/2024		22,727,272,727.27	12,126,911,581.57	34,854,184,308.84	181,818,181,8
14	2/1/2025		22,727,272,727.27	10,897,932,752.18	33,625,205,479.45	159,090,909,09
15	8/1/2025		22,727,272,727.27	9,380,217,932.75	32,107,490,660.02	136,363,636,36
16	2/1/2026		22,727,272,727.27	8,173,449,564.13	30,900,722,291.41	113,636,363,63
17	8/1/2026		22,727,272,727.27	6,700,155,666.25	29,427,428,393.52	90,909,090,909
18	2/1/2027		22,727,272,727.27	5,448,966,376.09	28,176,239,103.36	68,181,818,181,
19	8/1/2027		22,727,272,727.27	4,020,093,399.75	26,747,366,127.02	45,454,545,454.
20	2/1/2028		22,727,272,727.27	2,724,483,188.04	25,451,755,915.32	22,727,272,727.
21	5/1/2028		22,727,272,727.27	666,313,823.16	23,393,586,550.44	(0)
22	НИЙТ	250,000,000,000.00	250,000,000,000.00	183,605,680,153.85	433,605,680,153.85	

Банк:

Худсыг батлагдсаныг гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

186

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

Талууд харилцан тохиролцож зээл олголт, эргэн төлөлтийн хуваарийг урьдчилсан байдлаа гаргав.

Гэрээний 5 дугаар зүйлд заасан цохцолийн дагуу зээл олголтыг хийнэ. Барьц хөрөнгийн үнэлгээ болон зээлийн бодит олголттой уялдуулан талууд зээл олголтын төловлөгө зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрөв.

Банкийг төлөөлж:

Монгол Улсын Хөгжлийн банкны
Үйлдвэр захирал

ХӨГЖЛИЙН БАНК
Б.БАТБАЯР

Дэд захирал бөгөөд Төслийн санхүүжилт,
зээлийн газрын захирал

Ч.МӨНХБАЯР

Төслийн зээл, санхүүжилтийн
хэлтсийн захирал

Т.МӨНХТУЛГА

Зээлдэгчийг төлөөлж:

"Монгол газрын тос бүтээгдэхүүнээр хангах үйлдвэр"
ТӨХК-ийн Ерөнхий захирал

Монгол
газрын тос
Д.ЭРДЭНЭБОЛД
ХХК

226

Хянав. 12098.04.12/
Бүр. Буурвэсүрэн

Банк:

Худалдаа батлагаажуулан гарын үсэг зурсан:

Зээлдэгчийг төлөөлж:

187

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар: ЗГ-МГТ-З 2018/43-1 | Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү гэрээ (Цаашид **"Гэрээ"** гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 323 болон 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 129 дугаар тогтоол, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоол болон 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 55 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А-278 дугаар тушаал болон Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 29 дугаар тогтоолыг тус тус үндэслэн,

нэг талаас, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-19, 11, 12 дугаар давхарт байрлах, улсын бүртгэлийн 9016001019, регистрийн 5461626 дугаартай **Монгол Улсын Хөгжлийн банк** (цаашид **"Банк"** гэх),

нөгөө талаас, Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэсний гудамж-5/2, Засгийн газрын II байр хаягт орших **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам** (цаашид **"Захиалагч"** эсхүл **"Хувьцаа эзэмшигч"** гэх),

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Сүхбаатарын талбай гудамж 8/1 байр, 1601 тоот хаягт орших регистрийн 6177492 дугаар, улсын бүртгэлийн 9011671052 дугаартай **"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК** (цаашид **"Зээлдэгч"** гэх) нар (цаашид хамтад нь **"Талууд"** гэх) тэдгээрийн хооронд 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан ЗГ-МГТ-З 2018-43 дугаартай Зээлийн гэрээ (цаашид **"Зээлийн гэрээ"** гэх)-нд нэмэлт, өөрчлөлт оруулахаар харилцан тохиролцож байгуулав.

Хоёр. Гэрээнд оруулах өөрчлөлт

2.1. Зээлийн гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулав. Үүнд:

2.1.1. Зээлийн гэрээний 3.1.3-т *"Зээлийн эхний олголтоос хойш 10 жил"* гэснийг *"2028 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл"* гэж өөрчлөх;

2.1.2.Зээлийн гэрээний 3.1.4-т *"Зээлийн зориулалт: Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төсөлд, нарийвчилбал төслийн хүрээнд хийгдэх авто зам, төмөр зам, цахилгаан, дулааны хангамж, үйлдвэрийн талбай бэлтгэх зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой ажлын зардал, төслийн зөвлөх үйлчилгээний болон компанийн үйл ажиллагааны зардалд зориулагдана. Үүнээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно"* гэснийг *"Зээлийн зориулалт: Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төсөлд,*

Банк:

Хүндэтгэн батлагдсан тухай
129

Зээлдэгчийг төлөөлж:

нарийвчилбал төслийн хүрээнд хийгдэх авто зам, төмөр зам, цахилгаан, дулааны хангамж, үйлдвэрийн талбай бэлтгэх зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой ажлын зардал, төслийн зөвлөх үйлчилгээний болон компанийн үйл ажиллагааны зардалд болон Газрын тосны үйлдвэрийн 549 айлын орон сууцны хотхоны барилгын ажлын санхүүжилтэд зориулагдана" гэж өөрчлөх;

2.1.3. Зээлийн гэрээнд 3 дугаар зүйлд *"3.1.4.а. Газрын тосны үйлдвэрийн 549 айлын орон сууцны хотхоны барилгад 47,522,582,682 төгрөг хүртэл санхүүжилт (2019 онд олгох санхүүжилт 20,159,300,000 хүртэл төгрөг)"* гэж нэмэх;

2.1.4.Зээлийн гэрээний 3.1.5-д *"үндсэн зээлийн эргэн төлөлт: 2023 оноос зээлийн хугацаа дуусах хүртэл хугацаанд тэнцүү дүнгээр хагас жил тутам;"* гэснийг **"Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа:** *2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл"* **гэж өөрчлөх;**

2.1.5.Зээлийн гэрээний 3.1.6-д *"зээлийн хүүгийн эргэн төлөлт: 2023 оноос зээлийн хугацаа дуусах хүртэл хугацаанд хагас жил тутам;"* гэснийг *"Үндсэн хүүгийн эргэн төлөлтийн хуваарь: 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс хагас жил тутам;"* **гэж өөрчлөх;**

2.1.6.Зээлийн гэрээний 3.1.13-т заасныг бүхэлд нь дараах байдлаар өөрчлөх; *барьцаа хөрөнгө: Зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаартай Барьцааны гэрээ (Ирээдүйд бий болох хөрөнгө), 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн БГ-МГТ-ГЭ 2018-95 дугаартай Газар эзэмших эрх барьцаалах гэрээ, 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн БГ-МГТ-ГЭ 2018-99 дугаартай Газар эзэмших эрх барьцаалах гэрээ, 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-100 дугаартай Барьцааны гэрээ (Ирээдүйд бий болох хөрөнгө), 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн БГ-МГТ-ИБХ 2019-108 дугаартай Барьцааны гэрээ (Ирээдүйд бий болох хөрөнгө), 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн БГ-МГТ-ГЭ 2019-109 дугаартай Газар эзэмших эрх барьцаалах гэрээнүүдэд дурьдсан хөрөнгүүд болно."* **гэж өөрчлөх;**

2.1.7. Зээлийн гэрээний 3.1.15-д *"Актив, пассив хөрөнгийн удирдлагын газрын дүгнэлтээр тодорхойлогдоно"* **гэснийг** *"МУХБ-ны өөрийн эх үүсвэр"* **гэж тус тус өөрчлөв.**

2.2. Зээлийн гэрээнд дор дурдсан заалтыг тус тус нэмэв:

2.2.1. Зээлийн гэрээний 8 дугаар зүйлд *"8.1.14. Туслан гүйцэтгэгч компаниудаас урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн баталгаа гаргуулах"* **гэж нэмэх;**

2.2.2. Зээлийн гэрээний 8 дугаар зүйлд *"8.1.15. Гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний үнийн дүнд өөрчлөлт оруулахгүй байх заалтыг тусгах"* **гэж нэмэх;**

2.2.3. Зээлийн гэрээний 8 дугаар зүйлд *"8.1.16. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг 30 хувь хүрсэн даруйд дуусаагүй барилгын гэрчилгээг гаргуулж, зээлийн барьцааны гэрээг байгуулах бөгөөд урьд өмнө байгуулсан ирээдүйд бий болох эд хөрөнгө барьцаалах гэрээг хүчингүйд тооцох"* **гэж нэмэх;**

2.2.4. Зээлийн гэрээний 8 дугаар зүйлд *"8.1.17. Үйлдвэрийн хотхоны холбогдох техникийн нөхцөлүүд, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, газрын гэрчилгээ зэргийг тухай бүр банкинд ирүүлэх"* **гэж нэмэх.**

129

Банк:

Худалдаа хөгжлийн банк

Зээлдэгчийг төлөөлж:

189

2.2.5. Зээлийн гэрээний 8 дугаар зүйлд *"8.2.7. Төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээ тайлан, төслийн хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тайлан, төслийн шинэчлэгдсэн төлөвлөгөө зэргийг тухай бүр Банкинд ирүүлж байх"* гэж нэмэх;

Гурав.Бусад зүйл

3.1. Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 323 дугаар тогтоолоор Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг тогтоосны дагуу Зээлийн гэрээнд заасан Хувьцаа эзэмшигч (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар)-ийн эрх, үүргийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хариуцах бөгөөд цаашид "Захиалагч" эсхүл "Хувьцаа эзэмшигч" гэнэ.

3.2. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарж, нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр болно.

3.3. Энэхүү гэрээ нь Зээлийн гэрээ болон түүнтэй холбоотойгоор байгуулсан Барьцааны гэрээнүүдийн салшгүй хэсэг болно.

3.4. Гэрээг 6 эх хувь үйлдсэн бөгөөд хувиуд хуулийн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Банкийг төлөөлж:	**Захиалагч, Хувьцаа эзэмшигчийг төлөөлж:**	**Зээлдэгчийг төлөөлж:**
Тэргүүн дэд захирал	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	Гүйцэтгэх захирал
Ч.ЭНХБАТ	Д.АМАРБАЯР	Д.АЛТАНЦЭЦЭГ
Дэд захирал бөгөөд Төслийн санхүүжилт, Зээлийн газрын захирал		
Ч.МӨНХБАЯР		

Хянав: Зээлийн үйл ажиллагаа хариуцсан
хуульч Т.Пүрэвсүрэн
2019.10.21

2019 10 22

Банк:

Худалдаж батлагдаагүйсан: Зээлдэгчийг төлөөлөх:

190

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БАРЬЦААЛАХ ГЭРЭЭ

2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар:БГ-МГТ-ГЭ 2019-109 | Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Газар эзэмших эрх барьцаалах энэхүү (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 13 дугаар бүлэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 0[illegible] дугаар сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоол болон 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 55 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А-278 дугаар тушаал болон "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн,

нэг талаас, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-19, 11, 12 дугаар давхарт байрлах, улсын бүртгэлийн 9016001019, регистрийн 5461626 дугаартай **Монгол Улсын Хөгжлийн банк** (цаашид **"Барьцаалагч"** гэх),

нөгөө талаас, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Сүхбаатарын талбай гудамж 8/1 байр, 1601 тоот хаягт орших регистрийн 6177492, улсын бүртгэлийн 9011671052 дугаартай **"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК** (цаашид "Барьцаалуулагч"гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гэрээний зорилго нь "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн хэрэгжүүлж буй "Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл" (цаашид "Төсөл" гэх)-ийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банк, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн хооронд 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан ЗГ-МГТ-З 2018-43 дугаартай Зээлийн гэрээ (цаашид "Зээлийн гэрээ" гэх)-ний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон Барьцаалуулагч өөрийн газар эзэмших эрхийг Барьцаалагчид барьцаалуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Барьцааны зүйл, барьцаагаар хангагдах шаардлага

2.1. **Барьцааны зүйл:** Барьцаалуулагч нь Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар дараах газар эзэмших эрх, түүний үр шим, захиран зарцуулснаас олсон орлогын хамт (цаашид **"Барьцааны зүйл"** гэх) барьцаалуулж байна:

№	Барьцааны зүйлийн байршил, зориулалт, талбайн хэмжээ	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Бүртгэсэн огноо, байгууллагын нэр, албан тушаалтны дугаар	Өөр этгээдийн барьцаанд байгаа эсэх	Барьцааны зүйлийн талаар гуравдагч этгээдийн эрх	Барьцаалбараар гэрчлэг дэх эсэх	Барьцааны зүйлийн харилцан тохиролцсон үнэлгээ

Барьцаалагч: Барьцаалуулагч:

191

1.	Дорноговь аймаг, Сайншанд сум, Жанчив 0 хаягт байрлах, Ажилчдын орон сууцны хотхон зориулалттай, 110,800.0 мкв газар	Эрхийн улсын бүртгэлийн дугаар: Э-0713000422 Гэрчилгээний дугаар: 009003296 НӨД: 4410087088	2019 оны 7 дугаар сарын 19-ний өдөр, Газрын асуудал эрхэлсэн байгууллага	-	Үгүй	Үгүй	1,396,080,000

2.2. Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ: 1,396,080,000 (Нэг тэрбум гурван зуун ерэн зургаан сая наян мянган) төгрөг. Барьцааны зүйлийн үнэлгээ өссөн тохиолдолд барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээг Зээлийн гэрээнд заасны дагуу 250,000,000,000 (Хоёр зуун тавин тэрбум) хүртэл төгрөгийн зээл болон зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, Барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал, Барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал уг эд хөрөнгетэй холбоотойгоор төлсөн татвар хураамж, төлбөр холбогдох бусад зардал болон барьцаалагчид учирсан бусад хохирлын нийлбэрээр тодорхойлно.

2.3. Барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх: Барьцаагаар хангагдах үүргийг Зээлийн гэрээнд тодорхойлсон зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

2.4. Зээлийн гэрээний үүрэг зөрчигдөх үед барьцаалагч нь барьцааны зүйлийн зах зээлийн үнэлгээ буюу түүнийг худалдан борлуулсан, шилжүүлсэн болон бусад хэлбэрээр захиран зарцуулсны орлогыг бүрэн хэмжээгээр Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахад зарцуулна.

2.5. Барьцааны зүйлийн эзэмшил: Барьцааны зүйл Барьцаалуулагчийн эзэмшилд байна.

2.6. Барьцаалагчийн зөвшөөрөл: Барьцаалуулагч нь Барьцааны зүйлийг бусдад давхар барьцаалуулах зэргээр аливаа хэлбэрээр Барьцааны зүйлд үүрэг ногдуулах болон эзэмших эрх нь барьцаалагдсан газар дээр барилга, байгууламж барих бол Барьцаалагчид 14-өөс доошгүй хоногийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдсэн байна.

2.7. Барьцааны зүйлийг өөрчлөх: Гэрээнд заасан Барьцааны зүйлийг Барьцаалагчийн шаардлага эсхүл зөвшөөрлөөр, бичгээр хийсэн гэрээний дагуу өөрчилж болно. Барьцааны зүйл өөрчлөгдөх нь Гэрээ болон Зээлийн гэрээг өөрчлөх, цуцалж, хүчингүй болгох, дуусгавар болох үндэслэл болохгүй.

2.8. Барьцаалагчийн шаардлагаар дараах тохиолдлуудад Барьцаалуулагч нь нэн даруй Барьцааны зүйл болон түүний тодорхой хэсгийг нэмэгдүүлэх буюу Барьцаалагчийн бичгээр тогтоосон үнийн хэмжээнд өөрийн өмчлөл, эзэмшлийн бусад хөрөнгө, эрхийг нэмж барьцаална. Үүнд:

2.8.1. аливаа шалтгаанаар Барьцаалуулагчийн газар эзэмших эрх дуусгавар болсон;

2.8.2. Барьцааны зүйл бүхэлдээ болон хэсэгчлэн үрэгдэх эсвэл бүрэн бүтэн байдалд нь харшлах нөхцөл үүссэн;

2.8.3. Барьцааны зүйлийн үнэ цэнэ буурсан.

2.9. Гэрээний 2.8-д заасан тохиолдолд бий болсон нөхцөл байдлаас гадна эдгээр нөхцөл байдлууд ирээдүйд бий болох нь тодорхой болсныг мэн ойлгоно.

2.10. Барьцаалуулагчийн баталгаа, зөвшөөрөл:

2.10.1. Барьцааны зүйлийн хууль ёсны эзэмшигч мөн болох Барьцааны зүйлд аливаа гуравдагч этгээдийн барьцааны эрх, шаардах эрх үүсээгүй, Барьцааны зүйл нь эрхийн зөрчилгүй, бие байдлын доголдолгүй болно.

2.10.2. Барьцаалуулагч нь Гэрээ дуусгавар болох хүртэлх хугацаанд Барьцааны зүйлтэй холбоотой аливаа мэдээлэл, лавлагаа, эрх бүхий байгууллага, этгээдээс авах

Худалдан авагчийн

Барьцаалагч: Барьцаалуулагч:

эрхийг Барьцаалагчид үүгээр олгож байна. Барьцааны зүйлийн эзэмших эрхийн гэрчилгээ нь эх хувираа Барьцаалагчийн эзэмшилд хадгалагдана.

2.10.3. Барьцаалагч Барьцааны зүйлийг газар дээр нь шалгах, Барьцааны зүйлийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад (тухайлбал харьяалагдах өмчийн харилцааны газар, татварын алба гэх зэрэг барьцааны зүйлтэй холбоо бүхий бусад эрх бүхий байгууллага) хадгалагдаж буй Барьцааны зүйл, түүний шилжилт, хөдөлгөөний талаарх баримт бичиг болон бусад холбогдох мэдээллийн талаарх лавлагааг гаргуулах, Гэрээний биелэлтэд хяналт тавих эрхтэй. Барьцаалуулагч нь Барьцаалагчийг энэхүү хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх бүх нөхцөлийг бүрдүүлнэ. Хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа саад тотгор учруулсан тохиолдолд Барьцаалагч нь Зээлийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, зээл болон зээлийн гэрээнд заасан бусад төлбөрийг төлөхийг шаардах эрхтэй.

2.11. Барьцаалсан зүйлийг Барьцаалуулагчийн эзэмшил, ашиглалтанд үлдээсэн бөгөөд түүний бүрэн бүтэн байдал, хэвийн ашиглалтын горим, холбогдох төлбөр, арчилгаа үйлчилгээ, нөхөн сэргээлт болон Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүрэг зэргийг Барьцаалуулагч хариуцна. Энэ үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх бүхий л хор уршгийг Барьцаалуулагч өөрийн бусад хөрөнгөөр арилгах болон Барьцааны зүйлийг орлуулах бусад барьцаа хөрөнгийг барьцаалах үүрэгтэй.

2.12. Барьцааны зүйлийн эзэмших эрх өөр этгээдэд аливаа хэлбэрээр шилжсэн тохиолдолд барьцааны эрх хүчин төгөлдөр хэвээр хадгалагдах бөгөөд Барьцааны зүйлийн талаар Гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө болоод хойш хийсэн аливаа гэрээ, хэлцэл, амлалт, ойлголтууд (хэрэв тийм зүйл байсан бол) Барьцаалагчийн хувьд үл хамаарах ба хүчин төгөлдөр бус гэж тооцогдоно.

2.13. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гэнэтийн ослын улмаас Барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдалд гарч болох элэгдэл хорогдол, учирсан хохирлыг Барьцаалуулагч тал бүрэн хариуцна. Энэ нь зээл, түүний хүүгийн болон бусад төлбөрийг төлөх гэрээний нөхцөлд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.

2.14. Барьцааны зүйлийг захиран зарцуулснаас олсон орлого гэж барьцаа хөрөнгийг худалдан борлуулах болон бусад байдлаар гүйлгээнд оруулснаас олсон эд хөрөнгө, мөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгө, барьцаа хөрөнгө гэмтсэн, устсантай холбоотой гэм хор учруулсны төлбөр, дайчлан гаргуулсны нөхөх олговор болон даатгалын нөхөн төлбөрийг хэлнэ.

Гурав.Талуудын эрх, үүрэг

3.1. Барьцаалуулагч дараах эрхтэй:

3.1.1. барьцаагаар хангагдах үүрэг бүрэн биелэгдсэн тохиолдолд Барьцааны зүйлийг барьцаанаас суллахыг шаардах;

3.1.2. Барьцаалуулагч нь Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Барьцаалагчаас гаргуулах;

3.1.3. Барьцааны зүйлийг худалдан борлуулсан болон бусдад шилжүүлсний орлогоос Гэрээнд заасан Барьцаалагчийн шаардлага хангагдсаны дараа үлдсэн мөнгөн хөрөнгийг авах.

3.2. Барьцаалуулагч дараах үүрэгтэй:

3.2.1. Барьцааны зүйлийн ашиглалт, үйл ажиллагаатай холбоотой бүхий л татвар, төлбөр, хураамжийг хугацаанд нь төлөх;

3.2.2. Барьцааны зүйл нь талуудын хооронд байгуулсан гэрээ, хэлцэл болон хууль тогтоомжийг зөрчин, гуравдагч этгээдэд барьцаалагдах, үрэгдэх, устах, дутах, гэмтэх, үнэлгээ буурах, үүний улмаас Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахгүй болох тохиолдолд Барьцаалуулагч бусад эд хөрөнгөө нэн даруй барьцаалах, хохирлыг бүрэн хариуцах;

3.2.3. Барьцааны зүйлийг нөхөн олговортойгоо дайчлан авсан болон сольсон тохиолдолд нөхөн олговор, солигдсон хөрөнгөөр Зээлийн гэрээний үүргийг тэргүүн зэлжид

Барьцаалагч:

Барьцаалуулагч:

Хүүдэр баталгаажуулсан
129

193

гүйцэтгэх, нөхөн төлбөрийг хугацаа нь болоогүй үүргийн гүйцэтгэлийн хувьд барьцааны зүйл болгон тооцуулах;

3.2.4. бусдын хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар барьцаалуулсан, барьцаа хөрөнгийн бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлснээс үүсэх хариуцлагыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүлээж, Барьцаалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцах;

3.2.5. Барьцааны зүйлийг бүхэлд нь болон хэсэгчлэн хураах, битүүмжлэх, төрийн өмчид шилжүүлэх, дайчлах, аливаа гуравдагч этгээдээс Барьцаалуулагчийн эсрэг эд хөрөнгө гаргуулах тухай нэхэмжлэл шүүх, арбитрт гаргах болон адилтгах бусад байдлаар эд хөрөнгийн эрхэд халдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Барьцаалагчид нэн даруй мэдэгдэх;

3.2.6. Барьцааны гэрээнд талууд гарын үсэг зурмагц, нотариатаар гэрчлүүлж, харьяалах газрын алба болон улсын бүртгэлд бүртгүүлэх;

3.2.7. Барьцаалуулагч нь барьцаагаар хангагдах үүргийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах;

3.2.8. иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

3.2.9. Барьцааны зүйлээс үл маргах журмын дагуу үүргийн гүйцэтгэлийг хангуулах Барьцаалагчийн эрхийг нотариатын мэдэгдэх хуудсаар баталгаажуулж өгөх;

3.2.10. энэ гэрээ болон хууль д заасан бусад үүрэг.

3.3. Барьцаалагч дараах эрхтэй:

3.3.1. Барьцааны зүйлийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шалгах;

3.3.2. Барьцаалуулагч Барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах үүргээ биелүүлээгүй бол Барьцааны зүйлийг өөрийн эзэмшилд шилжүүлэх, үүнтэй холбогдон гарах бүх зардлыг Барьцаалуулагчаас шаардах;

3.3.3. Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх Барьцаалагчид үүссэн тохиолдолд барьцааны зүйлийг худалдах болон худалдсан болон бусад этгээдэд шилжүүлэхийг шаардах, төлберт тооцож авах, шилжүүлэх тохиолдолд мэргэжлийн байгууллагын үнэлгээг үндэслэн харилцан тохиролцсон үнэлгээг бууруулах эрхтэй;

3.3.4. Гэрээ болон хууль д заасан бусад эрх.

3.4. Барьцаалагч дараах үүрэгтэй:

3.4.1. барьцаагаар хангагдах үүрэг биелсэн тохиолдолд Барьцааны зүйлийг чөлөөлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг Барьцаалуулагчид хүлээлгэн өгөх;

3.4.2. Барьцаалуулагчид Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг гарган өгөх.

Дөрөв.Барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангах журам

4.1. Зээлдэгч нь Зээлийн гэрээнд заасан хугацаа, хуваарийн дагуу зээл, түүний хүүг төлөөгүй, мөн гэрээгээр хүлээсэн үүргээ Зээлдэгч, Барьцаалуулагч нь биелүүлээгүй тохиолдолд Барьцаалагч үүргийн гүйцэтгэлийг албан бичгээр шаардана.

4.2. Гэрээний 4.1-д заасан албан бичигт дурдсан хугацаанд Зээлдэгч, Барьцаалуулагч нь үүргээ биелүүлээгүй бол Барьцаалагч энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, Барьцаалуулагч болон тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэлийг Барьцааны зүйлээс хангуулах тухайгаа албан бичгээр мэдэгдэнэ.

4.3. Гэрээний 4.2-т заасан мэдэгдэлд хуанлийн 30 хоногийн дотор Барьцаалуулагч хариу өгөөгүй буюу үүргээ биелүүлээгүй бол Барьцаалагч нь барьцааны зүйлийг шүүхийн журмаар худалдах ажиллагааг эхлүүлнэ.

4.4. Барьцааны зүйлд хэд хэдэн газар эзэмших эрх байгаа тохиолдолд Барьцаалагч нь барьцааны зүйл тус бүрээс үүргийн гүйцэтгэлээ бүхэлд нь хангахад ашиглах бөгөөд Барьцаалагч аль газар эзэмших эрхээс үүргийн гүйцэтгэлээ хангуулахыг дангаар сонгоно.

Худалдаа [illegible] 129

Барьцаалагч: Барьцаалуулагч:

Тав.Бусад зүйл

5.1. Гэрээнд Талууд гарын үсэг зурж, тамга, тэмдгээ дарж, нотариатаар гэрчлүүлж, эрх бүхий байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

5.2. Гэрээ нь Зээлийн гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелэгдэх хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байж, Зээлийн гэрээний үүрэг бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.

5.3. Гэрээ нь Барьцаалагч, Барьцаалуулагчийн хооронд байгуулсан Зээлийн гэрээ болон тус гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан бусад барьцааны гэрээнүүдийн салшгүй хэсэг болно.

5.4. Гэрээтэй холбоотой аливаа мэдэгдэл, албан бичгийг талууд Гэрээнд заасан хаягаар илгээнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд мэдэгдэх нь талуудын үүрэг ба хаяг өөрчлөгдсөнөөс мэдэгдэл, албан бичиг хүргүүлсэн тал хариуцахгүй болно.

5.5. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талууд гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарж, нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр гэж тооцогдоно.

5.6. Гэрээнд хэрэглэсэн нэр томъёог Гэрээнд өөрөөр заагаагүй бол Зээлийн гэрээнд заасан утгаар ойлгоно.

5.7. Гэрээний аль нэг заалт, бүлэг хүчингүй болсон нь барьцааны эрхийг дуусгавар болгохгүй.

5.8. Барьцааны зүйл болох эзэмших эрхтэй газрын кадастрын зураг, газар эзэмшүүлэх шийдвэр, иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний хуулбар нь гэрээний салшгүй хэсэг байна.

5.9. Гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсад дагаж мөрдөгдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.

5.10. Гэрээг 5 хувь үйлдсэн бөгөөд хувиуд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Барьцаалагчийг төлөөлж:

Тэргүүн дэд захирал

Ч.ЭНХБАТ

Дэд захирал бөгөөд Төслийн санхүүжилт, Зээлийн газрын захира

Ч.МӨНХБАЯР

Барьцаалуулагчийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

Д.АЛТАНЦЭЦЭГ

129

Хянав: Зээлийн үйл ажиллагаа хариуцсан
хуульч Т.Пүр
2019.10.21

2019 10 22

Барьцаалагч:

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

Нэгж талбарын дугаар: 4410087088


Хуулийн этгээдийн нэр: Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК Алтанцэцэг

Ашиглалтын төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 6177492

ХАЯГ: Аймаг/Хот:Дорноговь Сум/Дүүрэг: Сайншанд Баг/Хороо: 6-р баг Кадастрын муж: 087

Гудамж: Жвичив тоот: 0



Орчны тойм:

Орчны тойм:



Масштаб = 1:50000

Координатын систем:
WGS84 / UTM 49N
EPSG: 32649

Талбайн хэмжээ: 110800 квадрат метр

Зураг хэвлэсэн: ..... А.Анхилдэл

(Кадастрын асуудал эрхэлсэн мэргэжилтэн)

Хянасан: ..... Ц.Оюунсайхан

(Дарга)

Зөвлөсөн масштаб = 1:5000 (1 сантиметрт 50 метр багтана) Хэвлэсэн огноо: 2019-07-16

195

196

Гудамж: Жанчив

тоот: 0

Кадастрын муж: 087

Нэгж талбар

№	X	Y	урт
1	429708.05	4970617.33	402.17
2	430066.72	4970794.94	150.24
3	430134.73	4970660.04	55.30
4	430085.51	4970634.88	85.76
5	430122.62	4970557.60	29.26
6	430148.84	4970570.56	58.83
7	430175.02	4970517.89	102.17
8	430083.45	4970472.64	5.06
9	430081.21	4970477.18	27.16
10	430056.84	4970465.22	241.29
11	429840.62	4970358.30	2.78
12	429838.13	4970357.07	22.98
13	429827.88	4970377.63	268.07

Барилга

№	X	Y	урт	Барилын дулаан/Талбай

197

МОНГОЛ УЛС

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 000003296

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК / 6177492 /-д
(байгууллагын нэр) (регистрийн дугаар)

Аймгийн Засаг даргын захирамж -ын 20 19 оны 06 сарын 13 өдрийн А520 тоот
(шийдвэр гаргагч)

шийдвэрийг үндэслэн Дорноговь Сайншанд /
(аймаг, нийслэл) (сум, дүүрэг) (баг, хороо)

Жанчив 0 хаягт
(гудамжны нэр) (хашааны дугаар/ тоот)

байрлах, нэгж талбарын 4410087088 дугаар бүхий 110800.0 /11.08/ м.кв /га/ газрыг

Ажилчдын орон сууцны хотхон зориулалтаар

15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-0713000422

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
БАЙГУУЛЛАГА / АЛБАН ТУШААЛГАН

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ДАРГА

ТАМГА / ТЭМДЭГ / Ц.Оюунсайхан /
(нэр)

20 19 оны 7 сарын 19 өдөр

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, гарын
1	" Монгол Улсын Хөгжлийн банк"-ны 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ЗГ-МГТ-З 2018-43 тоот зээлийн гэрээг үндэслэн барьцаанд бүртгэв.	2019.10.23	А.Анхилдэл

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Газар эзэмших эрхийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

199

Терийн банк

Огноо: 2019/10/23

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ

Харилцагчийн нэр: Дорноговь аймгийн ГХГЗБГазар
Регистрийн дугаар: 6177492
Төлбөрийн мэдээлэл

Журналын №: 588614
Теллер №: 8924

№	Тайлант огноо	Татварын төрөл	Нэхэмжлэх, хөрөнгийн дугаар	Терийн сангийн дансны данс, нэр	Дүн
1	2019	Улсын тэмдэгтийн хураамж	2191003367906	100061300941 До.Са Улсын тэмдэгтийн хураамж	10,000.00
Нийт татварын дүн					10,000.00
Гүйлгээний шимтгэл					300.00

Нийт төлөх дүн: 10,300.00

Данс эзэмшигч 1 нэр: .....
Гарын үсэг.....


Данс эзэмшигч 2 нэр: .....
Гарын үсэг.....

Терийн банк ...../Салбар, тооцооны тев, касс/

Банкны ажилтны нэр, гарын үсэг, тэмдэг/...../

Танд баярлалаа

https://192.168.20.86:83/Tax/TaxPrintLeasp?selectValue=payNo&value=588614



Тебирийн даалгавар 4

2019 оны 04 сарын 08 өдөр

Дүн: 2,310,425.00

201

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2023 оны 8 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар: ЗГ-МГТ-З 2018-43/3 | Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү гэрээ (цаашид **"Нэмэлт, өөрчлөлтийн гэрээ"** гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 34 дүгээр тогтоол, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн,

нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, 11, 12 дугаар давхарт байрлах, улсын бүртгэлийн 9016001015 регистрийн 5461626 дугаартай **Монгол Улсын Хөгжлийн банк ХХК** (цаашид **"Банк"** гэх)

нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг 900 тоот хаягт байрлах, улсын бүртгэлийн 9011671052, регистрийн 6177492 дугаартай **"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК** (цаашид "Зээлдэгч" гэх) нар (хамтад нь "Талууд" гэх) нь талуудын хооронд 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан ЗГ-МГТ-З 2018-43 дугаартай Зээлийн гэрээ, 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан ЗГ-МГТ-З 2018-43/1 дугаартай Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ, 2021 оны 7 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан ЗГ-МГТ-З 2018-43/2 дугаартай Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ (цаашид хамтад нь "Зээлийн гэрээ" гэх)-нд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахаар харилцан тохиролцож байгуулав.

Хоёр. Гэрээний нэмэлт, өөрчлөлт

2.1. Зээлийн гэрээнд дараах нэмэлтийг оруулав:

2.1.1. Зээлийн гэрээний 3.1.16-д *"Зээлийн нөхцөл өөрчлөгдсний шимтгэл: Банкны 2023 оны сүүлийн хагас жилд барицтлах хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлийн дагуу 50.0 сая төгрөг 1 удаа төлнө."* гэж нэмэх.

2.2. Зээлийн гэрээнд дараах өөрчлөлтийг оруулав:

2.2.1. Зээлийн гэрээний 3.1.2-т *"зээлийн хүү: Жилийн 11.89% (арван нэг зуны наян есөн хувь)"* гэснийг *"зээлийн хүү: Жилийн 14.26% (Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн энэ хүүгээр тооцно)"* гэж өөрчлөх;

2.2.2. Зээлийн гэрээний 3.1.5-д *"үндсэн төлбөрөөс төлөвлөх хугацаа: 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл"* гэснийг *"үндсэн зээлийн эргэн төлөлт: 2027 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс хагас жил тутам тэнцүү дүнгээр төлөх"* гэж өөрчлөх;

2.2.3. Зээлийн гэрээний 3.1.6-д *"Үндсэн хүүгийн эргэн төлөлтийн хуваарь: 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс хагас жил тутам"* гэснийг *"зээлийн хүүгийн эргэн төлөлт: 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдөр хүртэл зээлийн үлдэгдлээс тооцогдох хүүг 2026 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс хагас жил бүр тэнцүү хуваан 2 удаа төлөх, цаашид хагас жил тутам төлөх"* гэж өөрчлөх;

2.2.4. Зээлийн гэрээний 3.1.7-д заасан Зээлийн эргэн төлөлтийн хуваарь: Хавсралт 1 *(Зээлийн олголт, эргэн төлөлтийн хуваарь)-г* энэхүү гэрээний хавсралтаар;

2.2.5. Зээлийн гэрээний 3.1.13-т заасан барьцаа хөрөнгийг дараах байдлаар өөрчлөх:

Банкийн төлөөлөх: *Хуудсыг баталгаажуулсан:* *Зээлдэгчийн төлөөлөх:*

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

№	Барьцаа хөрөнгийн төрөл	Үнэлгээ (төгрөг)
1	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж /32 айл/ тоот хаягт байршилтай 3,374.36 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 60%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713006852	1,440,480,787
2	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж /95 айлын 2-р барилга/ тоот хаягт байршилтай 8,638.56 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 68%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713006853	4,680,009,222
3	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж 40-4 тоот хаягт байршилтай 3,424.68 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713006854	2,891,193,000
4	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж /95 айлын 1-р барилга/ тоот хаягт байршилтай 8,638.56 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 86%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713006855	6,783,994,695
5	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж хаягт байршилтай 5,302.89 м.кв талбайтай, оффисын зориулалттай, 45.8%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713006856	4,092,193,892
6	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж 95 байр /3-р барилга/ тоот хаягт байршилтай 8,638.56 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 31.6%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713007165	2,210,705,562
7	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж 40 байр /5-р барилга/ тоот хаягт байршилтай 3,424.68 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 31.6%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713007166	667,967,522
8	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж 40 байр /6-р барилга/ тоот хаягт байршилтай 3,424.68 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 58.5%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713007167	1,107,363,422
9	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж 40 байр /7-р барилга/ тоот хаягт байршилтай 3,424.68 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 36.4%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713007168	980,247,391
10	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж 32 байр /10-р барилга/ тоот хаягт байршилтай 3,374.26 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 31.6%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713007169	826,138,096
11	Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р баг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн гудамж 40 байр /8-р барилга/ тоот хаягт байршилтай 3,424.68 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай, 31.6%-ийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд, хөрөнгө; Y-0713007170	885,404,720
12	Ажилчдын хотхоны инженерийн шугам сүлжээний байгууламж	3,543,805,922
13	Ажилчдын хотхоны гадна тохижилт	497,208,503

Банкийг төлөөлж:

Худалдыг батлагаажуулсан:

Зээдэгчийг төлөөлж:

203

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

№	Барьцаа хөрөнгийн төрөл	Үнэлгээ (төгрөг)
14	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа хаягт байршилтай 96.3 м.кв талбайтай, цахилгаан дамжуулах дэд станц зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө; Y-0702000045	177,843,915
15	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа хаягт байршилтай 263.85 м.кв талбайтай, төмөр замын өртөө зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө; Y-0702000046	699,245,619
16	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа баг хаягт байрлах 1,650,347 м.кв талбайтай, төмөр замын хамгаалалтын зурвас зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000073	3,300,694,000
17	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа баг хаягт байрлах 862,186 м.кв талбайтай, хатуу хучилттай зам зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000074	51,731,160
18	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа баг хаягт байрлах 551,640 м.кв талбайтай, эрчим хүч дамжуулах шугам зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000075	330,984,000
19	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000098	6,000,000
20	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 31,422 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000123	18,853,200
21	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000125	6,000,000
22	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 377,859 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000126	226,715,400
23	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000127	6,000,000
24	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 78,000 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000128	46,800,000
25	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 78,166 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000129	46,899,600
26	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 128,734 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000130	77,240,400
27	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000131	6,000,000
28	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000132	6,000,000

Банкийг төлөөлж:

Хүндэтгэж батлагдажуулсан:

Зээлдэгчийг төлөөлж:

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

№	Барьцаа хөрөнгийн төрөл	Үнэлгээ (төгрөг)
29	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000133	6,000,000
30	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 159,220 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000134	95,532,000
31	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000135	6,000,000
32	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000136	6,000,000
33	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000137	6,000,000
34	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 252,226 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000139	151,335,600
35	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 119,835 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000141	71,901,000
36	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 346,107 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000142	207,664,200
37	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 46,932 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000143	28,159,200
38	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000144	6,000,000
39	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 35,069 м.кв талбайтай, цэвэр ус дамжуулах хоолой зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000145	21,041,400
40	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000146	6,000,000
41	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2-р баг хаягт байрлах 10,000 м.кв талбайтай, ус түгээх, шахах, өргөх байгууламж зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0702000147	6,000,000
42	Дорноговь аймгийн Сайншанд сумын 4-р баг хаягт байрлах 198,838 м.кв /4.022 км/ талбайтай, төмөр зам бүхий далан зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0713001155	1,163,360,400
43	Дорноговь аймгийн Сайншанд сумын 4-р баг хаягт байрлах 145,900 м.кв /2.43 км/ талбайтай, төмөр зам бүхий далан зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0713001165	853,466,500

Банкийг төлөөлж:

Хүндэс батлагаажуулсан:

Зээлдэгчийг төлөөлж:

205

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

№	Барьцаа хөрөнгийн төрөл	Үнэлгээ (төгрөг)
44	Дорноговь аймгийн Сайншанд сумын 4-р баг хаягт байрлах 185,774 м.кв /4.317 км/ талбайтай, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0713001175	673,430,750
45	Дорноговь аймгийн Сайншанд сумын Жанчив гудамж хаягт байрлах 110,800 м.кв талбайтай, ажилчдын орон сууцны хотхон зориулалттай, эзэмших эрхтэй газар; Э-0713000422	321,320,000
46	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа хаягт байрлах 106,638 м.кв талбайтай, үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалттай, ашиглах эрхтэй газар; А-0702000007	-
47	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа хаягт байрлах 150 га талбайтай, үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалттай, ашиглах эрхтэй газар; А-0702000008	-
48	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа хаягт байрлах 2,288,162 м.кв талбайтай, үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалттай, ашиглах эрхтэй газар; А-0702000009	-
49	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р баг, Хаяа хаягт байрлах 157,079 м.кв талбайтай, үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалттай, ашиглах эрхтэй газар; А-0702000013	-
50	Төмөр замын Сайншанд өртөөнөөс үйлдвэрийн байршил хүртэл нийт 20 км төмөр зам	66,425,817,677
51	Сайншанд өртөөнөөс үйлдвэрийн байршил хүртэл хүнд даацын зориулалттай 20 км авто зам	31,854,211,662
52	Сайншанд өртөөнөөс үйлдвэрийн байршил хүртэл 20 км өндөр хүчдэлийн цахилгааны дамжуулах агаарын шугам	5,199,681,297
53	Үйлдвэрийн талбай, хашаа	6,331,053,424
54	Ажилчдын хотхоны 549 айлын 10 блок барилга, оффисын зориулалттай 1 блок барилга	20,723,097,695
55	Ажилчдын хотхоны инженерийн шугам сүлжээний байгууламж	300,555,127
56	Ажилчдын хотхоны гадна тохижилт	1,991,314,012
57	Үйлдвэрийн талбай, хашаа	374,011,981
	НИЙТ ДҮН	171,643,193,953

2.2.6. Зээлийн гэрээний 3.1.14.в-д "*Барьцаа хөрөнгийг Эрдэлийн газраар ажлын шугамаар үнэлүүлэн, зээл барьцаа хөрөнгийн харьцааг хангуулан зээлийг хэсэгчлэн олгоно*" гэснийг "*Барьцаа хөрөнгийг Эрдэлийн газраар үнэлүүлэн, зээл барьцаа хөрөнгийн харьцааг хангуулан зээлийг хэсэгчлэн олгоно*" гэж өөрчлөх;

2.3. Зээлийн гэрээнээс дараах заалтыг хасав:

2.3.1. Зээлийн гэрээний 5.1.8-д "*Жил бүрийн санхүүжилтийн хэмжээг энэхүү ТУЗ-ийн тогтоолын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, компанийн эрх барих дээд байгууллагаас батлагдсан тухайн жилийн эдийн засгийн үзүүлэлтийн зорилтот түвшин, зээл санхүүжилтийн хэмжээнд үндэслэн Зээлийн удирдлагын хорооны хуралаар шийдвэрлэх*".

Гурав. Бусад зүйл

3.1. Зээлийн гэрээний дагуу энэхүү нэмэлт, өөрчлөлтийн гэрээ байгуулагдах өдөр хүртэл тухайн зээлд бодогдсон нэмэгдүүлсэн хүүг зээлдэгч нь бүрэн төлнө.

3.2. Нэмэлт, өөрчлөлтийн гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчдөд гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарж, нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр болно.

51

Хүүдсыг батлагдаагүйсан:

Банкийг төлөөлөх:

Зээлдэгчийг төлөөлөх:

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

3.3. Энэхүү гэрээ нь Зээлийн гэрээ, түүний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан бусад гэрээнүүдийн салшгүй хэсэг болох бөгөөд энэ гэрээгээр өөрчилснөөс бусад заалтууд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

3.4. Энэ гэрээг 5 (тав) эх хувь үйлдсэн бөгөөд хувиуд хуулийн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Монгол Улсын Хөгжлийн банкийг төлөөлөх

гүйцэтгэх захирал

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Ж.БАТАА

.....

Төслийн өөрчлөлтийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч

.....

Б.САЙНЗАЯА

Зээлдэгчийн төлөөлөх:

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирал

.....

Д.АЛТАНЦЭЦЭГ

51

2023.09.05 ... сарын ... өдөр бүртгэлийн № 6415

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн тойргийн нотариатч Б.Бадамханд би энэ гэрээний үнэн зөвийг гэрчлэв.

Үйлчилгээний хөлсөнд 3000 төгрөг хураав

Нотариатч .....

Хянав: Зээлийн үйл ажиллагаа хариуцсан хуульч

.....

Б.Жамсрандорж

2023.08.30

Банкийг төлөөлөх: *Худалдаа баталгаажуулсан:* *Зээлдэгчийг төлөөлөх:*

ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЗАРЦУУЛАЛТ

Зээлийн шугамын дүн: *248.9 тэрбум төгрөг*
Зээлийн гэрээ байгуулсан : *2018.04.26*
Зээлийн хүү %: *11.89%*
Зээлийн хүү %: 2023.08.30-аас хойш *14.26%*
Зээлийн эргэн төлөлт хийх хугацаа: *2026.04.26*

2024.08.26-ны өдрийн байдлаар

№	Ажлын нэр	Нийт төсөвт өртөг / Гэрээний дүн	Гүйцэтгэгч	Гүйцэтгэл		Тодорхой тайлбар
				Дүн /сая.төг/	Хувь	
1	Төмөр зам	67,125.0	УБТЗ ХНН	67,125.0	100%	ГТБҮ-ийг Сайншанд сумтай холбосон төмөр зам, өртөө, төмөр бетон гүүр, 3.6 км авто зам зэргийн барилгын ажлыг УБТЗ ХНН 2018-2019 онд хийж гүйцэтгэн, 2019 оны 10 болон 11-р саруудад улсыг комисст хүлээлгэн өгсөн.
2	Авто зам	32,147.4	БХЯ	32,147.4	100%	ГТБҮ-ийг Сайншанд сумтай холбосон хүнд даацын тусгай зориулалтын 17км авто замыг БХЯ-ны ЗХ-ний 7780-р ангий хийж гүйцэтгэн, 2019 оны 11-р сард улсын комисст хүлээлгэн өгсөн.
3	Төслийн дэд станц, цахилгаан хангамжийн ажил	5,377.5	ЦДҮС ТӨХК	5,377.5	100%	Дорноговь аймгийн Сайншанд сумын 110/35/10кВ-ын дэд станцаас 110кВ-ын ЦДАШ-аар дамжуулан 18.6 км-т байрлах Газрын тос боловсруулахүйлдвэрийн талбайд байгуулан,110/10кв-ын үйлдвэрийн дэд станцыг "ЦДҮС" ТӨХК-ийн харьяанд байнгын жижүүртэй 6300 кВА чадал бүхий нэг трансформатортой байгууламж байхаар тооцсон. 2019 оны 7-р сард улсын комисс хүлээн авсан.
4	Үйлдвэрийн ажиллагсдын а мьдрах 550 айлын орон сууц.	69,141.1	БХЯ, Хангай бигэр ХХК, ТОБЭМ ХХК	42,221.2	61%	Барилгын ажлыг 2019 оны 8-р сард эхлүүлсэн бөгөөд эхнийээлжийн барилгын ажлууд 78 хувь, 2-рээлжийн барилгын ажлууд 31 хувийн гүйцэтгэлтэй байна.
5	Үйлдвэрийн талбайн тэгшилгээ, үйлдвэрийн болон усан хангамжийн худгийг хамгаалах хашаа барих ажил	6,705.1	БХБЯ, Нутгийн зам групп ХХК	6,705.1	100%	БХБЯ болон Нутгийн зам ХХК 2019-2022 онд барилгын ажлыг гүйцэтгэж, 2022.12.08-нд улсын комисс хүлээж авсан.
6	Үйл ажиллагааны зардал болон зөвлөх үйлчилгээ			21,488.2		
	Дүн			175,064.4		
7	Нийт зээлийн хуримтлагдсан хүү			98,487.8		2024.07.31-ний байдлаар

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

2023 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн
ЗГ-МГТ-З 2018-43/3 дугаартай Зээлийн гэрээнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай гэрээний Хавсралт

Зээлийн олголт, эргэн төлөлтийн хуваарь

Огноо	Зээлийн олголт	Үндсэн зээл төлөлт	Зээлийн хүү төлөлт	Нийт төлбөр	Зээлийн үлдэгдэл
2018-4-26	81,420,946.73	-	-	-	81,420,946.73
2018-5-3	335,136,531.00	-	-	-	416,557,477.73
2018-6-18	6,158,855,036.49	-	-	-	6,575,412,514.22
2018-6-19	3,842,764,625.00	-	-	-	10,418,177,139.22
2018-6-20	14,116,400,000.00	-	-	-	24,534,577,139.22
2018-8-31	183,390,886.00	-	-	-	24,717,968,025.22
2018-9-7	661,452,473.00	-	-	-	25,379,420,498.22
2018-9-17	278,199,294.00	-	-	-	25,657,619,792.22
2018-9-27	2,940,560,000.00	-	-	-	28,598,179,792.22
2018-11-13	11,558,670,150.00	-	-	-	40,156,849,942.22
2018-11-14	5,756,479,265.16	-	-	-	45,913,329,207.38
2018-11-23	7,044,454,136.00	-	-	-	52,957,783,343.38
2018-12-31	198,013,376.00	-	-	-	53,155,796,719.38
2019-3-29	8,664,155,533.00	-	-	-	61,819,952,252.38
2019-5-2	8,520,276,101.85	-	-	-	70,340,228,354.23
2019-6-20	2,575,918,291.00	-	-	-	72,916,146,645.23
2019-7-10	4,622,824,811.00	-	-	-	77,538,971,456.23
2019-8-1	1,094,938,588.00	-	-	-	78,633,910,044.23
2019-8-20	1,816,729,666.00	-	-	-	80,450,639,710.23
2019-8-30	160,875,032.00	-	-	-	80,611,514,742.23
2019-9-25	1,324,561,265.00	-	-	-	81,936,076,007.23
2019-10-4	6,299,789,151.00	-	-	-	88,235,865,158.23
2019-10-16	296,751,455.00	-	-	-	88,532,616,613.23
2019-10-23	6,209,879,200.00	-	-	-	94,742,495,813.23
2019-10-25	2,025,679,000.00	-	-	-	96,768,174,813.23
2019-11-12	2,430,053,247.00	-	-	-	99,198,228,060.23
2019-12-2	13,998,571,264.00	-	-	-	113,196,799,324.23
2019-12-24	2,885,906,259.00	-	-	-	116,082,705,583.23
2019-12-30	3,733,354,860.00	-	-	-	119,816,060,443.23
2020-3-31	1,118,166,429.00	-	-	-	120,934,226,872.23
2020-6-16	1,936,848,286.00	-	-	-	122,871,075,158.23
2020-6-26	1,722,668,106.00	-	-	-	124,593,743,264.23
2020-8-11	1,470,416,687.00	-	-	-	126,064,159,951.23
2020-8-20	1,488,087,483.81	-	-	-	127,552,247,435.04
2020-9-10	1,465,160,588.00	-	-	-	129,017,408,023.04
2020-9-17	1,265,991,542.00	-	-	-	[illegible]
2020-9-17	891,463,040.00	-	-	-	131,174,862,605[illegible]
2020-10-23	273,755,923.00	-	-	-	131,448,6[illegible]
2020-10-27	3,942,024,738.00	-	-	-	[illegible]
2020-10-30	1,118,293,235.00	-	-	-	136,5[illegible]

2023.09.05

Банкны төлөөлөл: Худалдаа батлагаажуулсан: Зээдэгчийн төлөөлөл:

209

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

Огноо	Зээлийн олголт	Үндсэн зээл төлөлт	Зээлийн хүү төлөлт	Нийт төлбөр	Зээлийн үлдэгдэл
2020-11-6	604,206,369.00	-	-	-	137,113,142,870.04
2020-11-17	1,520,956,970.00	-	-	-	138,634,099,840.04
2020-12-30	2,083,599,520.00	-	-	-	140,717,699,360.04
2021-5-7	1,232,954,652.00	-	-	-	141,950,654,012.04
2021-5-21	775,334,456.00	-	-	-	142,725,988,468.04
2021-6-2	2,411,512,675.76	-	-	-	145,137,501,143.80
2021-6-8	543,180,120.00	-	-	-	145,680,681,263.80
2021-6-22	1,639,487,523.00	-	-	-	147,320,168,786.80
2021-8-25	1,512,355,887.00	-	-	-	148,832,524,673.80
2021-9-14	2,046,703,112.00	-	-	-	150,879,227,785.80
2021-10-15	1,468,357,752.00	-	-	-	152,347,585,537.80
2021-11-1	2,138,709,202.80	-	-	-	154,486,294,740.60
2021-11-22	2,027,292,738.20	-	-	-	156,513,587,478.80
2021-12-24	570,404,651.00	-	-	-	157,083,992,129.80
2021-12-31	1,660,852,580.90	-	-	-	158,744,844,710.70
2022-3-24	1,961,536,958.40	-	-	-	160,706,381,669.10
2022-4-19	251,342,814.95	-	-	-	160,957,724,484.05
2022-5-13	811,870,298.60	-	-	-	161,769,594,782.65
2022-6-15	969,407,873.27	-	-	-	162,739,002,655.92
2022-7-8	350,462,845.80	-	-	-	163,089,465,501.72
2022-9-22	2,240,833,626.21	-	-	-	165,330,299,127.93
2022-11-29	1,005,541,126.39	-	-	-	166,335,840,254.32
2023-4-26	-	-	-	-	166,335,840,254.32
2023-7-7	2,262,463,047.00	-	-	-	168,598,303,301.32
2023-8-17	810,992,771.00	-	-	-	169,409,296,072.32
2023-8-30	-	-	-	-	169,409,296,072.32
2023-9-30	2,181,374,182.00	-	-	-	171,590,670,254.32
2026-4-26	-	-	76,581,392,150.61	76,581,392,150.61	171,590,670,254.32
2026-10-26	-	-	76,581,392,150.61	76,581,392,150.61	171,590,670,254.32
2027-4-26	-	57,196,890,084.77	12,200,895,844.51	69,397,785,929.28	114,393,780,169.55
2027-10-26	-	57,196,890,084.77	8,178,622,489.17	65,375,512,573.95	57,196,890,084.77
2028-4-26	-	57,196,890,084.77	4,089,311,244.59	61,286,201,329.36	-
	171,590,670,254.32	171,590,670,254.32	177,631,613,879.49	349,222,284,133.81	

Талууд харилцан тохиролцож зээл, зээлийн хүүгийн төлбөрийн хуваарийг хийв. Гэрээний 5 дугаар зүйлд заасан нөхцөлийн дагуу зээл олголтыг хийх бөгөөд зээлийн бодит олголттой уялдуулан Банк зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах эрхтэй болохыг Зээлдэгч хүлээн зөвшөөрөв.

Монгол Улсын Хөгжлийн банкийг

Хэлэлцээр үйлдэгч захирал

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

Ж.БАТАА

Банкийг төлөөлж:

Зээлдэгчийг төлөөлж:

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХК-ийн Үйлдвэрийн захирал

ДАЛТАНЦЭЦЭГ

УЛААНБААТАР ХОТ

2023.09.05

Зээлдэгчийг төлөөлж:

Хүүдсыг батлагаажуулсан:

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

Төслийн санхүүжилтийн газрын
захирлын үүрэг гүйцэтгэгч

.....

Б.САЙНЗАЯА

Хянав: Зээлийн үйл ажиллагаа
хариуцсан хуульч

.....

Б.Жамсрандорж
2023.08.30

2023.09.05
51

Банкнаас төлөвлөж: *Худалдаж авагчаас төлөвлөж:* *Зээлдэгчийг төлөвлөж:*

211

БАТАЛГААНЫ ГЭРЭЭ

2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар БА-МГТ 2024-06 ЭМГЛ-101/БГ-03/2024040429 | Улаанбаатар хот

Нэг.Нийтлэг үндэслэл

2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	71,188,099.96
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	24,600,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,551,139,717.82	199,875,270.37
2.1.2.01	Урт хугацаат зээл	158,744,844,710.70	166,335,840,254.32
2.1.2.02	Ур хугацаат зээлийн хүү	43,486,671,180.99	62,792,827,282.59
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	958,595,760.18	65,843,956,920.61
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	203,188,111,651.77	294,972,624,457.52
2.2	Өр төлбөрийн нийт дүн	207,739,250,349.59	295,172,499,727.89
2.3.01	Өмч: - төрийн	10,000,000.00	10,000,000.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9,384,783,200.00	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	-	9,384,783,200.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(41,456,643,699.08)	(52,381,197,846.30)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	(27,367,757,436.87)	(10,924,554,147.22)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(14,088,886,262.21)	(41,456,643,699.08)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(32,061,860,499.08)	(42,988,414,646.30)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	175,677,389,850.51	282,186,085,081.69

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	-	176,546,580.00
02	Борлуулалтын өртөг	-	62,231,172.55
03	Нийт ашиг(алдагдал)	-	114,315,407.45
08	Бусад орлого	13,398,883.24	617,036.34
08.1	Орлогын дүн	13,398,883.24	617,036.34
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,174,501,505.32	7,543,372,076.04
11	Санхүүгийн зардал	13,876,949,549.48	-
12	Бусад зардал	42,079,843.23	-
12.1	Зардлын дүн	21,093,530,898.03	7,543,372,076.04
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(24,637,961.83)	3,061,881.52
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(6,263,087,460.15)	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	(3,499,176,396.49)
17.1	Олз, гарзын дүн	(6,287,625,422.08)	(3,496,114,514.97)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(27,367,757,436.87)	(10,924,554,147.22)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(27,367,757,436.87)	(10,924,554,147.22)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(27,367,757,436.87)	(10,924,554,147.22)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хяр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	6,677,600,000.00	-	(14,088,886,262.21)	(7,401,286,262.21)
03	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(27,367,757,436.87)	(27,367,757,436.87)
06	Өмчид гарсан өөрчлөлт		2,707,183,200.00			2,707,183,200.00
09	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	9,384,783,200.00	-	(41,456,643,699.08)	(32,061,860,499.08)
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(9,384,783,200.00)	9,384,783,200.00		-
11	Залруулсан үлдэгдэл		(9,384,783,200.00)	9,384,783,200.00		-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(10,924,554,147.22)	(10,924,554,147.22)
17	2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	10,000,000.00	-	9,384,783,200.00	(52,381,197,846.30)	(42,986,414,646.30)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,636,616.97	161,540,515.52
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	132,551,238.00
1.1.3	Даатгалын нөхөвөөс хүлээн авсан мөнгө	-	203,400.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	12,636,616.97	28,785,877.52
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,379,313,540.44	6,981,616,170.63
1.2.1	Ажиллагсдад төлсөн	2,036,505,872.49	2,205,547,198.82
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	590,035,355.52	584,421,446.71
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	99,710,023.00	132,033,192.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	854,207,704.55
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,салбэг хэрэгсэлд төлсөн	21,014,545.45	30,250,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,472,947,750.96	302,058,417.35
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	7,333,238.52
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,158,096,993.02	2,886,064,972.68
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,366,676,923.47)	(6,820,375,655.11)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,661,303,008.00	3,469,665,888.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	289,859,028.00	179,480,000.00

01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,805,900.00	9,800,000.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,419,038,080.00	3,280,564,798.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,681,303,006.00)	(3,469,865,398.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,027,166,707.21	7,590,995,543.62
3.1.1	Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хуланз авсан	18,027,145,350.66	7,590,995,543.62
3.1.4	Бусад	21,356.55	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,286.95	-
3.2.5	Бусад	31,286.95	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,027,135,420.26	7,590,995,543.62
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,020,844,511.21)	(2,699,245,509.49)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,870,219,103.99	4,849,374,592.78
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,849,374,592.78	2,150,129,083.29

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны		Зөрүү	Хувь
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
НИЙТ ЭХ ҮҮСВЭР	18,548,259.9	36,113,109.0	7,705,927.9	(28,407,181.1)	21.3
Нийт ашиг/алдагдал			114,315.4	114,315.4	
Борлуулалтын орлого			176,546.6	176,546.6	
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	62,231.2	62,231.2	
Үйл ажиллагааны бус орлого	13,398.9	9,000.0	617.0	(8,383.0)	6.9
Зээлээр санхүүжих	18,534,861.0	36,104,109.0	7,590,995.6	(28,513,113.5)	21.0
Нийт зардал	27,381,384.8	27,394,637.0	7,543,372.0	(19,851,265.0)	148.2
Ерөнхий удирдлагын зардал	3,653,382.9	9,342,008.0	3,998,895.4	(5,343,112.6)	42.8
Санхүүгийн зардал /зээлийн хүүгийн зардал/	13,876,949.6	14,690,899.0		(14,690,899.0)	-
Элэгдлийн зардал	3,587,964.8	3,361,730.0	3,544,476.6	182,746.6	105.4
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	6,263,087.5				
ГВХЗ-ний олз/гарз	-	-	3,061.8	3,061.8	
Үйл ажиллагааны бус зардал	-	-	3,499,176.4	3,499,176.4	
Үйл ажиллагааны бус зардал			55,323.0	55,323.0	
ГВХЗ-ний бодит бус гарз			3,443,853.4	3,443,853.4	
Татварын өмнөх ашиг	(27,367,986.9)	(27,385,637.0)	(10,924,554.2)	20,019,428.6	39.9
Цэвэр ашиг алдагдал	(27,367,986.9)	(27,385,637.0)	(10,924,554.2)	20,019,428.6	39.9
Нийт ажиллагсдын тоо	85	151	85	66	56.3
Нийт цалингийн сан	1,853,719.1	3,899,510.0	2,728,746.1	(1,170,763.9)	70.0
Хөрөнгө оруулалт эхлэх үйлчилгээ	14,676,269.3	26,762,101.1	3,469,865.4	(23,292,235.7)	13.0
Нийт авлага	5,020,514.8	350,104.0	4,678,147.6	4,328,043.6	1,336.2
Дансны болон бусад авлага	4,783,562.4		4,216,550.2	4,216,550.2	
Барьцааны авлага	47,520.0	47,520.0	47,520.0	-	100.0
НӨШ, Татварын авлага	189,432.4	302,584.0	414,077.4	111,493.4	136.8
Нийт өглөг	207,739,260.3	257,176,877.0	285,172,499.7	27,993,622.7	110.9
Дансны өглөг/бусад ер төлбөр	1,159,641.1	956,824.0	64,111,882.5	63,155,058.5	6,700.5
НӨШ/татварын өглөг	66,838.0		175,275.3	175,275.3	
Барьцааны өглөг	4,281,255.3	5,081,817.0	1,788,929.4	(3,292,887.6)	35.2
Урт хугацаат зээлийн хүүгийн төлбөр	43,486,671.2	66,655,282.0	62,792,827.3	(3,862,454.7)	94.2
Банкны урт хугацаат зээл	158,744,844.7	194,494,954.0	166,335,840.3	(28,149,113.7)	85.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь үндсэн зорилгоо "Дорноговь аймагт жилд 2 сая тонн хүртэл газрын тос боловсруулах хүчин чадалтай, тэргүүний технологи бүхий үйлдвэрийг байгуулан, үр ашигтай ажиллуулж, компанийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх"-д оршино гэж тодорхойлжээ.

Тайлант онд газрын тос боловсруулах үйлдвэр, хотхоны бүтээн байгуулалт, газрын тосны хайгуул, судалгаа, газрын тос дамжуулах хоолой барих, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлэхээр 22 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

УУХҮС-ын 2018 оны А/259 дүгээр тушаалаар батлагдсан компанийн дүрэмд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 5, бусад 17 чиглэлийн үйл ажиллагаа явуулахаар тодорхойлжээ. Дараах үндсэн үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгуулах, ашиглалтад оруулах,
- Үйлдвэрийг барьж байгуулах явцад болон ашиглалтад оруулахын өмнө шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчийг гадаад улсад болон дотооддоо сургаж бэлтгэх,
- Стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, борлуулах,
- Үйлдвэрийг түүхий эдээр хангах,
- Түүхий тос дамжуулах хоолой барьж байгуулах.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хариуцлагын хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат компани гэж заасан бөгөөд 100 хувь төрийн өмчит компани байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Засгийн Газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийг байгуулж, УУХҮС-ын 2018 оны А/259 дүгээр тушаалаар компанийн дүрмийг батлан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах; ..." гэсэн заалттай нийцэж байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг УУХҮС-ын 2019 оны А/06 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2022 оны Б/08 дугаар тушаалаар 5 гишүүнийг өөрчлөн томилжээ.

ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг 840.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдсан;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Засгийн Газрын 2021 оны 388 дугаар "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай".

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна гэж үзлээ.

Тус компанийн Дотоод хяналтын албанаас 3 зорилтын хүрээнд 8 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөн, дараах ажилбаруудыг гүйцэтгэсэн. Тухайлбал:

- ERC-1 багц ажлын хэрэгжилтэд сар бүрээр хяналт хэрэгжүүлэн нэгтгэж, 5 зөвлөмж өгсөн,
- Худалдан авах ажиллагааны 2021, 2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт хийж, 4 зөвлөмж өгсөн,
- Газрын тосны үйлдвэрийн хотхоны бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт хийж, 3 зөвлөмжийг удирдлагад тус тус хүргүүлсэн байна.

Дотоод хяналтын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын ажилтнаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь 2019 онд Эйч Эйл Би Монголиа Аудит ХХК-аар гүйцэтгүүлсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулаагүй, өөрчлөлт, шинэчлэлт хийгээгүй, борлуулалтын орлого түүнтэй холбогдон гарах борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцох аргачлал, бодлогыг нарийвчлан тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орооогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,508.7 сая төгрөгөөр буюу 43.4 хувиар *өссөн* байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,849,374.6	2,150,129.1	(2,699,245.5)
Авлага	247,667.3	495,836.4	248,169.1
Урьдчилж төлсөн төлбөр	4,819,277.2	4,182,311.2	(636,966.0)
Бараа материал	41,397.4	47,019.3	5,622.0
Үндсэн хөрөнгө	164,934,904.2	244,697,052.2	79,762,148.0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000.0	1,000.0	-

Хойшлогдсон татварын хөрөнгө	783,769.2	612,736.9	(171,032.4)
Нийт хөрөнгө	175,677,389.9	252,186,085.1	76,508,695.2
Өр төлбөр	4,551,138.7	175,275.3	(4,375,863.4)
Урьчилж орсон орлого		24,600.0	24,600.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	203,188,111.6	294,972,624.5	91,784,512.8
Төрийн өмч	10,000.0	10,000.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9,384,783.2		(9,384,783.2)
Засийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		9,384,783.2	9,384,783.2
Хуримтлагдсан ашиг	(41,456,643.7)	(52,381,197.8)	(10,924,554.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	175,677,389.9	252,186,085.1	76,508,695.2

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн төлбөр, богино хугацаат өр төлбөр, эздийн өмчийн бусад хэсгийн дансд материаллаг дүнгээр буурч, авлага, үндсэн хөрөнгө, урт хугацаат өр төлбөрийн дансд материаллаг дүнгээр нэмэгдсэн байна.

Жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Хөгжлийн банк, Голомт банк, Богд банканд нийт 2,147.2 сая төгрөгийн, Богд банкин дахь ам.долларын дансанд 843.26 ам.доллар буюу 2.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 495.8 сая төгрөг болж 248.2 сая төгрөгөөр өссөн нь нэмэгдсэн ертгийн албан татварын авлага 243.6 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 34.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн төлбөрийн дансны үлдэгдэл 4,182.3 сая төгрөг болж 637.0 сая төгрөгөөр буурсан нь Барилгын ажлын гэрээнд заасны дагуу гүйцэтгэл бүрээс 20 хувийг суутган тооцсонтой холбоотой байна. Тус дансны үлдэгдэлд БХЯ болон Хангай бигэр ХХК, Тобэм ХХК-д олгосон Газрын тос боловсруулах үйлдвэрийн хотхоны барилгын ажлын урьдчилгаа санхүүжилт тайлагнагдсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 79,761.2 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Газрын тосны үйлдвэрийн хотхоны 40 айлын орон сууцны болон түүний гадна инженерийн шугам сүлжээний барилгын ажлыг ашиглалтад хүлээж авч, ТӨБЗГ-ын 2022 оны 635 дугаар тогтоолын дагуу 4,741.3 сая төгрөгийн барилга, байгууламжийг орлого авсан,
- Дуусаагүй барилгын дансанд Газрын тос дамжуулах хоолойн барилгын ажлын 58,523.5 сая төгрөгийн гүйцэтгэлийг бүртгэсэн,
- Өмнөх аудитын зөвлөмжийн дагуу Монгол Улсын хөгжлийн банкны зээлийн хүүгийн 16,146.2 сая төгрөгийн зардлыг дуусаагүй барилга байгууламж дансанд хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга байгууламжийн дансны 119,304.8 сая төгрөгийн үлдэгдэлд үйлдвэрийн хотхоны орон сууц, зам, талбай, газрын тос дамжуулах хоолой зэрэг 19 барилга, байгууламжийн 2.5-аас 94.4 хувийн гүйцэтгэлтэй хөрөнгө оруулалтын ажлууд бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 175.3 сая төгрөг болж 4,375.9 сая төгрөгөөр буурсан нь 3 гэрээт ажлын 2,569.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, дүгнэлтийг үндэслэн барьцааны хөрөнгийг олгосон, 1,855.0 сая төгрөгийн 7 гэрээт ажлын урт хугацаат еглегийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэснийг залруулсан зэргээс шалтгаалжээ.

Мөн ажиллагсадтай холбоотой хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн 134.4 сая төгрөгийн еглег үүсгэсэн байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 294,972.6 сая төгрөг болж 91,784.5 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай. Үүнд:

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- Засгийн Газрын 2022 оны 94 дүгээр тогтоол, Эрдэнэс-Тавантолгой ХК болон Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн хооронд Газрын тос дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх 388.1 сая ам.долларын гэрээ байгуулж, тайлант онд 18.3 сая ам.долларын гүйцэтгэлийг баталгаажуулан, 62,898.4 сая төгрөгийн тооцоо үүсгэн бүртгэсэн,
- Монгол Улсын Хөгжлийн банктай 2018 онд байгуулсан ЗГ-МГТ-3 2018-43 дугаар гэрээний дагуу 250,000.0 сая төгрөгийн зээл авахаас тайлант онд 7,591.0 сая төгрөгийн зээл авсан,
- Дээрх гэрээний хүрээнд 2018 оноос эхлэн авсан 166,335.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд 19,308.2 сая төгрөгийн зээлийн хүүгийн өглөг тооцон бүртгэсэн байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг зардлыг төлсөн эсвэл төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнэ буюу жинхэнэ гарсан хэмжээгээр хэмжих, гадаад валютаар гарсан зардлыг тухайн үеийн албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэж, зөвшөөрч тусгахаар заасан байна. Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Нийт зардлын дүнг өмнөх онтой харьцуулахад 19,851.3 сая төгрөгөөр буурсан нь зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн хотхон, зам, талбайн ажлын гүйцэтгэлд зээлийн хүүгийн зардлыг капиталжуулан бүртгэсэн, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зээлийн эх үүсвэр төлөвлөсөн хэмжээгээр гараагүй зэрэгтэй холбоотой байна.

Тайлант онд 62.2 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцсон бөгөөд ашиглалтад орсон газрын тосны үйлдвэрийн хотхоны 40-4 дугаар байр ашиглалтад орсонтой холбоотойгоор халаалтын зардал, засвар үйлчилгээний материалын зардлуудыг хамруулсан байна.

3.6 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг, 02 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төсвийг тус тус баталсан байна.

Тайлант онд үйл ажиллагааны бус орлогоос 9.0 сая төгрөг бүрдүүлж, 27,394.6 сая төгрөгийн зардал гарган, 27,385.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар, мөн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 26,762.1 сая төгрөгийг зарцуулахаар тус тус тооцон төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 177.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 62.2 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэүүний өртөг тооцон, нийт 11,042.7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал болон үйл ажиллагааны бус гарган, 10,924.5 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын гүйцэтгэл 11,042.7 сая төгрөг гарч 40.3 хувийн дутуу гүйцэтгэлтэй тайлагнагдсан нь Хөгжлийн банкнаас зээлийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс өөрөөс удирдлагын зардлыг 5,343.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд 27,385.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс 10,924.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь төсөв, төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцоолоогүй, тайлант онд гарсан асуудлуудаар тодотгол хийгээгүй, зээлийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй зэргээс шалтгаалсан байна.

237

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 39 нэр төрлийн 26,762.1 сая төгрөгийн арга хэмжээг Хөгжлийн банкны зээлийн санхүүжүүлтээр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, 8 нэр төрлийн 3,469.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Батлагдсан зориltот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг тайланг 2.5-д харуулав.

01 ТӨРИЙН АУДИТ БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн тайлант хугацаанд орлого олохтой холбоотойгоор гарах зардлыг хуваарилах, бүртгэлд тусгах талаарх бодлогыг тодорхой болгохоор өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитор М.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүн 27,367.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 273.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 6 арга хэмжээг авч хэрэгжүүлэн, 27,100.5 сая төгрөгийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэхээр тооцсон байна.

Жилийн эцсийн байдлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Орон тооны дээд хязгаарыг 151 ажилтнаар батлалсан ч гүйцэтгэлээр 85 ажилтан ажиллуулж, шинээр ажилтан авч ажиллуулаагүй,
- Гадаад, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, сургалт, хурал зөвлөгөөн зэрэг үйл ажиллагааны зардалд 4,084.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 1,176.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үйл ажиллагааны тайланд төрийн хэмнэлтийн горим хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор дараах ажлын гүйцэтгэлийг зогсоосон гэж тайлагнасан байна. Үүнд:

- Үйлдвэрийн салбар төмөр замын тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилгоор төмөр замын дохиолол, холбооны хэрэгслийн бууршгүй нөөцийг бүрдүүлэх,
- Төмөр замын 167 км ухмалын налуугийн нягтруулаагүй сул шороо бороонд усанд угаагдан ухагдан суваг, гуу жалга үүсгэсэн хэсгийг шороогоор дүүргэх,

- Төмөр замын ухмалаас сул шороо борооны усанд угаагдан урсаж овоорон төмөр замд тулсан байгааг замаас зайлуулан зөөж цэвэрлэх, шуудууг сэргээн засварлах,
- Гаалийн хяналтын түр бүсийн талбайг бий болгож ачаа бараа үйлдвэрийн талбай дээр буулгах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үналэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 22 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд горим сорил хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Тайлант онд ашиглалтад орсон 40 айлын орон сууцны 2 байрыг 24.6 сая төгрөгөөр түрээслүүлэхдээ холбогдох мэдээллийг ТӨБЗГ-т хүргүүлж, зохих арга хэмжээг авааагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлсан "Төр өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 5. "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэгч нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон төрийн өмчит хуулийн этгээд (цаашид "түрээслүүлэгч" гэнэ) байна. Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшиж буй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг энэ журмын дагуу түрээслүүлнэ", 2 дугаар зүйлийн 19. "Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшиж байгаа төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлсэн бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж байх үүрэгтэй" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийг бусдад түрээслүүлэхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр ТӨБЗГ-т, шаардлагатай арга хэмжээг авах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн,* өөрийн эзэмшлийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ ТӨБЗГ-т мэдэлээгүй нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлсан Төр өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журамд *нийцээгүй* гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр өөч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 6,557.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1,741.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 4,816.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлснийг 60.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,741,007.7	1	8,107.0	50.0
Албан шаардлага	3	4,816,461.8	2	44,381.9	66.7
Нийт дүн	5	6,557,469.5	3	52,488.9	60.0

Өмнөх аудитаар тогтоосон Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн Хонгорын овоо хүртэлх 27 км төмөр замаар ачаа тээвэрлэсэн нэр бүхий компаниудаас 1,732.9 сая төгрөгийн зам ашиглалтын төлбөрийг нөхөн авах төлбөрийн акт болон 550 айлын хотхоны барилгын ажлын урьдчилгаанд 3 туслан гүйцэтгэгчид урьдчилгаа санхүүжилт олгосныг барагдуулж, алдагдлыг багасгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараах асуудлуудыг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Газрын тос дамжуулах хоолой барих ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэх,
2. Тус компанийн бүтэц орон тоо, түүний зохион байгуулалт, уялдаа, хэрэгцээ шаардлага,
3. Газрын тосны үйлдвэр түүний дагалдах бүтээн байгуулалтуудын нөхцөл байдал, тус үйлдвэрийг түшиглэн үйл ажиллагаа явуулж буй зам засвар арчлалт, халаалт дулаан, ашиглалтын компаниудын сонгон шалгаруулалт, үйл ажиллагааны үр дүн, харилцан уялдаа,
4. Газын тос боловсруулах үйлдвэрийн хотхон, зам, талбайн бүтээн байгуулалтын өртөгт зээлийн хүүгийн зардлыг үнэн зөв хуримтлуулан бүртгэж, капиталжуулсан эсэхийг дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзнэ.

Мөн Газрын тос боловсруулах үйлдвэр бариx үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхээр бүрдүүлсэн эх үүсвэрүүд */БНЭУ-ын 1,000.0 сая ам.долларын зээл, Хөгжлийн банкны 250,000.0 сая төгрөгийн урт хугацаат зээл, Эрдэнэс Тавантолгой ХК-аас авах 388.1 сая ам.долларын зээл/*-ийн зарцуулалт, түүний үр дүн, үр ашиг, хууль эрх зүйн орчин, нийцэл зэргийг цогц байдлаар авч үзэн гүйцэтгэл-нийцлийн аудит хийх нь тус төслийн нөхцөл байдлын талаар дүгнэлт гарах, цаашид авч хэрэгжүүлэх, анхаарах асуудлыг тодорхойлох ач холбогдолтой байна.

241

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,510.4 сая төгрөгийн 3 алдаа[1] илэрснээс 2 алдааг аудитын явцад залруулж, 1 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Дараах залруулгыг хийсэн. Үүнд:

- Тус компанийн эзэмшиж, ашиглаж буй 9,384.8 сая төгрөгийн 35 газрыг эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт бус дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэсэн,
- Орон сууцны 95-1 дугаар барилга, оффис-үйлчилгээний барилгын ертгийг 121.6 сая төгрөгөөр зөрүүлэн хуримтлуулан бүртгэсэн, орон сууцны 95-3 дугаар барилгын ертгийг 4.0 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн зэрэг нийт 9,510.4 сая төгрөгийн алдааг залруулга хийлгэв.

Аудитаар нийт 2,351.9 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 6.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,345.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар илэрсэн 2,351.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон өрөнхий материаллаг байдлын түвшин 273.6 сая төгрөгөөс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж захирлын гар утасны төлбөрт 0.3 сая төгрөг, хот дотор авто машин унаж шатахууны зардалд 6.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. "... төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, ... хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1. "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1.гар утасны зардал" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

5.2.1. Тайлант хугацаанд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд батлуулаагүй, тодотгол хийлгэлгүйгээр төмөр замын ашиглуулах болон байр түрээслүүлэх үйл ажиллагаа явуулсан, газрын тос боловсруулах үйлдвэрийн газрын тос дамжуулах хоолойн байгууламж барих 58,523.5 сая төгрөгийн дуусаагүй барилга байгууламж бүртгэсэн, 175.3 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

Мөн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг бодит тооцоо судалгаанд үндаслэн төлөвлөж, батлуулаагүйгээс өмнөх оноос шилжин хэрэгжсэн 2,063.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг төлөвлөж, батлуулаагүй, бүтэц орон тоог 151 байхаар баталж, гүйцэтгэлээр 85 орон тоотой ажилласан байна.

Энэ нь УУХҮС-ын 2018 оны А/259 дүгээр тушаалаар баталсан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3 "Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ...", 10.6 "Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ. 10.6.1.Компанийн үйл ажиллагааны тухай жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, түүний хэрэгжилтийг зохион байгуулна; 10.6.11. Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах", ТУЗ болон гүйцэтгэх захирлын байгуулсан 2019 оны 19/01

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон, хайнга хэндсэн /хасагдсан тайлагналгүй орхисон/.

[2] Хүчин төгөлдөр үйлчлэх бүх хууль тогтоомжид хэрэлтэх байгууллага, түүний удирдлага, албан тушаалтан буруу үйлдэл, эс үйлдэл, хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

дүгээр гэрээний 3 дугаар зүйлийн 3.6 "Гүйцэтгэх захирал дараах асуудлыг зөвхөн ТУЗ-ийн хурлын тогтоолын дагуу шийдвэрлэх үүрэгтэй: 3.6.1 үйл ажиллагааны үндсэн чиглэлээс өөр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх; 3.6.2 Компанийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгө олж авах, данснаас хасах, захиалах, шинээр авах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинийг бодит тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж батлуулах, шаардлагатай үед төсвийн тодотгол хийж байх, батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2.2. Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн 550 айлын хотхон байгуулах төслийн барилгын ажлууд гэрээт хугацаанаас 1-ээс 2 жилийн хугацаа хоцролттой, ажлын тоо хэмжээ, төсөвт өртөгт маргаан үүссэнээс зогсонги байдалтай байна. Тухайлбал:

- туслан гүйцэтгэгч Зэвсэгт хүчний барилга, инженерийн 339 дүгээр ангийн гүйцэтгэж буй 21,837.2 сая төгрөгийн 6 барилгын ажил 2021 оны 9 дүгээр сард ашиглалтад орох байсан ч ажлын тоо хэмжээ, төсөвт маргаан үүссэнээс ажил зогссон,
- туслан гүйцэтгэгч Тобэм ХХК-ийн гүйцэтгэж буй 9,212.1 сая төгрөгийн 2 барилгын ажил 2020 оны 12 дугаар сард ашиглалтад орохоос санхүүжилт эх үүсвэр буюу Хөгжлийн банкны зээл гараагүйгээс ажил хийгдээгүй байна.

Энэ нь УУХҮС-ын 2018 оны А/259 дүгээр тушаалаар батлагдсан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1. "Компанийн удирдлага дараахь бүтэцтэй байна: 7.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал; 7.1.2. Төлөөлөн удирдах зөвлөл", 10 дугаар зүйлийн 10.3 "Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ...", 10.4 "Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, бизнесийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан ажиллана", 10.6.11. "Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах", 10.6.13 "Хууль тогтоомж, компанийн дүрэм, ... болон аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалт, ашиглалтад хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын тос боловсруулах үйлдвэрийн хотхоны барилгын зогссон ажлыг хувьцаа эзэмшигч, холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлэх арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэх.

5.2.3. Газрын тос боловсруулах үйлдвэрийн 550 айлын хотхоны барилгын ажлын урьдчилгаанд 3 туслан гүйцэтгэгчид 4,180.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон ч гүйцэтгэл гараагүй, зээлийн хүүгийн зардалд 519.7 сая төгрөг тооцож, алдагдлыг өсгөсөн байна. Өмнөх оны аудитаар урьдчилж төлсөн тооцоог барагдуулж зээлийн хүүгийн зардлаар алдагдал нэмэгдүүлж байгаа зөрчлийг арилгахаар албан шаардлага хүргүүлсэн ч хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3 "Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ...", 10.6.11. Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах", 10.6.13 "Хууль тогтоомж, компанийн дүрэм, ... болон аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалт, ашиглалтад хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх" гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

273

Шийдвэрлэсэн нь: Урьдчилгаа санхүүжилтийн гүйцэтгэлийг гаргуулж, зээлийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.4. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй, Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн Хонгорын овоо хүртэлх 27 км төмөр замаар ачаа тээвэрлэсэн нэр бүхий компаниудаас 1,732.9 сая төгрөгийн зам ашиглалтын төлбөрийг нөхөн авч төвлөрүүлээгүй байна.

УУХҮС-ын 2018 оны А/259 дүгээр тушаалаар батлагдсан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3 "Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ...", 10.6.11. Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах", 10.6.13 "Хууль тогтоомж, компанийн дүрэм, ... болон аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалт, ашиглалтад хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн актын хэрэгжилтийг хангах, холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх албан шаардлага өгөх.

5.2.5. Тайлант оны зорилтот түвшний хэрэгжилт хангалттүй, ажилтан тус бүрээр гүйцэтгэх ажлын төлөвлөгөө батлуулаагүй, гүйцэтгэл тайлагнаагүй, үр дүнг үнэлээгүй байхад нийт 92.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6. "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.4 "Төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг захирлын зөвлөлөөр хэлэлцэж, ажлын үр дүнг харгалзан ажилтны болон ... ажлыг тус тус үнэлж дүгнэн, шагнаж урамшуулах, ... зэрэг арга хэмжээг авна" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын үр дүнгийн урамшууллыг байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг үндэслэн ажилтан тус бүрээр гүйцэтгэсэн ажлыг үнэлж дүгнэсний дагуу олгож байх, үр дүнгийн урамшуулал олгох үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож журамлах.

6.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 176.5 сая төгрөгийн төмөр зам ашиглуулсны төлбөр авч, орлого олсон боловч нягтлан бодох бүртгэлийн зохицох зарчмын дагуу тухайн цаг хугацаанд орлого олохтой холбогдон гарсан зардал буюу борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцож бүртгээгүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцох зохицуулалт тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1.Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт", 5 дугаар зүйлийн 5.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.6.зохицох", 19 дүгээр зүйлийн 19.1. "Аж ахуйн нэгж

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагааны орлого олохтой холбогдон гарах зардлыг тооцож хуваарилах, бүртгэлд тусгах талаарх бодлогыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусган мөрдөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны төрөл утга	Нийт алдаа		Мадэллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 176.5 сая төгрөгийн төмөр зам ашиглуулсны төлбөр авч, орлого олсон боловч нягтлан бодох бүртгэлийн зохицох зарчмын дагуу тухайн цаг хугацаанд орлого олохтой холбогдон гарсан зардал буюу борлуулсан бүтээгдэхүүний ертөгийг тооцож бүртгээгүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг борлуулсан бүтээгдэхүүний ертөг тооцох зохицуулалт тусгаагүй байна.	1	-			1	-			1	-	1	-
Тус компанийн эзэмшил, ашиглаж буй 9,384.8 сая төгрөгийн 35 газрыг эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт бус дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэсэн.	1	9,384,783.2			1	9,384,783.2	1	9,384,783.2				
Орон сууцны 95-1 дугаар барилга, оффис-үйлчилгээний барилгын ертөгийг 121.6 сая төгрөгөөр зөрүүлэн хуримтлуулан бүртгэсэн, орон сууцны 95-3 дугаар барилгын ертөгийг 4.0 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн алдаг залруулсан.	1	125,594.5			1	125,594.5	1	125,594.5				
Дүн	3	9,510,377.7			1	9,510,377.7	1	9,510,377.7	1	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн төрөл утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд эдийн засгийн үндэслэл үзүүлэлт, зорилтот түвшинд батлуулаагүй, тодотгол хийлгэлгүйгээр төмөр замын ашиглуулах болон байр түрээслүүлэх үйл ажиллагаа	1	-			1	-						

01 ТӨГИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРТАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

явуулсан, газрын тос боловсруулах үйлдвэрийн газрын тос дамжуулах хоолойн байгууламж барих 58,523.5 сая төгрөгийн дуусаагүй барилга байгууламж бүртгэсэн, 175.3 сая төгрөгийн ер төлбөр үүсгэсэн. Мөн эдийн засгийн үндэслэл үзүүлэлт, зорилтот түвшнийг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, батлуулаагүйгээс амнах онооос шилжин хэрэгжсэн 2,063.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг төлөвлөж, батлуулаагүй, бүтэц орон тоог 151 байхаар баталж, гүйцэтгэлээр 85 орон тоотой ажилласан байна.												
Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт байрлах ГТБҮ-ийн 550 айлын хотхон байгуулах төслийн барилгын ажлууд гэрээт хугацаанаас 1-ээс 2 жилийн хугацаа хоцролттой, ажлын тоо хэмжээ, төсөвт ертөгт маргаан үүссэнээс зогссоны байдалтай байна. Тухайлбал: - туслан гүйцэтгэгч Зэвсэгт хүчний барилга, инженерийн 339 дүгээр ангийн гүйцэтгэх буй 21,637.2 сая төгрөгийн 6 барилгын ажил 2021 оны 9 дүгээр сард ашиглалтад орох байсан ч ажлын тоо хэмжээ, төсөвт маргаан үүссэнээс ажил зогссон, - туслан гүйцэтгэгч Тобэм ХХК-ийн гүйцэтгэх буй 9,212.1 сая төгрөгийн 2 барилгын ажил 2020 оны 12 дугаар сард ашиглалтад орохоос санхүүжилт эх үүсвэр болоу Хөгжлийн банкны зээл гараагүйгээс ажил хийгдээгүй байна. Иймд ТУЗ-ийн болон Хувьцаа эзэмшигч /УУХҮЯ/-ийн хурлаар тулгарсан асуудлыг хэлэлцүүлэн, нэгдсэн шийдвэрт хүрч, үр дүнгээ арга хэмжээ авах шаардлагатай байна.	1	-			1	-						
ГТБҮ-ийн 550 айлын хотхоны барилгын ажлын урьдчилгаанд 3 туслан гүйцэтгэгчид 4,180.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон ч гүйцэтгэл гараагүй, эзэлийн хүүгийн зардалд 519.7 сая төгрөг тооцож, алдагдлыг есгөсөн байна. Өмнөх оны аудитаар урьдчилж төлсөн төсөрөг барагдуулж эзэлийн хүүгийн зардлаар алдагдал нэмэгдүүлж байгаа зөрчлийг арилгахаар албан шаардлага хүргүүлсэн ч хэрэгжүүлэн ажиллаагүй байна.	1	519,700.7			1	519,700.7						
Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй, Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн Хонгорын овоо хурдэлж 27 км төмөр замаар ачаа тээвэрлэсэн нэр бүхий компаниудаас 1,732.9 сая төгрөгийн зам ашиглалтын төлбөрийг нөхөн авч төлөөгүүлээгүй байна.	1	1,732,900.7			1	1,732,900.7						
Тайлант оны зорилтот түвшний хэрэгжилт хангалттүй, ажилтан тус бүрээр гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл	1	92,400.0			1	92,400.0						

гаргаагүй, үр дүнг үнэлээгүй байхад нийт 92.4 сая төгрөгийн үр дүнгийн үремшүүлэл олгосон байна.													
Хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж захиргын гар утасны төлбөрт 0.3 сая төгрөг, хот дотор авто машин унаж шатахууны зардалд 6.5 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	6,861.6	1	6,861.6									
Дүн	6	2,351,863.0	1	6,861.6	5	2,345,001.4							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн төрөл үүгэ	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд ашиглалтад орсон 40 айлын орон сууцны 2 байрыг 24.6 сая төгрөгөөр түрээслүүлэхдээ холбогдох мэдээллийг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэр гаргуулаагүй байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

№2023 оны 03 дугаар сарын 01 № 118/110 180063

САТ-04023/26/108 СЗК-394

Үзэмбаяр х

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд захирлын гар утасны төлбөрт 314,530.00 /гурван зуун арван дөрвөн мянга таван зуун гуч/ төгрөг, хот дотор авто машин үнэж шатахууны зардалд 6,547,051.95 /зургаан сая таван зуун дөчин долоон мянга тавин нэг/ төгрөгийг зөрцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "... төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, ... хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1 "тар утасны зардал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтоохоор*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага гэрэх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гар утасны төлбөр болон хот дотор албан тушаалын суудлын авто машин ашиглан шатахуунд зарцуулсан нийт 6,861,581.95 /зургаан сая найман зуун жаран нэгэн мянга таван зуун наян нэг/ төгрөгийг Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, ерөнхий нягтлан бодогч /Б.Чинтуяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Сүхбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-30

2-Үйл-2023/03/15 ЗАМО-010.Doc

0001090132

249

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 дугаар сарын 01 № 530/АО/16800/23

САҮ-02023/56/ЗА-СЗА-ТЗА

Улаанбаатар хот

Г

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй, Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн Хонгорын овоо хүртэлх 27 км төмөр замаар ачаа тээвэрлэсэн нэр бүхий компаниудаас 1,732,900,704.00 /нэг тэрбум долоон зуун гучин хөөр сая есөн зуун мянга долоон зуун дөрөв/ төгрөгийн зам ашиглалтын төлбөрийг нөхөн авч төвлөрүүлээгүй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/259 дүгээр тушаалаар батлагдсан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3 "Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ...", 10.6.11 "Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдах буй компанийн төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах", 10.6.13 "Хууль тогтоомж, компанийн дүрэм, ... болон аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, зөрчүүлэлт, ашиглалтад хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зөрчүүлэх" гэх заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хууллаар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даатган гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн ШААРДАЖ НЬ:

6. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг ханган, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

6. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллахыг Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, ерөнхий нягтлан бодогч Б.Чинтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ-НИЙЦЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26-...

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХҮЛЭЭН АВСАН ЭСЭХ
САНАЛ ДҮГНЭГТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 01. № 551/АО/2022/01

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн 550 айлын хотхон байгуулах төслийн барилгын ажлууд гэрээт хугацаанаас нэлээс хоёр жилийн хугацаа хоцролттой, ажлын тоо хэмжээ, төсөвт өртөгт маргаан үүссэнээс зорилгоо байдалтай байна. Тухайлбал:

- Туслан гүйцэтгэгч Зэвсэгт хүчний барилга, инженерийн 339 дүгээр ангийн гүйцэтгэж буй 21,837,248,005.00 /хорин нэгэн тэрбум найман зуун гучин долоон сая хоёр зуун дечин найман мянга тав/ төгрөгийн 6 барилгын ажил 2021 оны 9 дүгээр сард ашиглалтад орох байсан ч ажлын тоо хэмжээ, төсөвт маргаан үүссэнээс ажил зогссон,
- Туслан гүйцэтгэгч Тобэм ХХК-ийн гүйцэтгэж буй 9,212,148,000.00 /есөн тэрбум хоёр зуун арван хоёр сая нэг зуун дечин найман мянга/ төгрөгийн 2 барилгын ажил 2020 оны 12 дугаар сард ашиглалтад орохоос санхүүжилтийн эх үүсвэр бүрдүү Хөгжлийн банкны зээл гаранагүй гэх шалтгаанаар зогссон байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөвлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/259 дүгээр тушаалаар батлагдсан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 "Компанийн удирдлага дараахь бүтэцтэй байна: 7.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал; 7.1.2. Төлөвлөн удирдах зөвлөл", 10 дугаар зүйлийн 10.3 "Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ...", 10.4 "Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, бизнесийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан ажиллана", 10.6.11 "Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх удирдаж буй компанийн төлбөрийн чадвар, кэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах", 10.6.13 "Хууль тогтоомж, компанийн дүрэм, ... болон аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалт, ашиглалтад хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны эрх хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлэхгүй бол алдаа, зөрчлийг төслөн зохсоох, арилган залруулахаар байгууллагаа, албан тушаалтанд албан шаардлага өгөх*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

Монгол Улс, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264000

Е-МБА-2021/0015 ЕМАС-51-54 Шаст

0001081751

251

1. Зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийн хотхоны барилгын зогссон ажлыг хувьцаа эзэмшигч болон холбогдох эрх бүхий байгууллагуудад хандан шийдвэрлүүлж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, ерөнхий нягтлан бодогч /Б.Чинтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Иймд Терийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хууліар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгөх*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, телберийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зориптот түвшнийг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, ерөнхий нягтлан бодогч /Б.Чинтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас: 51-264230

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

253

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 02 № 55/АШ/160062

Улаанбаатар хот

СААТ-2022/55/RA-EPA-IDA

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тос боловсруулах үйлдвэрийн 550 айлын хотхоны барилгын ажлын урьдчилгаанд 3 туслан гүйцэтгэгчид 4,180,722,899.00 /Дөрвөн тэрбум нэг зуун наян сая долоон зуун хорин хоёр мянга найман зуун өрөн ес/-төгрөгийн санхүүжилт олгосон ч гүйцэтгэл гараагүй, зээлийн хүүгийн зардалд 519,700,721.17 /таван зуун арван есөн сая долоон зуун мянга долоон зуун хорин нэг/ төгрөг тооцож, алдагдлыг өсгөсөн байна. Өмнөх оны аудитаар урьдчилгаа телсэн тооцоог баргадуулж, зээлийн хүүгийн зардлаар алдагдал нэмэгдүүлж байгаа зөрчлийг арилгахаар албан шаардлага хүргүүлсэн ч хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.6 "Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ...", 10.6.12 "Гэрээгээр хуласан үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах", 10.6.13 "Хууль тогтоомж, компанийн дүрэм, ... болон аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалт, ашиглалтад хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хууль хэлэхээс албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг арилган зөвлөх, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, телбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн ШААРДАХ нь:

3. Олгосон урьдчилгаа санхүүжилтийн хэмжээгээр гүйцэтгэлийг гаргуулж зээлийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
4. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, ерөнхий нягтлан бодогч /Б.Чинтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙ ЗӨРЧЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТАРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-[illegible]

0001081247

254

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 04 № 557/АШ/16200/1

Улаанбаатар хот

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ /Д.АЛТАНЦЭЦЭГ/

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны зориллтот түвшний хэрэгжилт хангалтгүй, ажилтан тус бүрээр гүйцэтгах ажлын төлөвлөгөө батлуулаагүй, гүйцэтгэл тайлагнаагүй, үр дүнг үнэлээгүй байхад нийт 92,400,000.00 /ерэн хоёр сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар 15.2 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: 15.2.6 байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.4 "Төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг захирлын зөвлөлөөр хэлэлцэж, ажлын үр дүнг харгалзан ажилтны болон ... ажлын тус тус үнэлж дүгнэн, шагнаж урамшуулах, ... зэрэг арга хэмжээг авна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг теслэн зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгөх"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэх, урамшуулал олгох үүрүүлэлтүүдийг тодорхой болгон, үр дүнг бодитой үнэлсний үндсэн дээр урамшуулал олгох, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллахыг Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, ерөнхий нягтлан бодогч /Б.Чинтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР — Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баруун төвийн-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264700

2 МБ/2022/01/13 ЗГАБ-30 Өмч

Төрийн аудитын байгууллага 01 2201081245 Хянасан албан тушаалтай санал дүгнэлт

255

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/42/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261729 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Аудитор: М.Ихагвасүрэн
Утас: 261729 Цахим хаяг: ikhagvasurenm@audit.gov.mn
Шинэ баланс Аудит ХХК-ийн захирал: Б.Мэндбаяр
Утас: 99032649 Цахим хаяг: info@shinebalans-audit.mn

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 10
4. АУДИТЫН ТАЙЛАН 15
4.1 Ерөнхий зүйл 15
4.2 Материаллаг байдал 15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 16
4.4.2 Бусад хуулийн хэрэгжилт ..... .15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 17
4.5.1 Завсрын аудитын талаар 17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 20
5.1 Албан шаардлага 20
5.2 Зөвлөмж 21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БХЯ	Батлан хамгаалах яам
ГВХЗ	Гадаад валютын ханшийн зөрүү
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НББББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОАТ	Орлогын албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

257

УЛСЫН АУДИТЫН ГАЗАР

"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД АЛТАНЦЭЦЭГ ГАНАД

2024 03.25 № 04/1789

Өөрчлөлттүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1.8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй мэчийн өөрчлөлт мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад аудит хийлээ

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлагдсан журам зааварын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Аудитын гол асуудал

Эдийн засгийн үндсэн үүсгүүлэгч зорилтот төвшинд үндсэн үйл ажиллагааны орлогоос 750.4 сая төгрөг, бусад орлогоос 0.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж валютын ханшийн зөрүүний олз 5,646.9 төгрөгийн хүлээн зөвшөөрч, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 1,250.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардалд 7 996.4 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны зардалд 9,497.4 сая төгрөгийг зарцуулж, 12 346.4 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөсөн байна

Хэтчилийн банкны 347 582.6 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 342 599.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ

Гүйцэтгэлээр 664.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гадаад валютын ханшийн 15 688.2 сая төгрөгийн олз хүлээн зөвшөөрч, нийт 15 917.9 сая төгрөгийг зарцуулж, 916.5 сая төгрөгийн хойшлогдсон татвар тооцож, 1 484.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна

Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 292 998.5 сая төгрөгийг зарцуулж, 85.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс дамжуулах хоолойн зураг төсөлд хянан батлагдаагүйгээс

Зайлшгүйн нөхцөлөөр ирж зөвлөх үйлчилгээний өмнөх гүйцэтгэх үндэслэлийн батлагаа ирүүлэхгүйгээс шалтгаалан бичиг баримт дутуу хэрэгсэсэн байна

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд нийт 20 удирдах 101 гүйцэтгэх, нийт 121 ажилтны орон тоо батлагдсанаас удирдах албан тушаалд 20 гүйцэтгэх албан тушаалд 76 ажилтан ажиллаж 25 орон тоо хэмнэж ажилласан байна

Компанийн жилийн үйл ажиллагаанд төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 101 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн биелэлт 75.0 хувьтай гэж тайлагнасан байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамрахгүй болно

Удирдлага болон Засагпах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагнагын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдаанаас үлмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтын тодорхойлж хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ

Терийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Терийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үлмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ аливд эсэх талаарх үндэслэлтэй батлагаажуулалт олж авах, дүгнэлт зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой

Үндэслэлтэй батлагаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний батлагаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн батлагаа болохгүй юм

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд үг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үзнэ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР [redacted] НАРАНЧИМЭГ

259

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.1.01	Менге.түүнтэй адилтгах хөрөнгө	2,150,129,083.29	2,966,920,880.95
1.1.02	Дансны авлага	34,238,973.18	97,599,059.05
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	414,077,405.11	1,076,057,768.96
1.1.04	Бусад авлага	47,520,000.00	49,405,983.03
1.1.06	Бэлэн материал	47,019,349.97	72,177,281.80
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,182,311,221.04	109,041,173,994.65
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,875,296,032.59	113,303,334,968.44
1.2.01	Үндсэн хөрөнгө	235,164,463,723.31	500,405,094,732.37
1.2.02	Биет бус хөрөнгө	9,532,588,442.53	9,512,990,500.26
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000,000.00	-
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	612,736,883.16	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	245,310,789,049.00	509,918,085,232.63
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	252,186,085,081.59	623,221,420,201.07
2.1.1.01	Дансны өглөг	-	15,172,512,741.95
2.1.1.02	Цалингийн өглөг	67,110.92	121,172.56
2.1.1.03	Татварын ер	71,634,181.49	17,066,950.00
2.1.1.04	НДШ - ийн өглөг	71,166,099.96	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	24,600,000.00	-
2.1.1.10	Бусад богино хугацаат ер төлбөр	32,187,878.00	45,954,913,887.51
2.1.1.13	Богино хугацаат ер төлбөрийн дүн	199,875,270.37	61,144,614,752.02
2.1.2.01	Урт хугацаат зээл	166,335,840,254.32	176,729,650,692.32
2.1.2.02	Ур хугацаат зээлийн хүү	62,792,827,282.59	84,340,940,682.53
2.1.2.04	Бусад урт хугацаат ер төлбөр	65,643,956,920.61	345,476,744,857.45
2.1.2.06	Урт хугацаат ер төлбөрийн дүн	294,972,624,457.52	606,547,336,232.30
2.2	Ер төлбөрийн нийт дүн	295,172,499,727.89	667,691,950,984.32
2.3.01	Өмч: - төрийн	10,000,000.00	10,000,000.00
2.3.06	Эздийн өмчийн бусад хэсэг	9,384,783,200.00	9,384,783,200.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(62,381,197,846.30)	(53,865,313,983.25)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(1,484,116,136.95)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(52,381,197,846.30)	(52,381,197,846.30)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(42,996,414,646.30)	(44,470,630,783.25)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	252,186,085,081.59	623,221,420,201.07

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	176,646,680.00	660,616,982.36
02	Борлуулалтын өртөг	62,231,172.55	877,272,181.41
03	Нийт ашиг (алдагдал)	114,315,407.45	(216,655,199.05)
08	Бусад орлого	617,036.34	3,467,028.30
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(7,543,372,076.04)	(7,430,828,492.41)
13	Гадаад валютын харшлын зөрүүний олз	3,061,881.52	15,688,216,143.84
17	Бусад алдагдал	(3,499,176,396.49)	(8,609,801,923.28)
18	Татвар төлөхийн өмнөх алдагдал	(10,924,554,147.22)	(568,600,442.60)
19	Орлогын татварын зардал	-	(918,515,694.35)
20	Татварын дараах алдагдал	(10,924,554,147.22)	(1,484,116,136.95)
22	Тайлант үеийн цэвэр алдагдал	(10,924,554,147.22)	(1,484,116,136.95)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	9,384,783,200.00	-	(41,456,643,699.08)	(32,061,860,499.08)
02	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(9,384,783,200.00)	9,384,783,200.00	-	-
03	Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	(10,924,554,147.22)	(10,924,554,147.22)
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	-	9,384,783,200.00	(52,381,197,846.30)	(42,986,414,646.30)
12	Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	(1,484,116,136.95)	(1,484,116,136.95)
17	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	-	9,384,783,200.00	(53,865,313,983.25)	(44,470,530,783.25)

261

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	161,540,515.52	497,322,299.76
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээний орлого	132,551,238.00	465,530,136.60
1.1.3	Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	203,400.00	445,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	28,785,877.52	31,347,163.16
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,981,916,170.63	5,025,950,067.12
1.2.1	Ажиллагсдад төлсөн	2,205,547,198.82	2,207,647,557.16
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	564,421,446.71	780,662,671.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	132,033,192.00	57,041,360.95
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	854,207,704.55	748,312,788.14
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	30,250,000.00	40,950,750.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	302,058,417.35	482,526,959.85
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	7,333,238.52	22,509,051.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,886,064,972.68	686,078,928.34
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,820,375,658.11)	(4,528,627,767.34)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,468,865,398.00	5,048,390,873.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	179,400,600.00	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,900,000.00	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,280,564,798.00	5,048,390,873.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,468,865,398.00)	(5,048,390,873.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,590,995,543.62	10,393,810,438.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,590,995,543.62	10,393,810,438.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,590,995,543.62	10,393,810,438.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,699,245,609.49)	816,791,797.66
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,849,374,592.78	2,150,129,083.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,150,129,083.29	2,966,920,880.95

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Х/н	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	НИЙТ ЭХ ҮҮСВЭР	мян.төг	7,705,928.0	347,083,160.0	297,007,979.0	(50,075,181.0)	85.6
	Нийт ашиг/алдагдал	мян.төг	114,315.0	(500,025.0)	(216,655.0)	283,370.0	43.3
1	Борлуулсан ажил, үйлчилгээний орлого	мян.төг	176,547.0	750,432.0	660,617.0	(89,815.0)	88.0
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	62,231.0	1,250,456.0	877,272.0	(373,184.0)	70.2
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	617.0	560.0	3,467.0	2,907.0	619.1
	Зээлээр санхүүжих	мян.төг	7,590,996.0	347,582,625.0	297,221,167.0	(50,361,458.0)	85.5
	Нийт зардал	мян.төг	7,543,372.0	7,998,376.0	7,430,826.0	(568,552.0)	92.9
	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	3,998,895.0	4,483,260.0	4,006,036.0	(477,224.0)	89.4
	Элэгдлийн зардал	мян.төг	3,544,477.0	3,513,117.0	3,424,790.0	(88,327.0)	97.5
2	ГВХЗ-ний олз	мян.төг	3,062.0	5,646,876.0	15,688,216.0	10,041,340.0	229.7
	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	3,499,176.0	9,497,438.0	8,609,802.0	(887,636.0)	90.7
	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	55,323.0	157,232.0	154,520.0	(2,712.0)	98.3
	ГВХЗ-ний бодит бус гарз	мян.төг	3,443,853.0	9,340,206.0	8,455,282.0	(884,924.0)	90.5
3	Татварын өмнөх алдагдал	мян.төг	(10,924,554.0)	(12,346,404.0)	(565,600.0)	11,780,804.0	26.6
4	ОАТ-ын зардал	мян.төг	-	-	(918,516.1)	(918,516.1)	-
5	Цэвэр алдагдал	мян.төг	(10,924,554.0)	(12,346,404.0)	(1,484,116.1)	10,862,287.9	26.6
6	Нийт ажиллагсдын тоо (үндсэн, гэрээт, ТУЗ)	хүн	95.0	121.0	96.0	(25.0)	79.3
7	Нийт цалингийн сан	мян.төг	2,728,746.0	3,087,454.0	2,713,223.0	(374,231.0)	87.9
8	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	2,394.0	2,573.0	2,355.0	(218.0)	91.5
9	Хөрөнгө оруулалт	мян.төг	3,469,885.0	342,589,341.0	292,998,476.0	(49,600,865.0)	85.5
	Нийт авлага	мян.төг	4,678,148.0	3,537,906.0	1,223,063.0	(2,314,843.0)	3,027.3
10	Дансны болон бусад авлага	мян.төг	4,216,550.0	3,031,184.0	99,485.0	(2,931,699.0)	3,510.9
	Барьцааны авлага	мян.төг	47,520.0	22,255.0	47,520.0	25,265.0	213.5

263

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Д/д	Үзүүлэлтүүд	Х/н	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	НДШ, татварын авлага	мян.төг	414,077.0	484,467.0	1,076,058.0	591,591.0	131.1
11	Нийт өглөг	мян.төг	295,172,509.0	868,484,103.0	667,691,952.0	(200,792,151.0)	76.8
	Дансны өглөг	мян.төг	64,111,883.0	591,908,028.0	390,658,342.0	(201,249,686.0)	66.0
	НДШ, Татварын өглөг	мян.төг	143,020.0	70,000.0	935,583.0	865,583.0	24.4
	Барьцааны өглөг	мян.төг	1,788,929.0	16,206,536.0	15,027,435.0	(1,179,101.0)	92.7
	Урт хугацаат зээлийн хүүгийн төлбөр	мян.төг	62,792,827.0	83,780,894.0	84,340,941.0	560,047.0	100.7
	Урт хугацаат зээл	мян.төг	166,335,840.0	176,518,645.0	176,729,651.0	211,006.0	100.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Монгол газрын тос боловсруулах үйдвэр ТӨХХК нь үндсэн зорилгоо "Дорноговь аймагт жилд 2 сая тонн хуртэл газрын тос боловсруулах хучин чадалтай, тэргүүний технологи бүхий үйлдвэрийг байгуулан, үр ашигтай ажиллуулж, компанийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх"-д оршино гэж тодорхойлжээ.

Тайлант онд газрын тос боловсруулах үйлдвэр, хотхоны бүтээн байгуулалт, газрын тосны хайгуул, судалгаа, газрын тос дамжуулах хоолой барих, хууль эрх зүйн орчныг бүдүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлэхээр 62 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан компанийн дүрэмд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 5, бусад 18 чиглэлийн үйл ажиллагаа явуулахаар тодорхойлжээ. Дараах үндсэн үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгуулах, ашиглалтад оруулах.
- Үйлдвэрийг барьж байгуулах явцад болон ашиглалтад оруулахын өмнө шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчийг гадаад улсад болон дотооддоо сургаж бэлтгэх;
- Стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, борлуулах;
- Үйлдвэрийг түүхий эдээр хангах;
- Түүхий тос дамжуулах хоолой барьж байгуулах.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хариуцлагын хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат компани гэж заасан бегеед 100 хувь төрийн өмчит компани байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийг байгуулж, компанийг дүрмийг анх УУХҮС-ын 2018 оны А/259 дүгээр тушаалаар батлаж, шинэчилсэн найруулгыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах; ..." гэсэн заалттай нийцэж байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 5 дугаар тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэй томилжээ. Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүнтэй бөгөөд 4 гишүүн нь харьаат бус гишүүн байна.

ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг 1.1 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "..цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэж байна.

265

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Терийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Засгийн Газрын 2023 оны 82 дугаар тогтоол Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн талаар авах арга хэмжээний талаар
- Засгийн Газрын 2023 оны 336 дугаар тогтоол "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн ЕРС-04 багц ажлын санхүүжилтийн талаар авах арга хэмжээний тухай
- Засгийн Газрын 2023 оны 28 дугаар тогтоол Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай
- ЗГХЭГ-ын даргын 2023 оны 70 дугаар тушаал Ажлын хэсэг байгуулах тухай
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 02 дугаар тогтоолоор компанийн дүрэмд өөрчлөлт оруулсан, 03 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг "Эрдэнэс Монгол" нэгдлийн нэгдсэн бодлого жишиг нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинчлэн тогтоох эрхийг "Эрдэнэс Монгол" ХХК шилжүүлсэн, 04 дүгээр тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосон, 05 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг сонгосон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай журмыг боловсруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах, албан шаардлага өгөв.

Дотоод хяналтын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын ажилтнаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг ахуйн суурь хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Засгийн газрын 2023 оны 82 дугаар тогтоолоор Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн терийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Эрдэнэс Монгол ХХК-ийг тогтоосон. Энэ дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны А/36 дугаар тушаалаар нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлыг "Миндуг аудит" ХХК боловсруулж байгаа хэдий ч одоогийн байдлаар дуусаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орооогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 371,035.3 сая төгрөгөөр буюу 147 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Менген хөрөнгө	2,150,129.1	2,966,920.9	816,791.8
Авлага	495,836.4	1,223,062.8	727,226.4
Урьдчилж төлсөн төлбөр	4,182,311.2	109,041,174.0	104,858,862.8
Бараа материал	47,019.3	72,177.3	25,157.9
Үндсэн хөрөнгө	235,164,463.7	500,405,094.7	265,240,631.0
Биет бус хөрөнгө	9,532,588.4	9,512,990.5	(19,597.9)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000.0	-	(1,000.0)
Хойшлогдсон татварын хөрөнгө	612,736.9	-	(612,736.9)
Нийт хөрөнгө	**252,186,085.1**	**623,221,420.2**	**371,035,335.1**
Өр төлбөр	175,275.2	61,144,614.8	60,969,339.5
Урьдчилж орсон орлого	24,600.0	-	(24,600.0)
Урт хугацаат өр төлбөр	294,972,624.5	606,547,336.2	311,574,711.8
Нийт өр төлбөр	**295,172,499.7**	**667,691,951.0**	**372,519,451.3**
Төрийн өмч	10,000.0	10,000.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	9,364,783.2	9,364,783.2	-
Хуримтлагдсан алдагдал	(52,361,197.8)	(53,865,314.0)	(1,484,116.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**252,186,085.1**	**623,221,420.2**	**371,035,335.1**

Дээрх хүснэгтээс харахад менген хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн төлбөр, үндсэн хөрөнгө, өр төлбөр материаллаг дүнгээр өссөн байна.

Менген хөрөнгө дансны үлдэгдэл 2,966.9 сая төгрөг болж 816.8 сая төгрөгөөр өссөн нь гэрээний дагуу үйл ажиллагааны санхүүжилт оны эцэст орж ирсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 727.2 сая төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлага 97.6 сая төгрөг, НӨАТ-ын авлагын 566.5 сая төгрөг, хэрэгжээгүй НӨАТ-ын авлага 441.0 сая төгрөг, НДШ-ийн 65.5 сая төгрөгийн илүү төлөлтөөс тус тус шалтгаалжээ. Компани дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд зориулан төмөр замын байгууламжийн тоног төхөөрөмжийг

267

импортоор авч, холбогдох нэмэгдсэн өртгийн албан татварыг хэрэгжээгүй НӨАТ-ын авлага дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Урьдчилгаа төлсөн төлбөр дансны үлдэгдэл 104,858.9 сая төгрөгөөр өссөн нь Норинко Интернэйшнл компанийн дамжуулах хоолойн барилгын ажлын урьдчилгаа төлбөртэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 265,240.6 сая төгрөгөөр өссөн нь дамжуулах хоолойн барилгын ажлын 301,431.1 сая төгрөгийн зардлыг дуусаагүй барилга дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 60,969.3 сая төгрөгөөр өссөн нь Дамжуулах хоолойн барилгын ажлын үлдэгдэл төлбөр 45,943.4 сая төгрөг, барьцааны өглөг 15,008.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат ер төлбөр дансны үлдэгдэл 606,547.3 сая төгрөг болж 311,574.7 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай. Үүнд:

- Монгол Улсын хөгжлийн банктай 2018 онд байгуулсан ЗГ-МГТ-3 2018-43 дугаар бүхий гэрээний дагуу 250,000.0 сая төгрөгийн зээл авахаас тайлант онд 5,179.8 сая төгрөгийн зээл авсан,
- Засгийн Газрын 2022 оны 94 дүгээр тогтоол, Эрдэнэс-Тавантолгой ХК болон Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн хооронд "Газрын тос дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажил"-ыг санхүүжүүлэх 388.1 сая ам.долларын гэрээ байгуулж, тайлант онд 81.9 сая ам.долларын гүйцэтгэлийг баталгаажуулан, 285,690.8 сая төгрөгийн зээл авсан,
- Нийт 176,729.6 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд тайлант онд 21,548.1 сая төгрөгийн зээлийн хүүгийн өглөг тооцож, бүртгэсэн байна.

3.6 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг, 13 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төсвийг тус тус баталсан байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 750.4 сая төгрөг, хүүний орлогоос 0.6 сая төгрөгийг бүрдүүлж, ханшийн зөрүүний 5,646.9 сая төгрөгийн олз хүлээн зөвшөөрч, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 1,250.5 сая төгрөгийг, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 17,493.6 сая төгрөгийг зарцуулж, 12,346.4 сая төгрөгийн алдагдалтай баталсан байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 660.6 сая төгрөг, хүүний орлогоос 3.5 сая төгрөгийг бүрдүүлж, гадаад валютын ханшийн зөрүүний олз 15,688.2 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч, 877.3 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, нийт 16,959.1 сая төгрөгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардал зардал гарган, 1,484.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 660.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 89.8 сая төгрөг буюу 12 хувиар тасарсан нь 25 орон сууц түрээслэхээр төлөвлөсөн байсан боловч гүйцэтгэлээр 21 орон сууц түрээслэснээс шалтгаалжээ.

Үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 7,430.8 сая төгрөг буюу төлөвлөснөөс 565.6 сая төгрөгийг дутуу зарцуулсан нь батлагдсан орон тооноос дутуу ажиллаж, цалингийн зардал хэмнэснээс шалтгаалсан байна.

Тайлант онд алдагдал 1,484.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 10,862.2 сая төгрөгөөр бага байгаа нь 2023 онд ам.долларын ханш буурч, 15,688.2 сая төгрөгийн валютын хэрэгжээгүй олз хүлээн зөвшөөрсөн нь нөлөөлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 5 нэр төрлийн хөрөнгө оруулалтад 342,599.3 сая төгрөгийг Хөгжлийн банкны зээлийн санхүүжүүлэгээр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, 4 нэр төрлийн ажилд 292,998.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, шилэн дансны мэдээлийг бүрэн байршуулж байх, нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар бүртгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Шинэ баланс аудит ХХК-ийн аудитор Д.Батсүх, Ш.Жавзанпагма нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер, ахлах аудитор Г.Гантуяа, захирал Б.Мэндбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитор М.Лхагвасүрэн, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/83 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүн 11,104.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 111.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш компани хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой цалин хөлс, гадаад томилолт, бичиг хэрэг, сургалт, хурал зөвлөгөөний зардал эргийг 941.1 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Үйл ажиллагааны тайланд төрийн хэмнэлтийн горим хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор дараах ажлын гүйцэтгэлийг зогсоосон гэж тайлагнасан. Үүнд:

- Хотхоны барилгын ажлын санхүүжилт шийдвэрлэгдээгүйн улмаас хотхоны бүтээн байгуулалт санхүүжилтээс шалтгаалан саатсан тул хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн худалдан авалт хойшлогдсон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар шилэн дансны системд оруулсан мэдээллийг шалгахад 145 мэдээлэл байршуулбал зохихоос 145 мэдээлэл байршуулсан ба 1 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн гэрим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзлээ.

4.4.2 Бусад хуулийн хэрэгжилт

Илрүүлэлт: Компанийн ТУЗ нь 2023 оны 6 дугаар сарын 22-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор худалдан авалтын төлөвлөгөөг 572.8 сая төгрөгөөр батлагдсан байна. Төлөвлөгөө батлах ажил удааширч, 6 дугаар сарын сүүлд батлагдсанаас шалтгаалан 363.6 сая төгрөгийн худалдан авалт он дамжин хийгдэж, дараа оны худалдан авалтын төлөвлөгөөнд нөлөөлсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал, төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", Компанийн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.3.1.5 "Компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөг батлах" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

Өөсөн зөвлөмж: Компанийн дараа жилийн үйл ажиллагааны зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг тайлант оны сүүлийн улиралд багтаан боловсруулж, төлөвлөгөөг оны эхний улиралд ТУЗ-өөр батлуулж, түүний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, менгэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, дуусаагүй барилга дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2,351.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,345.0 сая төгрөгийн 5 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснийг 62.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

төгрөгөөр/ /мянган

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	6,861.6	1	6,861.6	100
Албан шаардлага	5	2,345,001.4	3	92,400.0	66
Зөвлөмж	2	-	1	-	50
Нийт дүн	8	2,351,863.0	5	99,261.6	62

Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн Хонгорын овоо хүртэлх 27 км төмөр замаар ачаа тээвэрлэсэн нэр бүхий компаниудаас 1,732.9 сая төгрөгийн зам ашиглалтын төлбөрийг нөхөн авч төлөгдүүлээгүй зөрчилд 2021 оны аудитаар өгсөн төлбөрийн акт хэрэгжүүлэх зөрчилд өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Уг төлбөрийн актыг үндэслэлгүй гэж үзэж Монголиан транс ложистик ХХК нь Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2023 оны 2 дугаар сарын 7-ний өдөр нэхэмжлэл гаргаж, шүүхийн шатанд хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.

Хотхоны 550 айлын орон сууцны барилгын ажлын 3 туслан гүйцэтгэгчийн урьдчилгаанд 4,180.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон ч гүйцэтгэл гараагүй, зээлийн хүүний зардалд 519.4 сая төгрөг бодогдож, алдагдал өсөж байгааг зогсоох талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байгаа асуудлыг судалж компанийн гүйцэтгэх удирдлагад уг асуудлыг шуурхай шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Тус албан шаардлага хэрэгжихгүй байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

